



УЛААНБААТАР ХОТЫН ГЭР ОРОНГҮЙ ИРГЭДИЙН НӨХЦӨЛ БАЙДЛЫГ ҮНЭЛЭХ ТҮРГЭВЧИЛСЭН СУДАЛГААНЫ ТАЙЛАН

Улаанбаатар

2022

ТАЛАРХАЛ

Судалгааны бүхий л үйл явцад дэмжиж ажилласан Азийн хөгжлийн банкны Зүүн Азийн газрын Хот, нийгмийн салбарын хэлтэсийн Нийгмийн хөгжлийн ахлах мэргэжилтэн Др. Гохар Тадевосанд “Когнос интернэйшл” ХХК-ийн судалгааны хамт олон гүн талархлаа илэрхийлж байна. Түүнчлэн, судалгаанд хамрагдсан гэр оронгүй иргэд, түлхүүр ярилцлага өгөгчид, түр хоноглох байрны үйлчилгээ үзүүлж байгаа байгууллага, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллага, хамт олонд энэхүү судалгаанд идэвхитэй оролцож, хувь нэмрээ оруулсанд гүн талархлаа илэрхийлж байна.

АГУУЛГА

ТАЛАРХАЛ	2
ТОВЧИЛСОН ҮГСИЙН ТАЙЛБАР	5
ГОЛ ОЙЛГОЛТ, НЭР ТОМЬЁОНЫ ТАЙЛБАР	6
ХУРААНГУЙ	7
1. УДИРТГАЛ	16
1.1 “Гэр оронгүй байх” гэдгийг тодорхойлох нь	16
1.2 Гэр оронгүй болоход нөлөөлж буй хүчин зүйлс.....	20
1.3 Гэр оронгүй иргэдийн талаарх тоо мэдээлэл	21
2. ХУУЛЬ ЭРХЗҮЙН ОРЧИН, ОЛОН УЛСЫН ТУРШЛАГА	23
2.1 Монгол Улс дах гэр оронгүй иргэдийн талаарх эрх зүйн орчин, төрийн бодлого, үйл ажиллагаа, тоо мэдээлэл, судалгаа	23
2.2 Гэр оронгүй болохоос урьдчилан сэргийлэх, бууруулах, үгүй болгох талаарх олон улсын сайн туршлагууд	26
3. СУДАЛГААНЫ ЗОРИЛГО, АЧ ХОЛБОГДОЛ	31
3.1 Судалгааны зорилго.....	31
3.2 Судалгааны хүрээ.....	31
3.3 Судалгааны арга зүй	32
3.4 Судалгааны түүвэрлэлт, дүн шинжилгээ.....	32
3.5 Судалгааны хязгаарлагдмал байдал	36
4. УЛААНБААТАР ХОТЫН ГЭР ОРОНГҮЙ, ТЭНЭМЭЛ ИРГЭДИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ	38
4.1. Гэр оронгүй, тэнэмэл иргэдийн хүн ам зүйн шинж байдал.....	38
4.2. Гэр оронгүй, тэнэмэл иргэдийн амьдарч буй ахуйн нөхцөл.....	43
4.3. Гэр оронгүй, тэнэмэл иргэдийн эрүүл мэндийн байдал.....	49
4.4. Гэр оронгүй, тэнэмэл иргэдийн ажил эрхлэлт, орлого, амьжиргаа	53
4.5. Гэр оронгүй, тэнэмэл иргэдийн гэрээсээ дайжих болсон шалтгаан	59
4.6. Гэр оронгүй, тэнэмэл иргэдийн хамрагдаж буй үйлчилгээ	63
4.6.1. ГОТИ-д төрийн болон төрийн бус байгууллагаас үзүүлж буй үйлчилгээ, тулгамдаж буй асуудал	63
4.6.2. ГОТИ-ийн үйлчилгээ авч буй байдал.....	73
4.7. Гэр оронгүй, тэнэмэл иргэдийн нийгмийн сүлжээ, хүрээлэл, өөрийгөө үнэлэх үнэлэмж	77
4.7.1 ГОТИ-ийн нийгмийн харилцааны сүлжээ, хүрээлэл	77
4.7.2 ГОТИ-ийн өөрийгөө үнэлэх үнэлэмж	80
5. УЛААНБААТАР ХОТЫН ГЭР ОРОНГҮЙ, ЗОРИУЛАЛТЫН БУС СУУЦАНД АМЬДАРЧ БУЙ ИРГЭДИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ	84
5.1. Гэр оронгүй, зориулалтын бус сууцанд амьдарч буй иргэдийн хүн ам зүйн шинж байдал	84
5.2. Гэр оронгүй, зориулалтын бус сууцанд амьдардаг иргэдийн ахуйн нөхцөл	87
5.3. Гэр оронгүй, зориулалтын бус сууцанд амьдардаг иргэдийн эрүүл мэндийн байдал	90
5.4. Гэр оронгүй, зориулалтын бус сууцанд амьдардаг иргэдийн ажил эрхлэлт, орлого, амьжиргаа.....	92

5.5. Гэр оронгүй, зориулалтын бус сууцанд амьдарч буй иргэдийн хамрагдаж буй үйлчилгээ	94
5.6. Гэр оронгүй, зориулалтын бус сууцанд амьдардаг иргэдийн нийгмийн сүлжээ, хүрээлэл, өөрийгөө үнэлэх үнэлэмж	97
5.6.1 ГОЗБСАИ-ийн нийгмийн харилцааны сүлжээ, хүрээлэл.....	97
5.6.2 ГОЗБСАИ-ийн өөрийгөө үнэлэх үнэлэмж.....	98
6. ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТ, САНАЛ	99
6.1 Дүгнэлт.....	100
6.2. Санал, зөвлөмж	101
7. АШИГЛАСАН МАТЕРИАЛ	107
8. ХАВСРАЛТ	109
А. Судалгааны зөвлөлдөх семинарт оролцогчид (2022/02/16)	109
Б. Тоон судалгааны асуулгын хуудас	111
В. Чанарын судалгааны асуулгууд.....	121
Г. Судалгааны үр дүнгийн нэмэлт хүснэгтүүд.....	131
Д. Судалгааны багт ажилласан судлаачид	161

ТОВЧИЛСОН ҮГСИЙН ТАЙЛБАР

ҮГ	ТАЙЛБАР
АХБ	Азийн хөгжлийн банк
ГГЯ	Ганцаарчилсан гүнзгийрүүлсэн ярилцлага
ДГОХ	Дэлхийн гэр оронгүйдлийн асуудлаарх хүрээлэн
ГОТИ	Гэр оронгүй, тэнэмэл иргэд
ГОЗБСАИ	Гэр оронгүй, зориулалтын бус сууцанд амьдарч буй иргэд
ФБЯ	Фокус бүлгийн ярилцлага
НҮБ	Нэгдсэн үндэстний байгууллага
НХТТ	Нийгмийн хамгааллын тусгай төв
ОНОТХҮ	Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ
ТББ	Төрийн бус байгууллага
ТХЗ	Тогтвортой хөгжлийн зорилтууд
УБ	Улаанбаатар
ҮМХЯ	Үндсэн мэдээлэгчтэй хийх ярилцлага
ХНХЯ	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам

ГОЛ ОЙЛГОЛТ, НЭР ТОМЬЁОНЫ ТАЙЛБАР

ОЙЛГОЛТ	ТАЙЛБАР
Гэр оронгүй, тэнэмэл иргэд (ГОТИ)	Гэр оронгүй, тэнэмэл иргэд (A1 ба A2 бүлгийн иргэд).
A1 бүлэг	Төрийн болон төрийн бус байгууллагын ажиллуулдаг түр хоноглох төвүүдэд амьдарч буй гэр оронгүй тэнэмэл иргэд
A2 бүлэг	Гудамж, орц, гадуур хэсүүчлэн хоноглож буй гэр оронгүй тэнэмэл иргэд.
Гэр оронгүй, зориулалтын бус сууцанд амьдарч буй иргэд (ГОЗБСАИ)	Орон сууцны орц, хонгил зэрэг зориулалтын бус сууцанд амьдарч буй гэр оронгүй иргэд (Б бүлгийн иргэд).
Б бүлэг	Орон сууцны орц, хонгил зэрэг зориулалтын бус сууцанд байрлан амьдарч буй гэр оронгүй иргэд.
Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ	Иргэн, аж ахуйн нэгж, төрийн болон төрийн бус байгууллагын оролцоотойгоор өрх, иргэнд дэмжлэг туслалцаа, үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагаа (ОНОТХҮ).
Түр хоноглох төв	Гэр оронгүй, тэнэмэл иргэдэд зориулсан төрийн болон төрийн бус байгууллагын санхүүжилтэйгээр үйл ажиллагаа явуулдаг түр хоноглох төвүүд.
Шилжин ирэгч	Төрсөн аймаг/хот нь Улаанбаатараас өөр бол шилжигч гэж үзсэн.

ХУРААНГУЙ

Энэхүү судалгаагаар Улаанбаатар хотын гэр оронгүй, тэнэмэл амьдралтай иргэдийн амьдралын нөхцөл байдал, хэрэгцээнд түргэвчилсэн байдлаар судалгаа хийлээ. Мөн орон сууцны орц, хонгил зэрэг зориулалтын бус сууцанд амьдарч буй гэр оронгүй иргэдийн хувьд тэднийг гэр оронгүй иргэд гэж томьёолох хууль эрх зүйн баримт бичиг Монгол улсад одоогоор байхгүй ч олон улсын ойлголт, тодорхойлолт болон судалгааны хүрээ тодорхойлох уулзалтын үеэр талуудын тавьсан хүсэлтийн дагуу энэхүү судалгаанд тодорхой төлөөллийг хамруулан судалсан. Судалгааг хоёрдогч тоо баримт мэдээлэл, олон улсын сайн туршлагыг судлах, гэр оронгүй иргэд ба тэдэнтэй ажилладаг мэргэжилтнүүдээс тоон, чанарын судалгааны аргаар мэдээлэл цуглуулж шинжлэх замаар гүйцэтгэсэн. Судалгааны мэдээлэл цуглуулалтын ажил 2022 оны 2 сарын 20-ноос 4 сарын 20-ны өдрүүдэд явагдаж, 405 гэр оронгүй, тэнэмэл иргэд, 200 гэр оронгүй, зориулалтын бус сууцанд амьдарч буй иргэдээс анкетын аргаар судалгаа авсан. Түүнчлэн, төрийн болон төрийн бус байгууллага, олон улсын байгууллага, тэнэмэл иргэдийн ар гэрийн төлөөлөл болсон 26 хүнтэй үндсэн мэдээлэгчийн ярилцлага, гэр оронгүй, тэнэмэл 37 хүнийг хамруулсан 7 фокус бүлгийн ярилцлага, 29 ганцаарчилсан гүнзгийрүүлсэн ярилцлагыг гэр оронгүй, тэнэмэл иргэдтэй хийж, дүн шинжилгээ хийн тайлангаа боловсрууллаа. Судалгаагаар дараах гол үр дүнгүүд гарсан. Үүнд:

Гэр оронгүй, тэнэмэл иргэд (ГОТИ) -ийн хувьд:

- **Хүн ам зүйн шинжийн хувьд**, ГОТИ иргэдийн дийлэнх 25-49 буюу ид хөдөлмөрийн насны, эрэгтэй хүмүүс байна. Мөн гэр оронгүй иргэдийн боловсрол улсын дундаж хүн амынхаас доогуур, гэр бүлийн хувьд гэрлэлтээ цуцлуулсан, огт гэрлээгүй, бэлэвсэн, ихэнх нь хүүхэдтэй хүмүүс байна. Гэр оронгүй аль ч бүлгийн иргэд дунд нийслэлийн унаган иргэдтэй харьцуулахад орон нутгаас шилжин ирэгчид их байна.
- **Ахуйн нөхцлийн хувьд**, гэр оронгүй иргэд харьцангуй урт хугацаанд (ГОТИ дунджаар 9.8 жил тогтсон гэр оронгүй амьдарч байна. ГОТИ-ийн дунд 10 хүн тутмын 4 нь урьд өмнө өөрийн гэсэн гэр оронгүй, хамаатан/найзындаа, түрээсийн байр/гэрт байсан, эсхүл засан хүмүүжүүлэх болон асрамжийн газраас гарсан иргэд байна. ГОТИ дулааны үед ихэвчлэн гудамж, зуслан, ой мод, голын эрэг, орон сууцны орц, хонгил зэрэгт, харин хүйтний үед ТББ, сүм хийд, улсын байгууллагын ажиллуулдаг түр хоноглуулах төвүүдэд хоноглож байна. ГОТИ тогтвортой ундны усны эх үүсвэргүй, ихэвчлэн айл, байгууллага, нийтийн ус түгээх байр, орон сууц, хонгилийн төвлөрсөн шугам зэрэг олон эх үүсвэрээс гуйх замаар усны хэрэгцээгээ хангаж байна. Түр хоноглуулах байранд байгаа иргэд 7 хоногийн өдөр бүр халуун хоол идсэн, зориулалтын бие засах газарт орсон, гараа савандаж угаасан, бүтэн нойртой хоносон байхад гадуур хоноглодог тэнэмэл иргэдийн хувьд уг тоонууд 2 ч хүрэхгүй байгаа нь тэдний хувьд ахуйн нөхцлийн асуудал маш хүнд байгааг харуулж байна.

- **Эрүүл мэндийн хувьд**, ГОТИ-ийн 74.8 хувь нь биедээ ямар нэг өвчин, зовиуртай ба аль аль бүлгийнхний дунд зүрх судасны эрхтэн тогтолцоо, үе мөчний төрлийн өвчлөл хамгийн түгээмэл байна. Хөгжлийн бэрхшээлд өртсөн түвшин ГОТИ-ийн дунд 27.9 хувь байгаа нь улсын дундаж үзүүлэлтээс 9 дахин өндөр байна. Мөн КОВИД-19-өөр өвчилсөн түвшин ГОТИ-ийн дунд 11.6 хувь байсан. ГОТИ-ийн 18.3 хувь нь өвдсөн ч эмнэлэгт очдоггүй ба ГОТИ эрүүл мэндийн үйлчилгээ авахад бичиг баримтгүй, даатгалгүй, гадуурхалд өртдөг зэрэг бэрхшээл үүнд нөлөөлдөг байна.
- **Ажил эрхлэлт, орлого, амьжиргааны байдлын хувьд**, ГОТИ-ийн 35.6 хувь ажиллаж орлого олсон боловч ихэвчлэн албан бус салбарт ажиллаж байна. Ажилгүй ГОТИ-ийн ажилгүй байгаа хамгийн түгээмэл шалтгаан нь архины донтолт байна. Ажил эрхэлсэн түр хоноглох байрны ГОТИ-ийн сарын дундаж орлого 475.4 мянга, гадуур хоноглож буй ГОТИ-ийнх 281.7 мянга байгаа нь улсын дунджаарх ажил эрхэлж буй иргэдийн орлогоос 3.0-5.1 дахин бага байна. Түр хоноглуулах байрууд гэр оронгүй иргэдийг хүйтний улиралд олноор нь хүлээн авч, хоол, гутал хувцас, унтаж амрах зэрэг анхдагч хэрэгцээг хангахад чухал үүрэг гүйцэтгэж байна. Гэвч гадуур хоноглож буй ГОТИ тогтворгүй орлого, хаягдал, ТББ, сүм, олон улсын байгууллагуудаас олгодог үнэгүй хоол, хувцсаар анхдагч хэрэгцээгээ хангаж байна. Үүнээс гадна ГОТИ-ийн дунд архинд донтох байдал маш өндөр тул олсон мөнгөөрөө хоол бус, архи авч хэрэглэх нь элбэг байна.
- **Гэрээсээ дайжсан/орон гэргүй болсон шалтгааны хувьд**, олон хүчин зүйлээс үүдэлтэй ч ГОТИ-ийн хувьд архины хэт их хэрэглээ гэсэн шалтгаан зонхилж байна. ГОТИ-ийг тэнэмэл амьдралын замд ороход нөлөөлсөн хүчин зүйлсэд “эрх мэдэлтнийг эсэргүүцэх” зан төлөв, гэр бүл дэх бие махбодийн болон сэтгэл санааны гэх мэт төрөл бүрийн хүчирхийлэл, гэр бүлийн хүрээний хэт хайр халамжаас үүдэлтэй бэрхшээлийг даван туулах чадвар муу байдал, “ойр дотныхонтой харилцаа холбоо тасрах” байдал зэрэг багтаж байна. Мөн нийгэм, эдийн засгийн хөгжлийн доогуур байдал, орон нутгийн төсвийн хүрэлцээгүй байдал зэрэг бүтцийн хүчин зүйлс ч ГОТИ-ийг гэр оронгүй амьдралд орохоос сэргийлэх, уг байдлаас гаргахад чиглэсэн үйлчилгээний чанарт сөргөөр нөлөөлж байна.
- **ГОТИ-дэд төрөөс үзүүлдэг үйлчилгээний хувьд**, НЗД-ын захирамжийн дагуу ГОТИ-ийг жил бүр 1-3 удаа, хүйтний улиралд илрүүлж түр хоноглуулах төвүүдэд байршуулах ажлыг зохион байгуулдаг ч энэ нь “түр гал унтраах” арга хэмжээ төдий байна. Төрийн, төрийн бус байгууллагын үзүүлдэг түр хоноглуулах байрны үйлчилгээнүүд хугацаа, санхүүжилтийн эх үүсвэрийн хувьд ялгаатай, нэгдсэн удирдлага, зохион байгуулалтгүй, үйлчилгээний төрөл цөөн байна. Улсын хэмжээнд бичиг баримтгүй нийгмийн эмзэг бүлэгт эмнэлгийн тусламж, үйлчилгээ хүргэх зорилго бүхий ганцхан эмнэлэг үйл ажиллагаа явуулж байна.
- **Нийгмийн сүүр үйлчилгээнд хамрагдах байдлын хувьд**, ГОТИ-ийн бараг тал хувь иргэний үнэмлэхгүй байгаа ба энэ байдал түр хоноглуулах төвөөс гадуур байгаа, орон нутгаас шилжин ирсэн, боловсрол доогуур ГОТИ-ийн дунд өндөр,

улмаар нийгмийн суурь үйлчилгээг хүртэх боломжгүй байна. Эрүүл мэндийн даатгалд хамрагдалт ГОТИ-ийн дунд гуравны нэг, нийгмийн даатгалд хамрагдалт 7.9 хувь байгаа ба эдгээрийн гол шалтгаан нь орлого хангалтгүй байдал юм. ГОТИ-ийн дунд 5 хүн тутмын 1 нь төрөөс тэтгэвэр, тэтгэмж авч байна. ГОТИ-ийн нэн түрүүнд шийдвэрлэхийг хүсч байгаа асуудал нь өөрийн орон байртай болох, ажил/орлоготой болох, бичиг баримттай болох зэрэг байна.

- **Нийгмийн сүлжээ, хүрээллийн хувьд**, ГОТИ-ийн дийлэнх гэр оронгүй найз, танилуудтайгаа хүрээлэл үүсгэн амьдарч байна. ГОТИ-ийн 49.4 хувь нь гэр бүлийнхэнтэйгээ уулзах хүсэлтэй ч хүссэн үедээ уулзаж чаддаггүй ба бусдаас тусламж авах хэрэгцээ гарахад эхнэр/нөхөр/хүүхдээс илүүтэйгээр аав, ээж, ах, эгч дүү, түр хоноглуулах төвийн ажилчдад ханддаг байна. Хамгийн их тусалдаг, өөрт нь ойр дотно санагддаг хүнээр ГОТИ ах, эгч, дүү (27.9 хувь) болон асрах/түр хоноглуулах төвийн ажилчид (20.7 хувь)-ыг нэрлэсэн ч эдгээр нь хариулагчдын тал хувьд ч хүрэхгүй байна. Нийгмийн сүлжээ муутай байгаагаас ГОТИ ганцаардах, нийгмээс тусгаарлагдах, өөртөө итгэлгүй болох хандлага байна.
- **Сэтгэл зүйн байдлын хувьд**, ГОТИ-ийн талаас илүү хувь нь санаа зовсон, тогтворгүй үетэй элбэг тохиолддог, архины хамааралтай байна. Өөрийгөө үнэлэх үнэлэмжид “сайн” үнэлгээ өгсөн байдал ГОТИ-ийн дунд 56.1-ээс дээш хувьтай байна. Ихэнх ГОТИ өөрсдийн ур чадвар, сэтгэл зүйн байдлыг харьцангуй сайнаар үнэлж байгаа ч архины хамаарал, сөрөг зуршил, зан үйлийн сөрөг үйлдлүүд нь эргээд гэр бүл, үр хүүхэд, нийгэмд эзлэх байр сууриа алдах, сэтгэл зүйн хүнд нөхцөлд оруулдаг гэдгийг хүлээн зөвшөөрч байна.

Гэр оронгүй, зориулалтын бус сууцанд амьдарч буй иргэд (ГОЗБСАИ)-ийн хувьд:

- **Хүн ам зүйн шинжийн хувьд**, ГОЗБСАИ-ийн дийлэнх нь 45-аас дээш насны, эмэгтэйчүүд байна. Мөн тэдний дунд нийслэлийн унаган иргэдтэй харьцуулахад орон нутгаас шилжин ирэгчид их байна.
- **Ахуйн нөхцлийн хувьд**, ГОЗБСАИ-ийн дунд 10 хүн тутмын 5 нь урьд өмнө өөрийн гэсэн гэр оронгүй, хамаатан/найзындаа, түрээсийн байр/гэрт байсан, эсхүл засан хүмүүжүүлэх болон асрамжийн газраас гарсан иргэд байна. ГОЗБСАИ жилийн ихэнх хугацаанд орон сууцны орцны хэсэг, хонгилд амьдарч байна. ГОЗБСАИ-ийн дийлэнх нь дулааны ба хүйтний улиралд төвлөрсөн шугамаас ундны усаа зөөвөрлөн авдаг.
- **Эрүүл мэндийн хувьд**, ГОЗБСАИ-ийн 65.5 хувь нь нь биедээ ямар нэг өвчин, зовиуртай ба аль аль бүлгийнхний дунд зүрх судасны эрхтэн тогтолцоо, үе мөчний төрлийн өвчлөл хамгийн түгээмэл байна. Хөгжлийн бэрхшээлд өртсөн түвшин ГОЗБСАИ-ийн дунд 12 хувь байгаа нь улсын дундаж үзүүлэлтээс 4 дахин өндөр байна. КОВИД-19-өөр өвчилсөн түвшин ГОЗБСАИ-ийн хувьд 22 хувь байлаа.

ГОЗБСАИ-ийн 18.5 хувь нь өвдсөн ч эмнэлэгт очдоггүй ба хаягийн бүртгэлгүй, бичиг баримтгүй, гадуурхалд өртдөг зэрэг саад бэрхшээл үүнд нөлөөлдөг байна.

- **Ажил эрхлэлт, орлого, амьжиргааны байдлын хувьд**, ГОЗБСАИ-ийн дунд архианаас хамааралтай ажилгүйдэл бараг байхгүй байна. Албан салбарт ажиллаж, мөнгөн хэлбэрээр цалинжсан ГОЗБСАИ-ийнх 495 мянган төгрөг байгаа нь Монгол Улсын хөдөлмөр эрхэлж буй хүн амын дундаж цалингаас 2.8 дахин доогуур байна. ГОЗБСАИ-ийн дийлэнх анхдагч хэрэгцээгээ хөдөлмөрийн орлогоосоо хангаж байна.
- **Гэрээсээ дайжсан/орон гэргүй болсон шалтгааны хувьд**, ГОЗБСАИ-ийн хувьд орон нутгаас шилжин ирээд байр/газар олдоогүй, хангалттай орлогогүй гэсэн шалтгаан зонхилж байна. Мөн нийгэм, эдийн засгийн хөгжлийн доогуур байдал, орон нутгийн төсвийн хүрээлцээгүй байдал зэрэг бүтцийн хүчин зүйлс ч ГОЗБСАИ-ийг гэр оронгүй амьдралд орохоос сэргийлэх, уг байдлаас гаргахад чиглэсэн үйлчилгээний чанарт сөргөөр нөлөөлж байна.
- **Нийгмийн сүүр үйлчилгээнд хамрагдах байдлын хувьд**, ГОЗБСАИ-ийн дийлэнх нь иргэний үнэмлэхтэй байгаа ч хаягийн бүртгэлгүй асуудал элбэг байна. Эрүүл мэндийн даатгалд хамрагдалт ГОЗБСАИ-ийн дунд 60 хувь, нийгмийн даатгалд хамрагдалт 35 хувь байгаа ба эдгээрийн гол шалтгаан нь орлого хангалтгүй байдал юм. ГОЗБСАИ-ийн дунд 5 хүн тутмын 2 нь төрөөс тэтгэвэр, тэтгэмж авч байна. ГОЗБСАИ-ийн хувьд нэн түрүүнд шийдвэрлэхийг хүсч байгаа асуудал нь өөрийн орон байртай болох, хүүхдүүдийнхээ ирээдүйд санаа зовдог, орлогоо нэмэгдүүлэх зэрэг болж байна.
- **Нийгмийн сүлжээ, хүрээллийн хувьд**, ГОЗБСАИ-ийн дийлэнх нь гэр бүл, хамаатантайгаа хамт амьдарч байна. ГОЗБСАИ-ийн хувьд бусдаас тусламж авах хэрэгцээ гарахад аав, ээж, ах, эгч, дүү, гэр бүл, ажлын хамт олондоо ханддаг байна.
- **Сэтгэл зүйн байдлын хувьд**, ГОЗБСАИ-ийн дунд архины хамаарлын асуудал ховор байна. Өөрийгөө үнэлэх үнэлэмжид “сайн” үнэлгээ өгсөн байдал ГОЗБСАИ-ийн хувьд 57.5 хувиас дээш хувьтай өндөр байна.

Санал, зөвлөмж

Судалгааны үр дүн, гэр оронгүй иргэдтэй ажиллах олон улсын сайн туршлагууд, мэргэжилтнүүдтэй хийсэн зөвлөлдөх уулзалтуудаас гарсан санал, зөвлөмжид үндэслэн гэр оронгүй иргэдийн тулгамдсан асуудлыг шийдэх чиглэлээр хэрэгжүүлбэл оновчтой хэмээн дараах бодлого, үйл ажиллагааны саналуудыг дэвшүүлж байна.

I. Гэр оронгүй, тэнэмэл иргэдэд (ГОТИ) чиглэсэн бодлого, үйл ажиллагааны зөвлөмж, санал:

Зөвлөмж, санал	Хэрэгжүүлж эхлэх хугацаа		
	Богино хугацаа (2 жил дотор)-нд:	Дунд хугацаа (2.1-5 жилд)-нд:	Урт хугацаа (5-аас дээш жилийн дараа)-нд:
1. Гэр оронгүй тэнэмэл иргэдтэй холбоотой эрх зүйн орчинг боловсронгуй болгох:			
1.1 Байгалийн гамшиг, нийтийг хамарсан халдварт өвчин тархах эрсдэлтэй үед гэр оронгүй иргэд рүү онцгойлон чиглэсэн зарим хамгааллын арга хэмжээг гамшгийн үед төрөөс хэрэгжүүлдэг бодлого, үйл ажиллагааны баримт, бичгүүдэд тусган хэрэгжүүлдэг болох. Тухайлбал, бичиг баримтгүй, банкны дансгүй ГОТИ-дийг тусгайлан анхаарах.	+		
1.2 Нийгмийн халамжийн тухай хуулийн шинэчилсэн найруулгад гэр оронгүй, тэнэмэл иргэдийн асуудлаар тусгайлан бүлэг оруулах	+		
1.3 Гэр оронгүй, тэнэмэл амьдрал руу орохоос урьдчилан сэргийлэх болон бусад арга хэмжээний талаар стратеги, бодлого, хууль боловсруулж, хэрэгжүүлэх		+	
2. Гэр оронгүй тэнэмэл иргэдтэй холбоотой бодлого, зохицуулалтыг боловсронгуй болгох:			
2.1 ГОТИ-дэд үйлчилгээ үзүүлж буй салбарууд хоорондын үйл ажиллагааг уялдуулахын тулд нэгдсэн зохицуулалт хийх чиг үүрэг бүхий байгууллага/ нэгжийг тодорхой болгох, засгийн газар бүхлээрээ хамтран ажиллах (whole of government approach)		+	
2.2 Магадлан итгэмжлэгдсэн ТББ-аас ГОТИ-д үйлчилгээ үзүүлэхэд олгодог урсгал зардлын дэмжлэгийг жилийн 4 улиралд олгох	+		
2.3 Түр хоноглох байрууд ГОТИ-ийг байрлах хугацаанд нь газар тариалан, нийгэд тустай хөдөлмөр эрхлүүлэх зэргээр ажил мэргэжлийн дадал олж авах үйл ажиллагаануудын санаачлагыг төрөөс бодлогоор дэмжих, энэ чиглэлд тогтвортой ажлын байр бий болгох төр, иргэний нийгмийн байгууллага, хувийн хэвшлийг татварын урамшуулал болон бодлогоор дэмжих	+		
2.4 ГОТИ-ийн асуудлаар ажилладаг судалгааны болон бодлогын түвшинд ажилладаг олон улсын байгууллагуудтай хамтын ажиллагааг эхлүүлэх, туршлага судлах. Тухайлбал Дэлхийн гэр оронгүйдлийн асуудлаарх хүрээлэн (Institute of Global Homelessness)	+		
2.5 Төрийн болон төрийн бус байгууллагаар дамжиж, үйлчилгээ авч бие даасан амьдралд шилжихэд бэлэн болсон ГОТИ-дэд хашаа газар, гэр оронтой болгох чиглэлээр тусгайлсан хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх. Тухайлбал: түрээсийн төлбөр бага, огт төлбөргүй улсын орон сууц, орон		+	

сууцны ваучер, хашаа газар олгох гэх мэт хөтөлбөрүүдийг судалж, хэрэгжүүлэх, “Гэртээ харих зам”-тай төстэй төсөл/хөтөлбөр санаачлан хэрэгжүүлэх.			
2.6 Төрийн болон төрийн бус байгууллагаар дамжиж, үйлчилгээ авч бие даасан амьдралд шилжсэн иргэдийг бие даан амьдрахад нь үргэлжлүүлэн дэмжих хөтөлбөрт хамруулах. Үүнтэй холбоотой бие даан амьдрах хөтөлбөр гаргаж хэрэгжүүлэх. Жишээ нь сэтгэл зүйч, нийгмийн ажилтан, наркологийн эмч зэрэг мэргэжлийн хүмүүсээс бүрдсэн баг бие даасан амьдралтай болсон иргэдтэй үргэлжлүүлэн ажилладаг, хяналт тавьдаг байх		+	
2.7 Ахмадын асрамж, халамж, сэтгэцийн асуудалтай иргэдийг хүлээн авдаг байгуулалагуудад гэр оронгүй иргэдийг шилжүүлэх тохиолдолд үйлчилгээ үзүүлж буй төрийн, төрийн бус байгууллагын мэргэжилтнүүдийн нөхцөл байдлын үнэлгээ, тодорхойлолтыг үндэслэн хүндрэл чирэгдэлгүй хялбар шилжүүлэх боломжтой процесс бий болгох.	+		
2.8 ГОТИ-тэй ажилладаг албан хаагчдын тогтвор суурьшилтай ажиллах нөхцлийг бүрдүүлэхийн тулд төрөөс хүнд нөхцөлд ажилласны нэмэгдэл цалин олгох, бие, сэтгэл зүйн эрүүл мэндийг дэмжих, хөнгөлөлттэй нөхцлийн орон сууцны хөтөлбөрт хамруулах, мэргэжил дээшлүүлэх хөтөлбөрт хамруулах, туршлага судлах гадаад дотоодын аялалд хамруулах гэх мэтээр амьдралын баталгааг дэмжсэн хөтөлбөр хэрэгжүүлэх.	+		
2.9 ГОТИ-ийн асуудлын талаар орон нутагт үүрэг өгөх, орон нутгийн төсөвт суулгах	+		
3. Гэр оронгүй тэнэмэл иргэдийн статистик, мэдээллийг сайжруулах:			
3.1 Гэр оронгүй, тэнэмэл иргэдийн тоо мэдээллийг албан ёсны статистикаар гаргадаг тогтолцоо бүрдүүлж, мэдээллэдэг болох, салбар дундын нэгдсэн мэдээллийн сантай болох		+	
3.2 Гэр оронгүй иргэдийн судалгааны ажлыг олон улсын тодорхойлолт, жишиг болохуйц стандартад нийцүүлэн, жишээлбэл “тухайн цаг мөч”-ид (point-in-time) буюу нэг шөнийн дотор тоолох судалгааны аргаар, тогтмол давтамжтайгаар төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллагуудын оролцоотойгоор зохион байгуулдаг болох; сэдэвчилсэн судалгаанууд хийх, тухайлбал ГОТИ-ийн дундаж наслалтын талаар.		+	
3.3 “Тухайн цаг мөч”-ийн судалгаанд судалгааны арга зүйгээр сургалтад хамрагдсан судлаачдыг сайн дурын үндсэн дээр оролцуулах замаар судалгааны хамрагдалт, мэдээллийн үнэн зөв байдал, чанарыг сайжруулах		+	
4. Иргэдийг гэр оронгүй тэнэмэл амьдралд орохоос урьдчилан сэргийлэх:			
4.1 Асрамжийн газар болон засан хүмүүжүүлэх газраас гарч буй иргэдийг нийгэмд бие даан амьдрахаар гарах үед гэр орон зэрэг суурь хэрэгцээгээ хангахад нь анхаарсан хөтөлбөр, төсөл санаачлан, хэрэгжүүлэх, гэр орон олгох	+		
4.2 Шилжин ирэгчдэд зориулсан үндсэн хэрэгцээгээ хангах, дасан зохицоход нь туслах чиглэлээр хэрэгжүүлдэг төсөл хөтөлбөрүүдийн талаар иргэдэд мэдлэг, мэдээлэл олгох, төслүүдийн үйл ажиллагааг өргөжүүлэх	+		

4.3 Орон нутгаас шилжин ирж буй бүртгэлгүй, ажилгүй, өрх тойлгойлсон, гэх мэт эмзэг бүлгийн иргэдийг олон нийт, нийгмийн ажилтнуудаар дамжуулан илрүүлэх, шилжин суурьшигчдад зориулсан тусгай хөтөлбөр/арга хэмжээнд хамруулах	+		
4.4 Орон гэргүй болоход нөлөөлж байгаа хувь хүн, гэр бүл, нийгмийн түвшний эрсдэлт хүчин зүйлсийг арилгах, таслан зогсооход чиглэсэн хариу арга хэмжээ интервенцийг хэрэгжүүлэх чадавхи, нөөцийг бий болгох, эко системийг өөрчлөх, илүү иргэдэд ээлтэй болгон сайжруулах. Жишээ нь, Гэр оронгүй амьдрах болсон шалтгаанууд дунд ойр дотны хүн нас барсан, туслах хүн байхгүй, ял шийтгэл эдэлж байсан тул гадуурхагдсан зэрэг асуудлууд байгаа тул нийгмийн хамгаалал, халамжийн чиглэлээр ажиллагчид эн тэргүүнд мэргэжлийн үүднээс анзааран, олж харж, зохих шатны арга хэмжээнүүд цаашид хэрэгжүүлдэг болох	+		
5. Гэр оронгүйдлийн асуудлаас урдчилан сэргийлэх болон ГОТИ-ийн нөхцөл байдлыг олон нийтэд ойлгуулах, гэр оронгүй иргэдтэй ажиллахад олон нийтийн оролцоог бий болгох :			
5.1 ГОТИ амьдралд орохоос урьдчилан сэргийлэх, сэрэмжлүүлэх, ГОТИ-ийн нөхцөл байдлыг таниулах агуулга бүхий мэдээллийн контентуудыг олон нийтэд хүргэх гэр оронгүй иргэдтэй ажиллахад олон нийтийн оролцоог бий болгох	+		
6. Гэр оронгүй, тэнэмэл иргэдэд үзүүлж буй одоогийн үйлчилгээг сайжруулах, өргөжүүлэх:			
6.1 ГОТИ-ийн илрүүлэг, түр хоноглох төвүүдийн үйл ажиллагааг тогтмолжуулах, шаардлагатай хүний нөөц, санхүүг шийдвэрлэх, ялангуяа сургалт, сэтгэл зүйн зөвлөгөө, сэтгэл засал, нийгэмшүүлэх чиглэлийн зардал байхгүй байгааг анхаарч нэмэгдүүлэх	+		
6.2 Нийгмийн ажилтан, сэтгэл зүйч, сайн дурынхан, нийгмийн үйлчилгээний хувийн хэвшлийнхний хамтарсан багийн үйлчилгээг стандартчилж, эдгээр хүмүүсийн зан үйл, дадал хэвшлийг өөрчлөхүйц үйлчилгээг мэргэжлийн түвшинд сайжруулах	+		
6.3 Хувь хүний үүрэг хариуцлага, амьдралын зорилго, итгэл найдварыг бий болгоход чиглэсэн сургалтын хөтөлбөрийг түр хамгаалах байрны хөгжлийн үйлчилгээний стандарт үйлчилгээ болгох	+		
6.4 Түр хоноглох байрууд зайлшгүй эмч, эрүүл мэндийн ажилтантай байх, ГОТИ-дэд эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, үйлчилгээг улирлын давтамжтай тогтмол хийх			
6.5 ГОТИ-дэд сэтгэл зүйн дэмжлэг, урт хугацааны хөтөлбөрийг хэрэгжүүлэхдээ стационар эмчилгээтэй хослуулах	+		
6.6 Түр хоноглох төвүүдэд очсон ГОТИ-дэд архинд донтох өвчний эмчилгээ, сэтгэц, сэтгэл заслын эмчийн зөвлөгөө сургалтыг тогтмол явуулах, энэ талын үйлчилгээг чанаржуулах, сэтгэл зүйч, сэтгэцийн эмч нарыг хүртээмжтэйгээр ажиллуулах.	+		
6.7 Архины хамааралтай, сэтгэц/сэтгэл зүйн өөрчлөлттэй иргэдтэй ажилладаг тул гэр оронгүй иргэдтэй ажилладаг албан хаагчдын ажилдаа ирж очих, ажлын байран дээрх аюулгүй байдлыг сайжруулахад чиглэсэн бодлого/үйл ажиллагаа хэрэгжүүлэх, журам гаргах.	+		

6.8 Түр хоноглох байрууд ГОТИ-ийг байрлах хугацаанд нь газар тариалан, нийтэд тустай хөдөлмөр эрхлүүлэх зэргээр ажил мэргэжлийн дадал олж авах, зах зээлд чиглэсэн үйлдвэрлэлд оролцуулах үйл ажиллагаануудыг санаачлан хэрэгжүүлэх.	+		
--	---	--	--

II. Гэр оронгүй, зориулалтын бус сууцанд амьдарч буй иргэдэд (ГОЗБСАИ) чиглэсэн бодлого, үйл ажиллагааны зөвлөмж, санал

Зөвлөмж, санал	Хэрэгжүүлж эхлэх хугацаа		
	Богино хугацаа (2 жил дотор)-нд:	Дунд хугацаа (2.1-5 жилд)-нд:	Урт хугацаа (5-аас дээш жилийн дараа)-нд:
1. ГОЗБСАИ-тэй холбоотой бодлого, зохицуулалтыг боловсронгуй болгох:			
1.1 ГОЗБСАИ-дийг хашаа газар, гэр оронтой болгох чиглэлээр тусгайлсан хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх. Тухайлбал: төвлөрсөн орон сууцуудыг барьж, ваучер болон бага түрээсээр гэр оронтой болгох, мөн огт төлбөргүй улсын орон сууц, хашаа газар олгох гэх мэт хөтөлбөрүүдийг судалж, хэрэгжүүлэх			+
1.2 ГОЗБСАИ-дийн дунд архины хамааралгүй, ажлаа хийгээд амьдарч байгаа иргэд дийлэнхийг эзэлж буй тул тэдний дунд “Эн тэргүүнд гэр орноор хангах” загварыг хэрэгжүүлэх		+	
1.3 Бодлого боловсруулагчид, хууль тогтоогчдын гэр оронгүй, гудамжинд гарах эрсдэлд байгаа ГОЗБСАИ-ийн асуудлуудын талаарх мэдээллийг нэмэгдүүлэх, асуудлыг шийдвэрлэх улс төрийн хүсэл, эрмэлзлийг бий болгох, сонгуулийн мөрийн хөтөлбөртэй нь уялдуулах	+		
1.4 Иргэдийг орон сууцжуулах бодлогод гэр оронгүй болох эрсдэлтэй бүлгийн хүн амд чиглэсэн эрсдэлээс сэргийлэх тодорхой заалтууд оруулах. Тухайлбал, орон нутгаас шилжин ирсэн, орцны жижүүр хийдэг зэрэг бүлгийг онцгойлон анхаарах.		+	
2. Зориулалтын бус сууцанд амьдардаг иргэдийн статистик, мэдээллийг сайжруулах			
2.1 Зориулалтын бус сууцанд амьдарч байгаа иргэдийн тоо мэдээллийг албан статистикаар, дотор нь төрлөөр нь ангилж гаргадаг тогтолцоо бүрдүүлэх	+		

2.2 Зориулалтын бус сууцанд амьдарч байгаа иргэдийг хамруулсан үндэсний хэмжээнд төлөөлөхүйц түүвэртэй судалгааны ажлыг явуулж, бодлого боловсруулалт, шийдвэр гаргалтад ашиглах.	+		
3. Зориулалтын бус сууцанд амьдарч буй иргэдийн нөхцөл байдал дордохоос урьдчилан сэргийлэх:			
3.1 Орц, хонгилд амьдарч буй иргэдийн ихэнх нь орон нутгаас шилжин ирэгчид байгаа тул нэгэн шилжин ирсэн иргэдэд зориулсан үндсэн хэрэгцээгээ хангах, дасан зохицоход нь туслах чиглэлээр хэрэгжүүлдэг төсөл хөтөлбөрүүдийн талаар иргэдэд мэдлэг, мэдээлэл олгох, төслүүдийн үйл ажиллагааг өргөжүүлэх	+		
3.2 Орон нутгаас шилжин ирж буй бүртгэлгүй, ажилгүй, өрх тойлгойлсон, гэх мэт эмзэг бүлгийн иргэдийг олон нийт, хороодын нийгмийн ажилтнуудаар дамжуулан илрүүлэх, нэгэнт шилжин ирсэн суурьшигчдад зориулсан тусгай хөтөлбөр/арга хэмжээнд хамруулах	+		
3.3 ГОЗБСАИ-ийн, ялангуяа орцны жижүүр иргэдийн цалингийн хэмжээг нэмэгдүүлж, нийгмийн даатгал, эрүүл мэндийн даатгалдхамрагдалтын байдлыг төрийн татаасаар зохицуулж, сайжруулах	+		
4. Зориулалтын бус сууцанд амьдардаг иргэдийн нийгмийн хамгаалал, баталгааг дээшлүүлэх:			
4.1 Зориулалтын бус сууцанд амьдардаг тул хаяг шилжүүлэлт, шилжих хөдөлгөөний бүртгэл хийлгэх боломжгүй байгааг анхаарах.	+		
4.2 Хаяггүйгээс болж урьдчилан сэргийлэх үзлэг, нарийн мэргэжлийн эмнэлгийн тусламж үйлчилгээг үнэ төлбөргүй авах боломжгүй, нийгмийн даатгал, халамжийн үйлчилгээнд хамрагдаж чадахгүй байгааг анхаарч, хаягжуулах арга хэмжээ авах	+		
4.3 Дийлэнх нь тогтсон ажил, орлоготой тул зориулалтын бус сууцанд амьдардаг иргэдэд зориулсан бага хүүтэй, эсвэл хүүгүй бага талбайтай орон сууцны зээл, хашаа/газар, түрээсийн сууцанд хамруулах боломжуудыг судалж хэрэгжүүлэх, ингэхдээ сарын хүү болон зээлийн төлбөр, эсвэл, түрээсийн төлбөр нь тухайн өрхийн сарын орлогын 30%-аас хэтрэхгүй байхаар зохицуулах	+		
4.4 Бага төлбөртэй, түрээсийн, ваучераар олгох орон байр, хашаа/газар нь сургууль, цэцэрлэг, төрийн үйлчилгээ гэх мэт нийгмийн дэд бүтэцтэйгээ ойрхон, хүнд ээлтэй орчинд баригдах	+		

1. УДИРТГАЛ

Улаанбаатар хотын гэр оронгүй, тэнэмэл иргэдийн хэрэгцээт байдлын түргэвчилсэн судалгаа нь гэр оронгүй, тэнэмэл иргэдийн хэрэгцээ, нөхцөл байдлыг илүү өргөн хүрээнд ойлгоход чиглэсэн анхны томоохон судалгаа юм. Монгол Улсын нийт хүн амын 48.1 хувь нь Улаанбаатар хотод амьдардаг бөгөөд гэр оронгүй иргэдийн тоогоор ч гэсэн бусад аймаг, хотыг бодвол харьцангуй олон байгаа нь нийслэлд энэхүү судалгааг хийх гол үндэслэл болсон. Энэхүү судалгаа нь Засгийн газраас авч хэрэгжүүлбэл зохих бодлого, арга хэмжээг тодорхойлох, холбогдох зөвлөмжийг боловсруулах зорилготой. Судалгаа, үнэлгээний “Когнос Интернэйшнл” ХХК нь энэхүү судалгааг Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр 2022 оны 1-10 дугаар сард хийж гүйцэтгэсэн болно.

1.1 “Гэр оронгүй байх” гэдгийг тодорхойлох нь

Гэр оронгүй, тэнэмэл болохоос урьдчилан сэргийлэх, уг асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн тодорхой бодлого, арга хэмжээ баталж, хэрэгжүүлэхийн тулд гэр оронгүй байх үзэгдлийн талаар нэгдмэл ойлголтод хүрэх нь чухал юм. Гэр оронгүй байх гэдгийг тодорхойлсон нийтээр хүлээн зөвшөөрсөн тодорхойлолт Монгол Улс төдийгүй дэлхий дахинаа байхгүй байна. Олон улсын тайлан судалгаанаас харахад гэр оронгүй байх гэдгийг орон байргүй байхаас гадна гэр бүлээ алдсан¹, нийгмээс гадуурхагдсан, хүлээн зөвшөөрөгдөхөө больсон, гэр бүл, хамаатан садангүй, биеийн болон сэтгэл зүйн эрүүл мэндэд² нөлөө үзүүлэхүйц орон байрны баталгаагүй байдал гэж тодорхойлсон ба гэр оронгүй байх нь эдийн засгийн боломжийг багасгаж, нийгмээс хөндийрүүлдэг³ төдийгүй хувь хүний өөрийгөө үнэлэх үнэлэмж⁴, нэр хүндэд сөрөгөөр нөлөөлдөг аж. НҮБ байгуулагдсанаас хойшхи 75 жилийн хугацаанд анх удаа гэр оронгүй иргэдийн асуудлыг 2020 онд НҮБ-ын 58-р Нийгмийн хөгжлийн комиссоор “Зохистой орон сууц болон гэр оронгүй иргэдийн нөхцөл байдлыг шийдвэрлэхэд чиглэсэн нийгмийн хамгааллын тогтолцоо” сэдвийн хүрээнд өргөн хүрээнд хэлэлцсэн. Гэр оронгүй байх гэдэг нь зөвхөн орох оронгүй байх бус гэр бүл, хамаатан садангүй, нийгмээс

¹ 58th UN Commission for Social Development (2020). Affordable housing and social protection systems for all to address homelessness. //documents-dds-ny.un.org/doc/UNDOC/LTD/N20/037/48/PDF/N2003748.pdf?OpenElement

² Oppenheimer, Sarah C., Paula S. Nurius, and Sara Green. “Homelessness History Impacts on Health Outcomes and Economic and Risk Behavior Intermediaries: New Insights from Population Data.” *Families in Society* 97, no. 3 (July 2016): 230–42. <https://doi.org/10.1606/1044-894.2016.97.21>.

³ Sylvestre J, Kerman N, Polillo A, Lee CM, Aubry T, Czechowski K. A Qualitative Study of the Pathways Into and Impacts of Family Homelessness. *Journal of Family Issues*. 2018;39(8):2265-2285. doi:10.1177/0192513X17746709

⁴ Tan H, Forbes-Mewett H. Whose ‘fault’ is it? Becoming homeless in Singapore. *Urban Studies*. 2018;55(16):3579-3595. doi:10.1177/0042098017743723

гадуурхагдан хүлээн зөвшөөрөгдөхөө болихыг хэлнэ. Гэр оронгүйдэл нь эдийн засгийн өсөлтийн үр шимийг хүртэх, аюулгүй, хүн ёсны амьдрах боломжгүйд хүргэж буй тогтолцооны доголдол юм. Олон улсад гэр оронгүй байх гэдгийг тодорхойлохдоо дараах хоёр тодорхойлолтыг түгээмэл ашигладаг байна. Үүнд:

1. Дэлхийн гэр оронгүйдлийн асуудлаарх хүрээлэн (ДГОХ)-ээс гаргасан тодорхойлолт (**Зураг 1.1.1**)
2. Гэр оронгүйдэл болон орон байраар хангагдах эрх зөрчигдөхийг тодорхойлсон Европын тодорхойлолт (“ETHOS” гэж товчилдог) (**Зураг 1.1.2**).

Дэлхийн гэр оронгүйдлийн асуудлаарх хүрээлэнгээс⁵ гаргасан тодорхойлолт нь 6 тивийн 30 гаруй улсын судлаачид, бодлогын шинжээчид болон бодлого боловсруулагчдын хамтран боловсруулсан баримт бичиг⁶ юм. Тус төвийн зорилтот хөтөлбөрүүд болон судалгаануудад, ялангуяа Ангилал 1 болон Ангилал 2-ын дэд бүлэгт (Хүснэгт 1.1.1-д тодруулсан) гэр оронгүй, тэнэмэл, гудамж хэсүүчлэн амьдарч буй болон түр хоноглох төвд байгаа иргэдийн нөхцөл байдлыг тусгасан.

Зураг 1.1.1. Дэлхийн гэр оронгүйдлийн асуудлаарх хүрээлэнгийн тодорхойлолт

Гэр оронгүй иргэн	Түр хоноглох төв болон эрсдэлт үед орогнох байранд амьдарч буй иргэн	Зохисгүй, аюулгүй бус орон сууцанд амьдарч буй иргэн
1А Гудамжинд эсхүл задгай газарт (цэцэрлэгт хүрээлэн, төмөр замын далан, гүүрний доор, замын хажуу, голын эрэг, ой мод гэх мэт) хонож буй иргэн	2А Түр хоноглох байранд хонож буй иргэн (орой бүр унтах газраа хайж олно)	3А. Түр хугацаанд найз нөхөд, ах дүү, хамаатан садангийнхаа гэрт амьдарч буй иргэн
1В Хүн амьдрах зориулалтын бус сууцанд (автобус болон вагоны буудал, таксины зогсоол, эзэнгүй барилга, нийтийн барилга, байгууламж гэх мэт) хонож буй иргэн	2В Гэр оронгүй иргэдэд зориулсан төв болон бусад түр хоноглох төвд амьдарч буй иргэн (өрөө, ор хуваарилж өгдөг)	3В. Хүчирхийлэлд өртөх эрсдэлд амьдарч буй иргэн
1С Автомашин, хүн тэрэг, завь, бусад тээврийн хэрэгсэлд хонож буй иргэн	2С Гэр бүлийн хүчирхийллээс зугтан түр хамгаалах байранд буй хүүхэд, эмэгтэйчүүд	3С. Хямд зочид буудал, дэн буудалд амьдарч буй иргэн
1D “Гудамж цэвэрлэгч” буюу оромж барьж, нэг цэгт тогтмол амьдардаг иргэн, өрх айл	2D Дотооддоо шилжин суурьшсан иргэдэд зориулсан хуаранд байрлаж буй зэвсэгт мөргөлдөөн, байгалийн гамшиг, хүнээс үүдэлтэй гамшиг, хүний эрхийн зөрчил, хөгжлийн гэх мэт шалтгааны улмаас орон гэрээсээ дайжсан, ингэхдээ хил даваагүй дотооддоо оршин сууж буй иргэн	3D. Хүн амьдрах зориулалтын бус сууцанд шахцалдан амьдарч буй иргэн
	2E Орогнол хүсэгчид, дүрвэгсэд болон цагаач иргэдийг хүлээн	3E. Хүн амьдрах зориулалтын бус сууцанд амьдарч буй иргэн
		3F. Чиргүүл, майханд амьдарч буй иргэн
		3G. Хэт олуулаа амьдарч буй иргэн
		3H. Хүн амьдрах зориулалтын бус сууц, түр зуурын зориулалттай барилга байгууламж, ядуусын хороолол

⁵ Institute of Global Homelessness, Accessed on April 27, 2022, <https://ighomelessness.org/igh-announces-the-first-global-framework-on-homelessness/>

⁶ Ibid.

	авах хуаран болон хүлээн авах/түр байрлуулах төвд байгаа иргэн	болон албан бус сууцанд амьдарч буй иргэн
--	--	---

Эх сурвалж: Дэлхийн гэр оронгүйдлийн асуудлаарх хүрээлэн, 2017 он.

ETHOS буюу Гэр оронгүйдэл болон орон байраар хангагдах эрх зөрчигдөхийг тодорхойлсон Европын тодорхойлолтод гэр оронгүй, тэнэмэл, орон байраар хангагдах эрх нь зөрчигдөхөд хүргэж буй амьдралын нөхцөл байдал зэргийг хамруулан авч үзсэн болно⁷. Ингэхдээ гэр оронгүй байх гэдгийг толгой хоргодох дээвэргүй байх, орон сууцгүй байх, аюулгүй бус сууц, зохистой бус сууц гэж 4 ангилалд хуваан авч үзсэн. Эдгээр 4 ангиллыг цаашлаад гэр оронгүй иргэдэд чиглэсэн бодлого, тэдэнд тулгарч буй саад бэрхшээлийг тодорхойлох, бодлого боловсруулах, хэрэгжилтэд нь хяналт тавих, дүн шинжилгээ, үнэлгээ хийх зорилгод ашиглах боломжтой 13 дэд ангилалд хуваан авч үзсэн⁸ (Хүснэгт 1.1.2).

Зураг 1.1.2. Гэр оронгүйдэл болон орон байраар хангагдах эрх зөрчигдөхийг тодорхойлсон Европын томъёолол (ETHOS)

		Үйл ажиллагааны төрөл	Амьдарч буй нөхцөл байдал	Ерөнхий тодорхойлолт
Суурь ангилал	Толгой хоргодох дээвэргүй	1. Тэнэмэл амьдралтай иргэн	1.1 Нийтийн орон зай эсхүл гадуур хонож буй иргэн	Гудамжинд эсхүл нийтийн орон зайд, амьдрах зориулалтын гэж үзэх боломжгүй сууцанд амьдарч буй иргэн
		2. Онц байдлын үеийн хоргодох байранд буй иргэн	2.1 Шөнө хоноглох төв	Тогтмол хоноглох сууцгүй, түр хоноглох төв, шаардлага төдийлөн тавьдаггүй түр хоноглоулах төвд хонож буй иргэн
	Гэр оронгүй	3. Гэр оронгүй иргэдэд зориулсан сууцанд амьдарч буй ирэн	3.1 Гэр оронгүй хүнд зориулсан нийтийн сууц 3.2 Түр хоноглох төв 3.3 Шилжилтийн үед дэмжлэг үзүүлэх түр сууц	Богино хугацаанд байрлах зориулалттай
		4. Эмэгтэйчүүдэд зориулсан түр хоноглох төвд амьдарч буй иргэн	4.1 Эмэгтэйчүүдэд зориулсан түр хоноглох төв	Гэр бүлийн хүчирхийллийн улмаас эмэгтэйчүүдийг түр байрлуулж буй байр, богино хугацаанд байрлуулах зориулалттай
		5. Цагаачдад зориулсан сууцанд амьдарч буй иргэн	5.1 Түр байрлуулах, хүлээн авах төвүүд 5.2 Цагаач ажилчдын байр	Цагаач иргэдийг статусаар нь хүлээн авч байрлуулах, түр байрлуулах зориулалттай
		6. Чөлөөлөгдөх гэж буй иргэн	6.1 Засан хүмүүжүүлэх газар 6.2 Эрүүл мэндийн байгууллага 6.3 Асрамжийн газар	Өмнө нь огт орон байргүй байсан Орон байргүй тул удаан хугацаанд байрлах шаардлагатай Орон байртай байсан нь тогтоогдоогүй (18 нас хүртэл)

⁷ FEANTSA, accessed on April 27, 2022, <https://www.feantsa.org/download/ethos2484215748748239888.pdf>

⁸ Ibid.

Багалгаагүй	7. Урт хугацаанд дэмжлэг авч буй иргэн (орон байргүйн улмаас)	7.1 Өндөр настны асрамжийн газар 7.2 Орон байргүй байсан хүмүүст зориулсан орон сууц	Үйлчилгээ бүхий өмнө нь орон байргүй байсан иргэдэд зориулсан урт хугацаанд байрлуулах байр (ихэвчлэн 1 жилээс дээш хугацаатай)
	8. Аюулгүй бус орон байранд амьдарч буй иргэн	8.1 Гэр бүл, найз нөхдийн хамт түр амьдарч буй 8.2 Албан ёсны зөвшөөрөлгүйгээр оршин сууж буй 8.3 Хууль бусаар газар эзэмшин сууж буй	Орон байргүйн улмаас ердийн орон сууц бус боловч сууцанд амьдарч буй Хууль бусаар хүний сууцанд амьдарч буй Хууль ёсны эрхгүйгээр газар эзэмшин сууж буй
	9. Нүүлгэх заналхийлэл дор амьдарч буй иргэн	9.1 Түрээсэлж буй орон сууцнаас албадан гаргасан 9.2 Өмнөх эзэмшлийг сэргээсэн	Албадан гаргах шийдвэр хүчин төгөлдөр Эзэмшигчийн эзэмших эрхийг сэргээсэн
	10. Хүчирхийллийн аюул дор амьдарч буй иргэн	10.1 Цагдаагийн байгууллагад бүртгэгдсэн	Цагдан сэргийлэх байгууллагаас гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хохирогчдыг аюулгүй байранд нүүлгэн шилжүүлсэн
Зохисгүй	11. Түр зуурын, хэвийн бус сууцанд амьдарч буй иргэн	11.1 Зөөврийн сууц 11.2 Ердийн бус сууц 11.3 Түр зуурын байгууламж	Тогтвортой оршин суух зориулалтгүй Түр суух зориулалтын сууц, оромж Байнгын бус сууц эсхүл кабин
	12. Зохисгүй орон сууцанд амьдарч буй иргэн	12.1 Оршин суух зориулалтын бус зохисгүй орон сууц	Үндэсний хууль тогтоомж эсхүл орон сууцны тухай зохицуулалтаар оршин суух зориулалтын бус гэж үзсэн
	13. Хэт олон хүнтэй хамт амьдарч буй иргэн	13.1 Үндэсний хэмжээнд тогтоосон зай талбайн дээд хэм хэмжээ	Нэг хүнд ноогдох зай талбайн үндэсний стандартыг давах

Эх сурвалж: Гэр оронгүйдэл болон орон байраар хангагдах эрх зөрчигдөхийг тодорхойлсон Европын томъёолол (ETHOS), 2005

Олон улсын ойлголт, тодорхойлолт, тайлан, судалгааны үр дүнгүүд болон судалгааны багийн 2022 оны 1-2 дугаар сард зохион байгуулсан судалгааны хүрээг тодорхойлох зөвлөлдөх уулзалтууд, ганцаарчилсан ярилцлагуудын үр дүнд тулгуурлан гэр оронгүй иргэн гэдгийг энэ судалгаанд дараах байдлаар тодорхойлсон болно:

Гэр оронгүй иргэн гэж 18 болон түүнээс дээш насны, гэр оронгүй, тэнэмэл байдлаар, эсхүл, байрны орц, хонгил гэх мэт зориулалтын бус сууцанд амьдарч буй иргэнийг хэлнэ.

Эл судалгаанд гэр оронгүй иргэдийг дотор нь хоёр бүлэгт хуваан авч үзсэн: А бүлэг буюу гэр оронгүй тэнэмэл иргэд, Б бүлэг буюу зориулалтын бус сууцанд амьдарч буй иргэд. Б бүлгийн хувьд тэднийг гэр оронгүй иргэд гэж томъёолох хууль эрх зүйн баримт бичиг Монгол улсад байхгүй ч олон улсын ойлголт, тодорхойлолт болон

судалгааны хүрээ тодорхойлох уулзалтын үеэр талуудын тавьсан хүсэлтийн дагуу энэхүү судалгаанд тодорхой төлөөллийг хамруулан судалсан.

1.2 Гэр оронгүй болоход нөлөөлж буй хүчин зүйлс

Аливаа хүн гэр оронгүй болоход нийгэм, эдийн засгийн тогтолцооны түвшний⁹ болон хувь хүн, гэр бүлийн түвшний олон хүчин зүйлс нөлөөлдөг. Тухайлбал, тогтолцооноос хамааралтай шалтгаанд ядуурал, тэгш бус байдал, ажилгүйдэл болон бүрэн бус хөдөлмөр эрхлэлт, ажлын байрны тогтворгүй байдал, ялгаварлан гадуурхалт, нийгмийн гадуурхалт, халамж асрамжийн газар болон эмзэг бүлгийн хүүхдэд зориулсан асран хамгаалах төвд байрлах насны хязгаарт хүрэх, хүртээмжтэй орон сууцны хомсдол, орон сууцны хувьчлал, албадан нүүлгэн шилжүүлэлт, хотжилт, хөдөөнөөс хот руу шилжих шилжилт хөдөлгөөн, газар эзэмших, байгалийн гамшгийн улмаас шилжин нүүх болон зөрчилдөөн, мөргөлдөөн зэрэг хамаарна¹⁰. Хувийн болон гэр бүлийн улбаатай шалтгаанд сэтгэцийн эрүүл мэнд, гэр бүлийн хүчирхийлэл, мансууруулах бодисын зохисгүй хэрэглээ, архаг эсвэл эдгэшгүй өвчин болоод эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, даатгалд хамрагдах боломж дутмаг байдал, хөгжлийн бэрхшээл¹¹, гэр бүл салалт, хүүхдийн хүчирхийлэл¹² зэрэг хамаардаг.

Хөдөөнөөс хот руу шилжих хөдөлгөөнөөс шалтгаалсан хотын хүн амын өсөлт, цалингийн зогсонги байдал, орон сууцны зах зээлийн худалдан авах чадвар буурсан, түрээсийн үнийн өсөлт, хүртээмжтэй орон сууцны хомсдолоос шалтгаалан эрэлт, нийлүүлэлтийн харьцаа алдагдах, хүртээмжтэй орон сууцны хүрэлцээ дутмаг зэрэг нь дэлхийн олон хотуудад¹³ гэр оронгүйдлийн хямралыг бий болгоход нөлөөлж байна. Мөн хүртээмжтэй орон сууцны хомсдол (орон сууцны түрээсийн үнэ өрхийн сарын орлогын 30 хувиас дээш хувь эзлэх¹⁴) нь гэр оронгүй, тэнэмэл байдалд хүргэж буй өөр нэг шалтгаан болж байна. Хөдөө орон нутагт амьжиргааны түвшин доогуур, суурь

⁹ Suzanne Speak, “The state of homelessness in developing countries” presentation at the expert group meeting on affordable housing and social protection systems for all to address homelessness,” Nairobi, 2020

¹⁰ Mabhala, Mzwandile A., Basma Ellahi, Alan Massey, and Paul Kingston. “Understanding the determinants of homelessness through examining the life stories of homeless people and those who work with them: a qualitative research protocol.” (2016).

¹¹ Carol A., Christopher A. Magee, and Peter J. Kelly, “Is there a complex trauma experience typology for Australians experiencing extreme social disadvantage and low housing stability?,” *Child Abuse & Neglect*, 2016

¹² Charlotte Fry et al., “A systematic review of cognitive functioning among young people who have experienced homelessness, foster care, or poverty,” *Child Neuropsychology* 23, no. 8 (2017): 907-934.

¹³ 58th UN Commission for Social Development, “Affordable housing and social protection systems for all to address homelessness: report of the Secretary-General,” accessed on April 27, 2022, <https://digitallibrary.un.org/record/3840349?ln=en>

¹⁴ UN-HABITAT, “Global Urban Indicators Database,” 2020

үйлчилгээний хүртээмж хангалтгүй байгаа нь¹⁵ хөдөөгийн иргэд хотод орон гэр нь бэлэн биш байхад олноор хот, суурин газарт шилжин суурьшихад хүргэж байна.

1.3 Гэр оронгүй иргэдийн талаарх тоо мэдээлэл

Дэлхий дахинаа 100¹⁶ сая хүн гэр оронгүй, 1.6 тэрбум хүн зориулалтын бус сууцанд амьдарч байна. 2010 онд явагдсан Хүн ам, орон сууцны тооллогоор 1016 иргэн гэр оронгүй тэнэмэл байдлаар амьдарч байсан байна. Сүүлийн 5 жилийн хугацаанд гудамжинд амьдарч буй гэр оронгүй, тэнэмэл иргэдийн хэд хэдэн статистик судалгаа гарсан байна. Тухайлбал, Нийслэлийн Нийгмийн халамжийн хэлтсийн судалгаагаар¹⁷, 2018 онд нийслэлд гэр оронгүй, тэнэмэл амьдарч буй 1,375 иргэн байсан ба тэдгээрийн 79 хувь нь эрэгтэй, 21 хувь эмэгтэй, 52 хувь 18-45 насныхан, 40 хувь нь 46-59 насныхан байсан байна. Тэнэмэл иргэдийн тал хувь нь 1-5 жил, 24 хувь нь 6-4 жил, 2 хувь нь 10-аас дээш жил гэр оронгүй, тэнэмэл байдлаар хэсүүчлэн амьдарсан байна. Шилжилт хөдөлгөөнд оролцсон байдлаар нь үзвэл, 80 хувь нь Улаанбаатар хотын уугуул, 20 хувь нь хөдөө орон нутгаас шилжин ирсэн, нийслэлийн нийт гэр оронгүй иргэдийн 80 орчим хувь нь хаягийн бүртгэлтэй гэсэн байна. Нийслэлийн Нийгмийн халамжийн газар¹⁸, Нийслэлийн Цагдаагийн удирдах газар, Нийслэлийн Нийгмийн хамгааллын тусгай төв, дүүргүүдийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэс хамтран орон гэргүй, тэнэмэл амьдралтай, архины хамааралтай иргэдийн бүртгэл судалгааг 2020 оны 12 дугаар сарын байдлаар гарган нийт 850 иргэнийг олж тогтоон мэдээллийн сан үүсгэсэн байна.

Гэр оронгүй иргэдийн талаарх олон улсад хэрэглэгдэж буй ойлголт, тодорхойлолтуудаар, орц, хонгил зэрэг хүн амьдрах зориулалтын бус газарт амьдарч иргэд мөн гэр оронгүй иргэд гэж тооцогддог. Гэвч тэдгээр иргэдийг цэгцтэй судалж бүртгэсэн дэлгэрэнгүй тоо, мэдээллийн сан өнөөг болтол Монгол Улсын албан ёсны статистикуудаар байхгүй, тэдгээр өрх, гэр бүлүүд ямар шинж байдалтай, яагаад ийм нөхцөлд амьдрах болсон талаар болон одоогийн нөхцөл байдал, асуудал, бэрхшээлүүдийг нь ул үндэстэйгээр судлан, зохион байгуулалттайгаар бүгдийг нь хамруулсан арга хэмжээ авах ажил өнөөг хүртэл хийгдэхгүй байсаар байна. Монгол Улсын 2020 оны ХАОСТ-ын дүнгээр, 2,227 өрх зориулалтын бус сууцанд амьдарч байгаа тоо гарсан байна. Захиргааны буюу НЗДТГ-ын Нийгмийн бодлогын хэлтсээс өгсөн мэдээгээр, Улаанбаатар хотод 2022 оны байдлаар 1,857 гэр оронгүй өрх зориулалтын бус сууцанд буюу орцны жижүүр хийж орцны үүд хэсэгт байрлан амьдарч,

¹⁵ 58th UN Commission for Social Development, “Affordable housing and social protection systems for all to address homelessness: report of the Secretary-General,” 2020

¹⁶ UN-HABITAT, “Financing Urban Shelter: Global Report on Human Settlements 2005,” Nairobi

¹⁷ АХБ, Иргэний үлсын бүртгэлийн мэдээллийн санд бүртгэлгүй, оршин суугаа газрын тодорхой хаяггүй, иргэний бичиг баримтгүй иргэдийг бүртгэлжүүлэх арга зам, 2019

¹⁸ ХНХЯ, Шилжих хөдөлгөөн ба хот, суурины аюултай бүс, орцонд амьдарч буй гэр бүл. (НХХЯ-ны хэвлэгдээгүй судалгааны тайлан), 2010

мөн байрны хонгил болон 00-ын өрөөнд амьдарч байна. Түүнчлэн 4,922 өрх нийтийн байранд амьдарч байна (Хүснэгт 1.3.1).

Хүснэгт 1.3.1 УБ хотод орцны жижүүр хийж орцны үүд хэсэгт байрлан амьдардаг, байрны хонгил болон 00-ын өрөөнд амьдардаг өрхийн тоо, нийтийн байранд амьдардаг өрхийн тоо

№	Дүүрэг	Орцны жижүүр	Хонгилд амьдардаг	00-ын өрөөнд амьдардаг	Нийтийн байранд амьдардаг
1	Баянгол	268	85	204	2177
2	Багануур	-	3	3	3
3	Налайх	-	3	-	-
4	Сүхбаатар	78	143	16	193
5	Баянзүрх	186	212	41	302
6	Багахангай	-	-	-	1
7	Хан-Уул	35	119	56	143
8	Сонгинохайрхан	147	67	52	1985
9	Чингэлтэй	14	7	118	118
	Нийт	728	639	490	4,922
	Нийт		1,857		4,922

Эхсурвалж: Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтэс

2. ХУУЛЬ ЭРХЗҮЙН ОРЧИН, ОЛОН УЛСЫН ТУРШЛАГА

Энэхүү бүлэгт гэр оронгүй иргэдийн асуудлаар Монгол Улсад хэрэгжиж байгаа эрх зүйн болон бодлогын орчингийн талаар хоёрдогч тоо баримт, мэдээллүүдэд шинжилгээ хийх замаар тоймлон танилцуулсан. Түүнчлэн гэр оронгүй иргэдийн асуудлаар Монгол Улсад болон бусад улсад хийгдсэн зарим судалгаа, гэр оронгүй иргэдтэй ажиллах чиглэлээр олон улсад хэрэгжиж буй сайн туршлага зэргээс танилцуулсан.

2.1 Монгол Улс дах гэр оронгүй иргэдийн талаарх эрх зүйн орчин, төрийн бодлого, үйл ажиллагаа, тоо мэдээлэл, судалгаа

Монгол Улсын хүн бүр иргэн хүн болж төрснийхөө хувьд хуулинд зөвшөөрөгдсөн бүхий л хүний эрхийг эдэлж, үүрийг биелүүлэх боломжуудаар хангагдсан байх ёстойг *Хүний эрхийн түгээмэл тунхаглал* болон *Монгол Улсын Үндсэн хуульд* баталгаажуулсан байдаг (**Шигтгээ 2.1.1**).

Шигтгээ 2.1.1:

Монгол Улсын Үндсэн хуулийн хэсгээс:

16-р зүйл: Монгол Улсын иргэн дараахь үндсэн эрх, эрх чөлөөг баталгаатай эдэлнэ:

1/амьд явах эрхтэй;

2/эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрхтэй;

5/өндөр наслах, хөдөлмөрийн чадвар алдах, хүүхэд төрүүлэх, асрах болон хуульд заасан бусад тохиолдолд эд, мөнгөний тусламж авах эрхтэй;

6/эрүүл мэндээ хамгаалуулах, эмнэлгийн тусламж авах эрхтэй;

19-р зүйл: 1.Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна.

Гэвч Монгол Улс дахь гэр оронгүй иргэдийн хувьд иргэний эрх, үүргийн зөрчлийн асуудал нь нэлээд ил тод бус, нийгмийн бусад бүлгүүдийн асуудлын “ард талд” үл анзаарагдан/хойшлогдон орхигдсон байж болзошгүй юм.

Үндсэн хуулиас гадна, нарийвчилсан байдлаар ГОТИ-ийн асуудлыг Монгол Улсад *Нийгмийн халамжийн тухай* хуулиар зохицуулж байгаа бөгөөд халамжийн тогтолцооны цогц үйлчилгээний нэг хэсэг болон тусгагдсан байна. *Нийгмийн халамжийн тухай* хуульд зааснаар **олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ** (ОНОТХҮ) гэдэг нь иргэн, аж ахуйн нэгж, төрийн болон төрийн бус байгууллагын оролцоотойгоор өрх, иргэнд дэмжлэг туслалцаа, үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааг хэлдэг. ОНОТХҮ-г 2005 оноос эхлэн хэрэгжүүлэхээр *Нийгмийн халамжийн тухай* хуулинд заасан боловч хэрэгжүүлэх механизм дутагдалтай байснаас дахин шинэчлэн найруулан, холбогдох журам, аргачлалыг баталж, 2011 оноос хэрэгжиж эхэлсэн байна. Дээрх хуулиас гадна цөөн төрлийн хөтөлбөр, арга хэмжээг Засгийн

газрын зүгээс боловсруулан хэрэгжүүлж ирсэн ба **Хүснэгт 2.1.1**-д Монгол Улсад гэр оронгүй, тэнэмэл иргэдтэй холбоотойгоор хүчин төгөлдөр хэрэгжиж байгаа хууль тогтоомж, хөтөлбөрүүд, тэдгээрийн зарим онцлох заалтуудаас сийрүүлэн харуулав.

Хүснэгт 2.1.1. Монгол Улсад хэрэгжиж буй гэр оронгүй өрх, иргэдтэй холбоотой эрх зүйн орчин.

Ангилал, хууль тогтоомж	Зүйл, заалт	Ерөнхий зохицуулалт
Нийгмийн халамжийн тухай хууль	13.5.3	Онцгой тохиолдлын мөнгөн тэтгэмж олгох Хорих ангиас суллагдсан өөрийн гэсэн гэр оронгүй, нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай өрх иргэн”-д
	13.5.4.	Нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай, дөрөв ба түүнээс дээш 18 хүртэлх насны хүүхэдтэй, гэр оронгүй, өрх толгойлсон эцэг, эхэд
	18.1.8.	Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ Гэр оронгүй иргэн, түүний гэр бүлийн гишүүдийн амьдрах итгэлийг нэмэгдүүлэх, нийгэмшүүлэх, бичиг баримтжуулах, түр хоноглох байранд байрлуулах;
	18.2.8.	Гэр оронгүй тэнэмэл амьдралтай иргэн, өрх
	18.5	ОНОТХҮ-г иргэн, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагаар гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлж болно.
	18.6	18.5-д заасан иргэн, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагыг сонгон шалгаруулах ажлыг аймаг, нийслэл, дүүргийн нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллага гүйцэтгэнэ.
	20.1.1.	Энэ хуулийн 20.2-т заасан хүүхэд сургуулийн өмнөх боловсролын болон ерөнхий боловсролын сургуульд сурч байгаа бол хичээлийн хэрэгсэл, сурах бичиг, дүрэмт хувцасны үнийн хөнгөлөлт үзүүлэх
	20.2.4	Боловсролын дэмжих үйлчилгээнд дараах иргэнийг хамруулна: Гэр оронгүй, тэнэмэл амьдралтай иргэний хүүхэд
	20.3.	Энэ хуулийн 20.2.2, 20.2.4, 20.2.6-д заасан хүүхэд албан бус сургалтад хамрагдаж байгаа бол түүнд энэ хуулийн 20.1.1-д заасан хөнгөлөлтийг бүрэн буюу хэсэгчлэн олгоно.
	20.5.	Боловсролыг дэмжих үйлчилгээг нийгмийн халамжийн болон боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хамтран баталж, тус тусын үзүүлэх тусламж, дэмжлэгийн зардлыг тухайн Засгийн газрын гишүүний төсвийн багцаас гаргана.
	22.1.2.	Хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээ Гэр оронгүй, тэнэмэл амьдралтай иргэн, өрх
	21.1.1.	Эрүүл мэндийг дэмжих үйлчилгээ Энэ хуулийн 3.1.2-т заасан өрхийн гишүүн-иргэний эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг бүрэн болон хэсэгчлэн төлөх;
	21.1.2.	Нийгмийн халамжид хамрагдагсад үзүүлэх эрүүл мэндийн бусад үйлчилгээ
Засгийн газрын тогтоол		Гэр оронгүй, тэнэмэл иргэдтэй холбоотойгоор Монгол Улсын Засгийн Газрын дараах тогтоол, шийдвэрүүд гарсан байна. Үүнд: <ul style="list-style-type: none"> • Эрүүл мэндийн даатгалтай холбогдсон зарим арга хэмжээний тухай, дугаар 79, 1995 он • Гэр оронгүй, тэнэмэл амьдралтай иргэдийн талаар авах арга хэмжээний тухай, дугаар 248, 2002 он, • Гэр оронгүй, тэнэмэл амьдралтай иргэдийг нийгэмшүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай, дугаар 137, 2014 он • ОНОТХҮ хэрэгжүүлэх журам, дугаар 161, 2010 он

Хөтөлбөр	<ul style="list-style-type: none"> • “Гэртээ харих зам” Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчид, дугаар 187, 2015 он • Монгол Улсын Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөр, дугаар 120, 2012 он, Хавсралт төлөвлөгөөний хамт
-----------------	---

Нийгмийн халамжийн тухай хуулийн¹⁹ 18.1 дүгээр зүйлд заасан ОНОТХҮ-ний хүрээнд дараах төрлийн үйлчилгээ багтана:

1. Амьдралын итгэл үнэмшил, бие даан амьдрах чадвар, хөдөлмөрийн дадал олгох, авьяасыг нь дэмжих зорилгоор сургалт зохион байгуулах,
2. Зөвлөгөө өгөх,
3. Сэргээн засах үйлчилгээнд хамруулах,
4. Түр байрлуулан асрамжлах, хүчирхийлэлд өртсөн хүнийг түр хамгаалан байрлуулах,
5. Өдрийн үйлчилгээнд хамруулах,
6. Гэрийн асрамж, халамжийн үйлчилгээнд хамруулах,
7. Иргэн, түүний гэр бүлийн хэрэгцээнд тулгуурласан нийгмийн халамжийн бусад үйлчилгээг үзүүлэх,
8. Гэр оронгүй иргэн, түүний гэр бүлийн гишүүдийн амьдрах итгэлийг нэмэгдүүлэх, нийгэмшүүлэх, бичиг баримтжуулах, түр хоноглох байранд байрлуулах,
9. Нийгмийн халамжийн дэмжлэг, тусалцаа зайлшгүй шаардлагатай өрх, иргэнийг нийгэмшүүлэх, хамт олны бүлэг бүрдүүлэх, орлогын эх үүсвэртэй болгох төсөл хэрэгжүүлэх, амьдрах ухаанд сургах,
10. Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчийг түр хамгаалан байрлуулах үйлчилгээнд хамруулах.

Дээрх үйлчилгээнд дараах төрлийн зорилтот өрх, иргэн хамрагдахаар хуулийн 18.2 дугаар заалтад заасан байна²⁰. Үүнд:

1. Ахмад настан
2. Хөгжлийн бэрхшээлтэй иргэн
3. Эрсдэлт нөхцөлд байгаа хүүхэд
4. Хүчирхийлэлд өртсөн иргэн
5. Хорих ангиас суллагдсан иргэн
6. Согтуурах, мансуурах донтох өвчтэй иргэн
7. Эдгэшгүй хүнд өвчтэй хүн
8. Гэр оронгүй, тэнэмэл амьдралтай өрх, иргэн
9. Шилжин суурьшсан өрхийн гишүүн, иргэн
10. Өрх толгойлсон эх /эцэг/
11. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй өрх
12. Гурав болон түүнээс дээш хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцгийн хүүхэд²¹

¹⁹ УИХ, Нийгмийн халамжийн тухай хууль, 2012

²⁰ УИХ, Нийгмийн халамжийн тухай хууль, 2012

²¹ Ibid. 2017 оны 6 сарын 30-нд нэмэлт өөрчлөлт орсон

Хуулийн заалтаас харахад, судалгааны зорилтот бүлэг болох ГОТИ дээрх халамжийн үйлчилгээнд хамрагдаж, үйлчилгээг хүртэх боломжтой. Үйлчилгээг хэрэгжүүлэгч байгууллага нь аймаг, дүүргийн хөдөлмөр халамжийн үйлчилгээний газар/хэлтэс болон аймаг, нийслэл, дүүргийн нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллагатай гэрээ байгуулсан иргэн ААН, ТББ байх боломжтой юм.

Гэр оронгүй иргэдийн талаар хийгдсэн судалгааны ажил ховор байна. Цөөн тооны зарим судалгааны ажлууд хийгдсэнээс, дор тоймлон харуулав. Дэлхийн банкнаас гаргасан судалгаагаар²² гэр оронгүй, тэнэмэл иргэдэд үзүүлж буй туслалцаа, үйлчилгээний доголдлыг тогтоож, холбогдох хууль тогтоомжийг хэрэгжүүлэхэд хот төлөвлөлт, эрүүл мэнд, боловсрол, зам тээвэр, нийгмийн халамж, хуулийн болон хууль сахиулах зэрэг байгууллагуудын жигд оролцоог хангаж, ‘засгийн газар бүхэлдээ’ хүчин чармайлт гаргах шаардлагатайг онцолсон. Тухайн судалгаагаар гэр оронгүй иргэдэд чиглэсэн үйлчилгээнүүд асуудлаас урьдчилан сэргийлэхээс илүү ихэвчлэн гал унтраасан, байгууллагад суурьлсан тусламж үйлчилгээ хэлбэртэй байгааг тэмдэглэжээ. Мөн судалгаагаар гэр оронгүй иргэдэд үзүүлэх тусламж асуудлаасаа шалтгаалан холимог хэлбэрээр явагдах нь зүйтэйг дурьдсан. Тухайлбал, өвлийн улиралд түр хоноглох байраар шуурхай хангах, харин удаан хугацаанд гэр оронгүй байсан иргэдэд нөхөн сэргээх үйлчилгээ болон эрчимт түр хоноглох байр, шилжин суурьшагсдад улирлын чанартай орон байр, орц, шатны доор, хонгил зэрэг нөхцөлд амьдарч буй иргэдэд тэдэнд тохирсон өөр зохицуулалт гаргах гэх мэт холимог байдлаар асуудлыг шийдэх хэрэгтэйг зөвлөмж болгосон.

Хүн амын дотоод шилжих хөдөлгөөний талаар хийгдсэн томоохон судалгаануудаас харахад нийслэлд шилжин ирэгч дийлэнх иргэдэд суурьших газар олдохгүй, байр, хашаа худалдан авч чадахгүй, нийгмийн үйлчилгээнд хамрагдаж чадахгүй байх зэрэг асуудлууд тулгардгаас гадна эдийн засгийн чадавхи болон боловсрол, мэргэжлийн байдал доогуур, мэдээлэл, тусламж олж авах танилын хүрээ хязгаарлагдмал байдгаас ажилд орох боломж муу, аргагүйн эрхэнд хүн амьдрах шаардлага, нөхцөл бүрдээгүй газарт ажиллаж, амьдардаг гэсэн үр дүн гарсан байдаг. Иймээс цаашид гэр оронгүй тэнэмэл иргэд болон зориулалтын бус сууцанд амьдарч буй иргэдийн тоо мэдээллийг цэгцлэх, асуудлыг нарийвчлан судалж, тодорхой бодлого, арга хэмжээ хэрэгжүүлэх нь зүйтэй юм.

2.2 Гэр оронгүй болохоос урьдчилан сэргийлэх, бууруулах, үгүй болгох талаарх олон улсын сайн туршлагаууд

Дэлхийн улс орнууд гэр оронгүй иргэдийн статистик тоо мэдээллийг ихэвчлэн “тухайн цаг мөч”-ид буюу нэг шөнийн дотор тоологдсон тоогоор гаргадаг. Энэ ажлыг ихэвчлэн орон нутгийн удирдлага, засаг захиргаа төлөвлөгөөт ажлаа болгосон байдаг. АНУ, Канад, Их Британи, Тайвань, Хонг-Конг, Сингапурт энэ төрлийн судалгаа нь гэр

²² Sunita Kotnala, “Proposed services for the homeless in Mongolia,” World Bank, 2012

оронгүйдлийн нөхцөл байдлыг ойлгох, түүнд хяналт тавих, хариу арга хэмжээ авах нотолгоо болж өгдөг. Ингэхдээ эдгээр хот, улс оронд нэг шөнийн нэг цаг мөчид бүх төрлийн хамгаалах байранд байгаа, гудамжинд хоноглож буй гэр оронгүй, тэнэмэл иргэдийг тоолж, ганцаарчилсан ярилцлага хийх зорилгоор 400-1000 орчим сайн дурын ажилчдыг дайчлан ажиллуулдаг. Энэхүү арга нь орон гэргүйдлийн талаарх ойлголт мэдлэгийг олон нийтэд таниулах, илүү бодитой тоо мэдээлэл цуглуулах, давхардуулан тоолохоос урьдчилан сэргийлэх зэрэг давуу талыг бий болгодог.

Дэлхий дахинаа, гэр оронгүй иргэдийн төлөө бодлого боловсруулагчид, газар дээр нь ажилладаг хүмүүс хоёр төрлийн хөтөлбөр хэрэгжүүлдэг байна.


Хүснэгт 2.2.1 Дэлхий дахинаа гэр оронгүй иргэдийн төлөө хийгддэг хоёр төрлийн хөтөлбөр

Иргэдийг гэр оронгүй байлгадаг	Иргэд гэр оронгүй болохоос урьдчилан сэргийлдэг
Хурч үйлчлэх Түр хоноглох газар Шилжилтийн Байршуулан эмчлэх хөтөлбөр	Эн тэргүүнд гэр орноор хангах Гэр бүлд нь нэгтгэх Түр хоноглох байрт очихоос урьдчилан сэргийлэх Урьдчилан сэргийлэх

Эх сурвалж: Др. Сэм Тэмбэрис, Эн тэргүүнд гэр орноор хангах хөтөлбөрийг санаачлагч, 2021

Дэлхий дахинаа хэрэгжүүлж байгаа гэр оронгүйдлийг бууруулах, арилгахад чиглэсэн төрөл бүрийн хөтөлбөр, загваруудаас сэтгэцийн болон нийгмийн загварыг “Эн тэргүүнд гэр орноор хангах” (Housing first) загвартай хослуулан хэрэглэх нь “шаталсан загвар” (Staircase model)-тай харьцуулахад мансууруулах бодис хэрэглэдэг гэр оронгүй иргэдийг нөхөн сэргээх, нийгэмшүүлэхэд хамгийн үр дүнтэй болох нь батлагдсан (Зураг 2.2.1 болон Зураг 2.2.2 үзнэ үү).

Зураг 2.2.1. Гэр оронгүйдлийг шийдвэрлэхэд “Шаталсан загвар”-ыг ашиглах нь.



Эх сурвалж: Др. Сэм Тэмбэрис, Эн тэргүүнд гэр орноор хангах хөтөлбөрийг санаачлагч, 2021

Эн тэргүүнд гэр орноор хангах гэдэг нь гэр оронгүй иргэдийг байнгын оршин суух, хүртээмжтэй гэр орноор аль болох хурдан хангахыг хэлнэ. Ингэхдээ тэдгээр хүмүүст дэмжлэгт үйлчилгээнүүдийг үзүүлж, олон нийтийн оролцоонд түшиглэсэн

дэмжин тусалдаг хүмүүстэй холбож, улмаар орон сууцаа хадгалж авч үлдэх, гэр оронгүй, тэнэмэл амьдралд эргэн орохоос нь сэргийлдэг.

Зураг 2.2 2. Гэр оронгүй иргэдийг эн тэргүүнд гэр орноор хангах загвар.



Эх сурвалж: Др. Сэм Тэмбэрис, Эн тэргүүнд гэр орноор хангах хөтөлбөрийг санаачлагч, 2021

Судалгаанаас харахад “эн тэргүүнд гэр орноор хангах” загварыг ашиглах нь гэр орондоо тогтвортой амьдарч, гэр орноо авч үлдэх хувийг өндөр байлгах, мөн гал унтраасан байдалтай үйлчилгээнүүд²³ болон байгууллагад суурьлсан үйлчилгээнүүдийг багасгаж, гэр оронгүй иргэдийн эрүүл мэндэд сайнаар нөлөөлж²⁴, ниймийн эерэг үр дүнг²⁵ бий болгодог. “Эн тэргүүнд гэр орноор хангах” арга зам болон “шатлалт загвар”-ын аль нь илүү үр дүнтэй болохыг судлахын тулд санамсаргүй хяналтат туршилтыг²⁶ Канадын 5 хотод 950 гэр оронгүй, тэнэмэл иргэдийн дунд явуулсан. Судалгааны үр дүнгээс харахад “эн тэргүүнд гэр орноор хангах” хөтөлбөрт хамрагдсан гэр оронгүй иргэдийн гэр орондоо тогтвортой амьдрах байдал, амьдралын чанар болон олон нийтийн оролцоонд түшиглэсэн үйлчилгээний үр дүн нэг жилийн хугацаанд хоёр дахин нэмэгдсэн байна. Иймээс дэлхийн олон улс орон энэхүү сайн туршлага болсон “эн тэргүүнд гэр орноор хангах” загварыг орон гэргүйдлээс урьдчилан сэргийлэх, багасгах болон арилгахдаа орон нутгийн зөвлөл, засаг захиргаатайгаа хамтран хэрэгжүүлж ирсэн (Зураг 2.2.3)


²³ Keuroghlian, Alex S., Derri Shtasel, and Ellen L. Bassuk. "Out on the street: a public health and policy agenda for lesbian, gay, bisexual, and transgender youth who are homeless." *American journal of orthopsychiatry* 84, no. 1 (2014): 66.

²⁴ McAll, Christopher. "Appearing to the world: The effects of the Housing First experiment in Montreal after 48 months." *Vie sociale* 2324, no. 3 (2018): 85-98

²⁵ Medicine Hat Community Housing Society. "At Home In Medicine Hat: Our Plan to End Homelessness." *Homelessness & Housing Development*. January 2014.

²⁶ Aubry, Tim, Sam Tsemberis, Carol E. Adair, Scott Veldhuizen, David Streiner, Eric Latimer, Jitender Sareen et al. "One-year outcomes of a randomized controlled trial of housing first with ACT in five Canadian cities." *Psychiatric Services* 66, no. 5 (2015): 463-469.

Зураг 2.2.3. “Эн тэргүүнд гэр орноор хангах” загварыг ашиглан тогтолцоог өөрчлөх нь



Эх сурвалж: Др. Сэм Тэмбэрис, Эн тэргүүнд гэр орноор хангах хөтөлбөрийг санаачлагч, 2021

Финлянд улс нь орон гэргүүдлийг шийдвэрлэх чиглэлээр хэрэгжүүлж буй хүчин чармайлтаараа дэлхийд тэргүүлдэг²⁷. Тус улс 2018 оноос хэрэгжиж буй "эн тэргүүнд гэр орноор хангах" бодлого бүхий орон гэргүүдлийг шийдвэрлэхэд чиглэсэн үндэсний стратегийнхаа хүрээнд 2027 он гэхэд орон гэргүүдлийг арилгах зорилт тавин ажиллаж байна. Бүх нийтийн нийгмийн болон эрүүл мэндийн үйлчилгээ нь гэр оронгүй болох эрсдэлт нөхцөлд байгаа иргэдэд дэмжлэг үзүүлж, гэр оронгүй байсан иргэдийг нийгэмшүүлэхэд тусалдаг. Финляндын Y-сан (Y-Foundation) нь гэр оронгүй иргэдэд зориулсан хүртээмжтэй түрээсийн хямд өртөгтэй орон сууцны тоог нэмэгдүүлэх замаар тус улс дахь орон гэргүүдлийг нэгмөсөн арилгах зорилго дэвшүүлэн ажилладаг. Ингэхдээ улсын хэмжээнд хот, суурин газруудад барилга барьж, засварлаж, түрээсэлдэг ба 2016 оны байдлаар тус сан 52 хот, орон нутагт 6,675 орон сууц өмчилж авсан байна. Орон сууцыг “эн тэргүүнд гэр орноор хангах” загвараар орон нутгийн засаг захиргаа болон төрийн бус байгууллагуудтай түншлэх хэлбэрээр гэр оронгүй иргэдэд олгодог. Ихэнх орон сууц нь хотын төвөөр байрладаг ба энэ нь оршин суугчдад хөдөлмөрийн зах зээл, үйлчилгээний газрууд болон дэмжлэг үзүүлэх үйлчигээнд ойр байх боломжийг бүрдүүлдэг. Түүнчлэн оршин суугчдыг нийгэмшүүлэхэд чиглэсэн шинэлэг шийдэл, төлөвлөгөөг ашигладаг. Y-сан нь оршин суугчдад дэмжлэг үзүүлэх сүлжээг бий болгох, гэр оронгүй иргэдэд үзүүлэх үйлчилгээг хөгжүүлэхэд орон нутгийн болон төрийн бус байгууллагуудыг оролцуулах замаар түрээслэгч нарт дэмжлэг үзүүлж, бие даан амьдрах чадавхи олгохыг зорьдог. Тус сангаас 2020 он гэхэд нийт түрээслэгчдийнхээ гуравны

²⁷ 58th UN Commission for Social Development, “Affordable housing and social protection systems for all to address homelessness. Chair’s Summary,” accessed on April 30, 2022, <https://www.un.org/development/desa/dspd/wp-content/uploads/sites/22/2020/06/chair-summary-csod58-priority-theme-panel.pdf>

хоёрыг ямарваа нэг дэмжлэг авах шаардлагагүйгээр бие даан амьдрах чадвартай болгохыг зорьж буй.

АНУ-д хэд хэдэн муж API (application programming interfaces) програм хангамжийн интерфэйсийг ашигладаг ба энэ нь агентлагууд гэр оронгүй, тэнэмэл иргэдийн бүртгэл мэдээллийг тэдний эрүүл мэндийн бүртгэл мэдээллийн хамт нэгдсэн мэдээллийн сангаас авч, нэгдмэл бодлого, зохицуулалттайгаар туслалцаа, үйлчилгээг хүргэх боломж олгодог. Түүнчлэн гэр оронгүй, тэнэмэл иргэдэд хүрч ажиллахын тулд гар утасны технологийг ашигладаг. Ахмад дайчдын гэр оронгүйдлийн асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн хоёр томоохон хөтөлбөрийг хэрэгжүүлдэг. Эхнийх нь орон сууцны ваучер, татаас, дэмжлэг үзүүлэх үйлчилгээд чиглэдэг бол хоёр дахь хөтөлбөрийн хүрээнд түр хугацаанд эсхүл онцгой нөхцөл байдлын улмаас гэр оронгүй байгаа иргэдийг өр зээлнээс салахад нь дэмжлэг үзүүлдэг. Иргэд, төрийн бус байгууллагууд эдгээр санаачилгыг өргөнөөр дэмжиж, үр дүнд нь гэр оронгүй ахмад дайчдын тоо 8 жилийн хугацаанд 50 хувиар буурчээ.

Бразил улсад орон сууцны бодлого нь хүн бүр гэр орноор хангагдах түгээмэл эрхийн зарчимд тулгуурладаг. Сүүлийн 10 жилийн хугацаанд хэрэгжүүлсэн Засгийн газрын бодлого, үйл ажиллагаа нь нийт орон нутгийн 97 хувийг хамарч, орон сууц, нийгмийн хамгааллын хүртээмжийг нэмэгдүүлсэн. Бразилийн Засгийн газар орон сууцны бодлогыг шинэчлэн боловсруулж, халамжийн загварыг халж, “эн тэргүүнд гэр орноор хангах” загварыг 2021 оноос хэрэгжүүлж байна. Одоогоор 3 мужийн нийслэл хотод “эн тэргүүнд гэр орноор хангах” загварыг туршиж эхлээд байна.

3. СУДАЛГААНЫ ЗОРИЛГО, АЧ ХОЛБОГДОЛ

3.1 Судалгааны зорилго

Судалгааны үндсэн зорилго нь Улаанбаатар хотын гэр оронгүй, тэнэмэл иргэдийн амьдралын нөхцөл байдалд дүн шинжилгээ хийхэд оршино. Түүнчлэн орон сууцны орц, хонгил зэрэг зориулалтын бус сууцанд амьдарч буй гэр оронгүй иргэдийн хувьд тэднийг гэр оронгүй иргэд гэж томъёолох хууль эрх зүйн баримт бичиг Монгол улсад одоогоор байхгүй ч олон улсын ойлголт, тодорхойлолт болон судалгааны хүрээ тодорхойлох уулзалтын үеэр талуудын тавьсан хүсэлтийн дагуу энэхүү судалгаанд тодорхой төлөөллийг оруулж, амьдралын нөхцөл байдлыг нь судлахад чиглэнэ. Дүн шинжилгээг Улаанбаатар хот дахь гэр оронгүй иргэд болон тэдэнтэй ажилладаг мэргэжилтнүүдийг хамруулсан түүвэр судалгаа хийх, мөн гэр оронгүй иргэдийн асуудлаарх олон улсын сайн туршлагаудыг судлах замаар хийсэн ба судалгааны үр дүнд үндэслэн гэр оронгүй иргэдийн асуудлаар Засгийн газраас хэрэгжүүлж болохуйц бодлого, үйл ажиллагааны чиглэлийг тодорхойлж, холбогдох зөвлөмжүүдийг боловсруулна.

Гэр оронгүй иргэдийн нөхцөл байдлын талаар анхан шатны мэдээллийг өргөн хүрээнд нарийвчлан судалсан судалгаа Монгол Улсын хэмжээнд дутагдалтай байгаа тул энэхүү судалгааны үр дүн нь гэр оронгүйдлийн асуудлыг ойлгох, олон улсын сургамж, сайн туршлагаас суралцах, цаашдын судалгааны сэдвүүдийн суурийг тавихад дөхөм үзүүлнэ хэмээн найдаж байна. Мөн гэр оронгүй, тэнэмэл амьдралаар амьдарч буй иргэд үндэсний статистик тоо мэдээллээс орхигдох, мөн нийгмийн халамжийн үйлчилгээнээс хүртэж чадахгүй үлдэх гэх мэт асуудлуудтай байдаг. Иймд энэхүү судалгаа нь гэр оронгүй, тэнэмэл иргэд болон зориулалтын бус сууцанд амьдарч буй иргэдийн шинж байдал, амьдралын нөхцөл, сэтгэл зүйн байдал, гэр оронгүй болоход нөлөөлсөн хүчин зүйлс, нийгмийн үйлчилгээнд хамрагдах байдал зэргийн талаар дэлгэрэнгүй судалж, Монгол Улсад дутагдалтай байгаа тоо, мэдээлэл бүрдүүлэхэд хувь нэмрээ үзүүлнэ.

Цаашилбал, шинжлэх ухааны үндэслэлтэй тоо, мэдээллээр асуудлыг баримтжуулан шийдвэр гаргагчид, хэрэгжүүлэгчдийн сонорт хүргэж буйгаараа ач холбогдолтой юм. Энэ бүгдийн үр дүнд бид хөгжлөөс хэнийг ч орхигдуулахгүйгээр, хамгийн эмзэг бүлгийхэнд түрүүлж хүрч үйлчилж Тогтвортой хөгжлийн зорилтуудаа нотолгоонд суурилсан байдлаар хэрэгжүүлэх Монгол Улсын хүчин чармайлтад хувь нэмрээ оруулахыг зорьсон.

3.2 Судалгааны хүрээ

Судалгааны байршлын хувьд УБ хотыг сонгосон нь бусад аймгийн хувьд гэр оронгүй, тэнэмэл иргэдийн тоо одоогоор УБ-тай харьцуулахад бага түвшинд байгаатай холбоотой. УБ хот дотроо төвийн 6 дүүргийг сонгон мэдээлэл цуглуулсан ба алслагдмал

Багахангай, Налайх, Багануур дүүргүүдийн хувьд мөн гэр оронгүй, тэнэмэл иргэдийн тоо төвийн дүүргүүдтэй харьцуулахад бага гэж үзсэн тул энэ удаагийн судалгаанд оруулаагүй.

3.3 Судалгааны арга зүй

Энэхүү судалгаа нь гэр оронгүй иргэд, тэдэнд туслалцаа, үйлчилгээ үзүүлдэг төрийн болон төрийн бус байгууллагууд болон бодлого боловсруулагчдын санал бодлыг асуун, дүн шинжилгээ хийх замаар Улаанбаатар хотод амьдарч буй гэр оронгүй иргэдийн нөхцөл байдал, хэрэгцээг судлах зорилготой судалгаа юм. Ингэхдээ тоон болон чанарын судалгааны аргыг хослуулсан холимог арга зүйг ашигласан. Тоон мэдээллийг асуулгын дагуу ганцаарчилсан ярилцлага хийх замаар цуглуулсан. Чанарын мэдээллийг гэр оронгүй, тэнэмэл байдлаар амьдарч буй иргэдтэй бүлгийн болон ганцаарчилсан гүнзгийрүүлсэн ярилцлага, мөн төрийн болон төрийн бус байгууллагуудын ажилтнуудтай ярилцлага хийх замаар цуглуулсан. Түүнчлэн үндэсний хэмжээнд болон олон улсад хийгдсэн судалгаа, шинжилгээний ажлууд, сайн туршлагауудыг судалж, мэдээлэл цуглуулах, зөвлөмж боловсруулахад ашигласан.

2022 оны 2-р сарын 16-ны өдөр оролцогч талуудын 42 төлөөлөлтэй (**Хавсралт А**) уулзалт хийж, судалгаанд ашиглах гэр оронгүй иргэний тодорхойлолт, судалгааны хамрах хүрээг танилцуулж, саналыг авч, эцэслэсэн.

Мэдээлэл цуглуулалтын ажлыг 2022 оны 2-р сарын 20-ноос 4-р сарын 20-ны хооронд хийж гүйцэтгэсэн. Мэдээлэл цуглуулахын өмнө судалгааны багийн гишүүдэд сургалт хийж, туршилтын судалгааг зохион байгуулсан. Энэхүү судалгааг хийхэд олон улсад сайн туршлагад тооцогддог гэр оронгүй, тэнэмэл байдлаар амьдралыг даван туулсан хүнийг судалгааны багтаа оруулж судалгаагаа авах зөвлөмжийг даган ажилласан. Үүнийг олон улсад орон гэргүйдлийн судалгаа хийх сайн жишигт тооцдог. Асуумж, сургалтын агуулгыг энэхүү багийн гишүүнтэйгээ харилцан зөвлөлдөж, санал солилцох замаар боловсруулсан. Судалгааны багийн бүх гишүүдэд судалгаа хийх явцад гэр оронгүй, тэнэмэл байдлаар амьдарч буй иргэдэд хайр, хүндэтгэл, хүлээцтэй хандахыг зааж сургасан. Судалгаанд оролцогчдод судалгааны талаарх мэдээллийг танилцуулж, сайн дураар оролцох зөвшөөрөл авсны үндсэн дээр судалгааг авч байсан. Оролцогчдын гэрэл зургийг авахдаа тухай бүр өөрсдөөс нь зөвшөөрөл авсан болно.


3.4 Судалгааны түүвэрлэлт, дүн шинжилгээ

Түүвэрлэлт

Тоон судалгаа: Судалгааны хүрээнд хоёр ялгаатай бүлгийн гэр оронгүй иргэдээс мэдээлэл цуглуулсан: *А бүлэг* буюу тэнэмэл байдлаар хэсүүчлэн амьдарч буй гэр оронгүй иргэд мөн *Б бүлэг* буюу орон сууцны орц, хонгил, хонгил зэрэг зориулалтын

бус сууцанд амьдарч буй иргэд. Б бүлгийн хувьд тэднийг гэр оронгүй иргэд гэж томъёолох хууль эрх зүйн баримт бичиг байхгүй Монгол улсад байхгүй ч олон улсын тодорхойлолт болон судалгааны хүрээ тодорхойлох уулзалтын үеэр талуудын тавьсан хүсэлтийн дагуу энэхүү судалгаанд төлөөлөл болгон хамруулсан. Судалгааны түүврийн хэмжээний талаарх мэдээллийг **Зураг 3.4.1**-д харуулав.

Зураг 3.4.1 Тоон судалгааны түүврийн хэмжээ



Судалгааны явцад судлагдахуунд хүрч ажиллах боломжоос шалтгаалан олон төрлийн түүвэрлэлтийн аргыг ашиглах шаардлагатай байсан тул А бүлэг буюу гэр оронгүй, тэнэмэл нийт 405 иргэдийг дотор нь хоёр дэд бүлэгт хуваасан: А1 бүлэг болох түр хоноглох байранд байрлаж буй 305 иргэд, А2 бүлэг болох гадуур хэсүүчлэн хоноглож буй 100 иргэд. А1 бүлгээс судалгаа авахдаа тухайн цаг мөчид Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж буй түр хоноглох төвүүдэд (**Хүснэгт 3.4.1**) байрлаж буй иргэн бүрээс мэдээлэл цуглуулахыг зорьж, А2 бүлгийн хувьд гудамжинд хэсүүчлэн хоноглодог гэр оронгүй, тэнэмэл иргэдийг хамруулсан. Судалгааны багийн гишүүд Нарантуул, Барс зэрэг зах болон Долмалин хийд зэрэг гэр оронгүй, тэнэмэл иргэд олноор цугларч хооллодог газарт хүрч очин, ярилцлага хийсэн.

Б бүлгийн хувьд Улаанбаатар хотын 5 дүүргийн орон сууцны орц, хонгилд амьдарч буй 200 иргэдийг судалгаанд хамруулсан (нэг дүүргээс 40). Ингэхдээ зорилтот бүлгийн төлөөлөл цөөн тоогоор оршин суудаг Улаанбаатар хотын Хан-Уул дүүргийг хассан болно. Судалгааны багийн гишүүд **Хавсралт Б** –д байгаа асуумжийн дагуу судалгаанд оролцогчдоос мэдээлэл цуглуулсан.

Хүснэгт 3.4.1. Судалгаанд хамрагдсан гэр оронгүй тэнэмэл иргэд (А1 бүлэг), байрлаж буй түр хоноглох төвөөр.

№	Түр хоноглох төвийн нэр /англи хэлээр/	Төвийн нэр /монгол хэлээр/	Оролцогчдын тоо	Эзэлж буй хувь /%/
Улсын төсөвт түр хоноглох төв				
1	Special Center for Social Protection	Нийгмийн хамгааллын тусгай төв	74	24.3
Төрийн бус байгууллагуудын ажиллуулдаг түр хоноглох төв				
2	Ulziit Asar NGO	Өлзийт асар ТББ	69	22.6
3	One way faith NGO	Ганц зам, итгэл ТББ	31	10.2
4	Titem construction NGO	Титэм констракшн ТББ	27	8.9
5	Dulguun minj NGO	Дөлгөөн минж ТББ	24	7.9
6	New life defeater NGO	Шинэ амьдрал, ялагт ТББ	18	5.9

7	Bethel NGO	Бэтэл ТББ	15	4.9
8	Terem mountain NGO	Тэрэм уул ТББ	15	4.9
9	Khagan Bogda NGO	Хаган богд ТББ	14	4.6
10	Amgalan Grace NGO	Амгалан ивээл ТББ	9	3.0
11	Help International Mongolia NGO	Хэлп интернэшнл ТББ	6	2.0
12	He is a light NGO	Тэр гэрэл ТББ	3	1.0
	Нийт		305	100.0

Чанарын судалгаа: Чанарын судалгааны тоо мэдээллийг дараахь аргачлалаар цуглуулсан: Үндсэн мэдээлэгчтэй хийх ярилцлага, фокус бүлгийн ярилцлага, ганцаарчилсан гүнзгийрүүлсэн ярилцлага (Ярилцлагын удирдамжуудыг **Хавсралт В-ээс** харна уу).

Үндсэн мэдээлэгчтэй хийх ярилцлага: Нийт 26 хүн (төрийн байгууллагын 10 төлөөлөл, улсын болон ТББ-ын түр хоноглох төвийн 11 захирал/менежер, олонорон гэргүй, тэнэмэл иргэдийн ар гэрийн 4 төлөөлөл)-тэй ярилцлага хийсэн. Төрийн байгууллагууд, магадлан итгэмжлэгдсэн түр хоноглох төв (ТББ), магадлан итгэмжлэгдээгүй түр хоноглох төв (ТББ), ар гэрийн төлөөлөл гэсэн 4 ангиллаар ялгаатай ярилцлагын асуултууд бэлдэж, гэр оронгүй иргэдтэй холбоотой хууль эрх зүйн орчин, тулгарч буй бэрхшээл, төвүүдийн үйлчилгээний чанар, сургамж, сайн туршлага, орон гэргүй болсон шалтгаан гэх мэт олон асуудлын хүрээнд ярилцсан.

Фокус бүлгийн ярилцлага (ФБЯ): Нийт 37 хүнийг хамруулсан 7 фокус бүлгийн ярилцлагыг түр хоноглох төвүүд дээр хийсэн. Ингэхдээ хүйсийн тэгш байдал болон нас, боловсрол гэх мэт нийгэм эдийн засгийн шинж чанарын ялгаатай байдлыг аль болох хангах байдлаар оролцогч хүмүүсээ сонгосон. ФБЯ-ын гол зорилго нь тоон судалгаагаар хэмжихэд төвөгтэй зарим асуудлыг, тухайлбал хэрхэн оронгүй амьдрал руу хальтарсан, өдөр тутам тулгардаг бэрхшээл, өдрийн ерөнхий дүр төрх, амьдралын хүсэл тэмүүлэл гэх мэт сэдвүүдийн хүрээнд судалгаанд оролцогчдыг чөлөөтэй ярилцуулахад чиглэсэн.

Ганцаарчилсан гүнзгийрүүлсэн ярилцлага (ГГЯ): Түр хоноглох төвүүд дээр хийсэн судалгаанд оролцогчдоос 29 гэр оронгүй, тэнэмэл иргэдээс өөрсдийн зөвшөөрлийн үндсэн дээр хамруулсан. Гол ярилцсан сэдвүүд нь хэрхэн орон гэргүй, тэнэмэл амьдрал руу орсон, амьдралд санаа зовдог зүйлс, нийгмийн амьдралд оролцоход тулгардаг бэрхшээлүүд, амьдралын зорилго гэх мэт байсан.

Хүснэгт 3.4.2 Түлхүүр мэдээлэл өгөгчдийн нэрс

Төрийн байгууллагууд			
	Нэр	Албан тушаал	Байгууллагын нэр
1	Баатархүү	Дарга, Нийгмийн бодлогын хэлтэс	НЗДТГ
2	Намсрайхүү	Мэргэжилтэн, Нийгмийн бодлогын хэлтэс	НЗДТГ
3	Дуламсүрэн	Дарга, Нийгмийн халамжийн хэлтэс	Нийслэлийн нийгмийн халамжийн газар

4	Чимэгсүрэн	Дарга, Нийгмийн халамжийн хэрэгжилтийн газрын халамжийн үйлчилгээний хэлтэс	ХХҮЕГ
5	Амармөрөн	Дарга, Нийслэлийн цагдаагийн ерөнхий газрын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хэлтэс	Цагдаагийн зрөнхий газар
6	Азжаргал	Хараа хяналтгүй хүүхдийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн	Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газар
7	Одончимэг	Орлогч дарга	Энэрэл эмнэлэг
8	Санжаа	Дарга, Нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах алба	СХД-ийн Цагдаагийн 1-р хэлтэс
9	Занданшоо	Мэргэжилтэн, Нийгмийн бодлогын хэлтэс	СХД
10	Энхтуул	Дарга, Хөдөлмөр, нийгмийн халамжийн хэлтэс	СХД
Нийгмийн хамгааллын тусгай төв			
	Нэр	Албан тушаал	Байгууллага
11	Пүрэвсүрэн	Төслийн зохицуулагч	НХТТ
12	Мөнхцэцэг	Захирал	НХТТ
13	Нандинцэцэг	Ахлах нийгмийн ажилтан	НХТТ
Олон улсын байгууллага			
14	Оюунхишиг	Төслийн үндэсний мэргэжилтэн	ОУ-ын шилжилт хөдөлгөөний байгууллага
Түр хоноглуулах төвүүд (ТББ)			
	Нэр	Албан тушаал	Байгууллага
15	Баянмөнх	Захирал	Өлзийт асар ТББ
16	Алтантуул	Захирал	Ганц зам итгэл ТББ
17	Уртнасан	Захирал	Найдварын өргөө ТББ
18	Алтантуяа	Менежер	Сэргэлт өөд ТББ
19	Тамара	Захирал	Заюу тайж ТББ
20	Батцэнгэл	Захирал	Шинэ амьдрал ялагч ТББ
21	Роза	Захирал	Бат гэрэлт ирээдүй ТББ
22	Буяннэмэх	Захирал	Титэм констракшн ТББ
ГОТИ-ийн гэр бүлийн гишүүд (ТББ)			
23	Нэрийг нууцлав	Гэр бүлийн гишүүн	
24	Нэрийг нууцлав	эр бүлийн гишүүн	
25	Нэрийг нууцлав	эр бүлийн гишүүн	
26	Нэрийг нууцлав	эр бүлийн гишүүн	

Дүн шинжилгээ

Тоон ба чанарын судалгаагаар цуглуулсан анхдагч мэдээллийг боловсруулж шинжлэхдээ агуулгын хувьд Масловын хэрэгцээний дараахь шатлалын онолын дагуу ГОТИ-ийн хэрэгцээг ерөнхийлөн ангилж, тэдгээр нь хэрхэн хангагдаж буй байдлыг тус тусад нь дүгнэн бүлэг болгож оруулсан (Зураг 3.4.1): i) Физиологийн, ii) Аюулгүй байдлын, iii) Харьяалагдах, хайрлах буюу Нийгмийн, iv) Хүндлэлийн, v) Хувь хүний хөгжлийн буюу Өөрийгөө идэвхжүүлэх²⁸. Физиологийн хэрэгцээ, аюулгүй байдал бүрэн

²⁸ Мянгар, О, Хүний хөгжлийн сэтгэл зүйн лекцүүд (дөрөв дэх удаагийн хэвлэл), Улаанбаатар, 2010

хангагдаагүй өрх, гэр бүл, нийгэмд хүний эрхийн зөрчил, гэмт хэрэг, хүчирхийлэл, хууран мэхлэлт, ялгаварлал, гадуурхал зэрэг сөрөг үзэгдлүүд оршдог гэж үздэг.

Тоон мэдээллээр дүрслэх статистикийн шинжилгээ хийсэн ба чанарын судалгааны мэдээллийг агуулгаар нь *сэдэвчлэн шинжлэх*, шинж тэмдгээр *харьцуулан шинжлэх* зэрэг аргуудаар шинжилсэн.

Судалгаагаар цуглуулсан тоон мэдээллүүд ГОТИ-ийн тодорхой асуудлууд хэр өргөн хүрээг хамарсан буюу хэр түгээмэл/давтамжтай байгааг илрүүлсэн бол чанарын мэдээллүүд нь тоон судалгааны үр дүнг тодруулах, баяжуулах, мөн асуудлын мөн чанар, учир шалтгааныг тайлбарлах, тоогоор хэмжигдэхгүй зарим асуудлыг олж харах зэрэгт тустай байсан.

Зураг 3.4.2 Масловын хэрэгцээний шатлалын суварга



Эх сурвалж: Maslow (1954); Мягмар (2016).

Өнөөгийн байдлаар Улаанбаатар хотод байгаа гэр оронгүй иргэдийг хаана байрлаж байгаагаас нь хамааруулан гурав ангилж болохоор байгаа ба бид түр хоноглох байранд байгаа (A1 бүлэг), гадуур хоноглож буй (A2 бүлэг), мөн хүн амьдрах зориулалтын бус байранд амьдарч буй (B бүлэг) иргэд гэсэн бүлгүүдээр судалгааны үр дүнг шинжилж, дүгнэсэн болно.

3.5 Судалгааны хязгаарлагдмал байдал

Тус судалгаа нь дараах хязгаарлагдмал талуудтай. Үүнд:

1. Гэр оронгүй, тэнэмэл иргэдийн тооллого биш, мөн үндэсний хэмжээний түүвэр судалгаа биш тул судалгааны үр дүн Монгол Улсын хэмжээнд байгаа нийт гэр

оронгүй иргэдийг бүрэн төлөөлөхгүй, харин Улаанбаатар хотын хэмжээнд судалгаанд оролцсон хүмүүсийн нөхцөл байдлыг илэрхийлнэ.

2. Цаг хугацаа болон нөөцийн хязгаарлагдмал байдлын улмаас орон сууцны орц, хонгил зэрэг зориулалтын бус сууцанд амьдардаг иргэдээс 200 иргэнийг судалгаанд хамруулж, мэдээллийг цуглуулсан.
3. Олон улсад гэр оронгүй иргэнд тооцдог гэр бүлийн хүчирхийллийн хохирогчдод зориулсан түр хамгаалах байр, өндөр настны асрамжийн газар, өнчин хүүхдүүдийн асрамжийн газарт байрлаж буй иргэдийг мөн адил цаг хугацаа, нөөц хязгаарлагдмал байсны улмаас судалгаанд хамруулж чадаагүй.

4. УЛААНБААТАР ХОТЫН ГЭР ОРОНГҮЙ, ТЭНЭМЭЛ ИРГЭДИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

Улаанбаатар хотод амьдарч буй гэр оронгүй, тэнэмэл иргэдийн хүн ам зүйн шинж, өдөр тутмын амьдралын ахуйн нөхцөл, эрүүл мэнд, орлого ба амьжиргааны байдал, гэрээсээ дайжих болсон шалтгаан, өөрийн үнэлэмж, нийгмийн хүрээлэл ба төрийн, бус байгууллагуудын үйлчилгээнд хамрагдаж буй байдал зэргийг энэхүү бүлэгт авч үзсэн. Тоон ба чанарын судалгааны мэдээлэлд суурилсан шинжилгээний үр дүнг танилцуулахдаа А1 буюу түр хоноглох байранд байгаа, А2 буюу гадуур хоноглож буй иргэдийн бүлгээр, мөн зарим хүн ам зүйн шинж байдлаар харьцуулан авч үзсэн.

4.1. Гэр оронгүй, тэнэмэл иргэдийн хүн ам зүйн шинж байдал

Судалгаанд хамрагдсан ГОТИ-ийн хүн ам зүйн шинж байдал дараах гол онцлогтой байна:


- 54.3% нь ид хөдөлмөрийн буюу 25-49 насны, 8 хүн тутмын 1 нь эмэгтэй хүн байна.
- 2002 оноос хойш орон нутгаас Улаанбаатарт шилжин ирсэн ГОТИ-ийн 66.4% нь хаягийн бүртгэлгүй байна. Гэр оронгүй, гадуур хоноглож буй иргэд (А2 бүлэг)-ийн хаягийн бүртгэл түр хоноглох төвүүдэд байрлаж буй иргэд (А1 бүлэг)-ийнхээс бага байна.
- 10-аас дээш насны хүн амын хувьд тооцсон улсын дундаж боловсролын үзүүлэлтүүдтэй харьцуулахад, ГОТИ-ийн дунд боловсролгүй иргэдийн хувь 1.8 дахин их, дээд боловсролтой иргэдийн хувь 2.3 дахин бага байна. Мөн судалгаанд хамрагдсан эмэгтэй ГОТИ-ийн бичиг үсэгт тайлагдсан байдал улсын дунджаас 6.6 пунктээр доогуур байна.
- Гэр оронгүй дөрвөн иргэн тутмын хоёр нь гэрлэлтээ цуцлуулсан болон тусгаарласан, нэг нь огт гэрлээгүй, мөн 10 хүн тутмын нэг нь бэлэвсэн байна.
- ГОТИ-ийн 79.3% хүүхэдтэй ч тэдний 96.9% нь хүүхдүүдтэйгээ хамт амьдардаггүй байна.

Энэ хэсэгт судалгаанд хамрагдсан ГОТИ-ийн нас, хүйсийн бүтэц, шилжилт хөдөлгөөнд оролцсон байдал, хаягийн бүртгэл, боловсрол, гэр бүлийн байдал зэрэг хүн ам зүйн онцлог шинжийг танилцуулсан ба эдгээр нь тухайн хүний гэр оронгүй амьдрах байдал, амьдралын чанартай нь салшгүй холбоотой үзүүлэлтүүд юм. Судалгаанд хамрагдсан ГОТИ-ийн 75.3 хувь буюу 305 иргэн улсын болон ТББ-ын түр хоноглох төвүүдэд, 24.7 хувь буюу 100 иргэн гадуур хоноглож байсан бөгөөд нийт ГОТИ-ийн 87.2 хувь нь эрэгтэй, 12.8 хувь нь эмэгтэй байв. Судлагдсан ГОТИ-ийг судалгааны мэдээлэл цуглуулах үед байрлаж байсан газраар нь ялгаж, тус бүрийн нас, хүйсийн бүтцийг суваргаар [Зураг 4.1.1](#)-д харуулав.

Улаанбаатарт байгаа гэр оронгүй тэнэмэл иргэдийн ихэнх нь эрэгтэй, хөдөлмөрийн насны иргэд байна. Судалгаанд хамрагдсан ГОТИ-ийг хүйсээр задлан харвал эрэгтэйчүүд давамгайлж байсан бөгөөд орон гэргүй 8 хүн тутмын 1 нь эмэгтэй, 7 нь эрэгтэй байна. Насны бүтцээр авч үзвэл ГОТИ-ийн дундаж нас 48.3, хамгийн залуу нь 22, хамгийн ахимаг нь 78 насны хүмүүс байна. Голч насаар нь харвал, ГОТИ-ийн тал

хувь нь 48 хүртэл, үлдсэн тал хувь нь 48-аас дээш насны иргэд байв. Эдгээр насны үзүүлэлтийг нарийн задалж харвал, ГОТИ-ийн 54.3 хувь нь ид хөдөлмөрийн буюу 25-49 насны иргэд байгаа нь анхаарал татаж байв. Насны бүтцийг ГОТИ-ийн байрлаж буй газраар ялган авч үзвэл, түр хоноглох байранд байрлаж буй иргэд (дундаж нас 48.9, голч нас 49) гадуур хоноглож буй иргэдээс арай ахимаг настай (дундаж ба голч нас нь тус тус 2 насаар өндөр) байна.

Зураг 4.1.1. Судалгаанд хамрагдсан ГОТИ-ийн хувь, нас, хүйсээр




Улаанбаатарт байгаа ГОТИ-ийн талаас илүү нь орон нутгаас шилжин ирэгчид байна. Судалгаанд хамрагдсан ГОТИ-ийн 45.8 хувь нь амьдралынхаа хугацаанд шилжих хөдөлгөөнд оролцоогүй буюу Улаанбаатарт төрсөн иргэд, 54.2 хувь (үүний 27.9 хувь нь 2002 оноос өмнө, 26.3 хувь нь 2002 оноос хойш буюу сүүлийн 10 жил дотор) нь ямар нэг байдлаар шилжих хөдөлгөөнд оролцсон буюу орон нутгаас Улаанбаатарт шилжин ирсэн хүмүүс байна. ГОТИ-ийн шилжих хөдөлгөөний байдлыг байрлаж буй газраар нь ялган харвал, түр хоноглох байранд байрлаж буй ГОТИ-ийн 50.5 хувь нь шилжин ирэгсэд байсан бол гадуур байгаа ГОТИ-дийн хувьд уг үзүүлэлт 65.7 хувь байна. Ялангуяа гадуур хоноглож буй ГОТИ-ийн дотор сүүлийн 10 жил дотор шилжиж ирсэн хувь түр хоноглох байранд байрлаж буй ижил төрлийн хүмүүсийнхээс 7.3 пунктээр өндөр байна. Эдгээрээс, бид шилжин ирэгчдийн хувьд гэр оронгүй, тэнэмэл амьдралд орох эрсдэл нийслэлийн унаган иргэдийнхээс илүү байгааг онцлон, тус асуудалд анхаарах хэрэгтэй гэж үзэж байна.

ГОТИ-ийн дунд, ялангуяа орон нутгаас сүүлийн 10 жил дотор шилжин ирсэн ГОТИ-ийн дунд хаягийн бүртгэлгүй байдал өндөр байна. Хаягийн бүртгэлтэй байх нь иргэд бүх төрлийн үйлчилгээнд хамрагдах, өөрийн эрхээ хамгаалуулахад чухал үүрэгтэй хүчин зүйлсийн нэг юм. Гэвч Улаанбаатараас судалгаанд хамрагдсан гэр оронгүй 4 хүн тутмын 1 (25.4 хувь) нь ямар ч харьяалал, бүртгэл байхгүй байна. Шилжих


хөдөлгөөний байдлаар нь ялган харвал, нийслэлийн уугуул иргэдийн 94.3 хувь, 2002 оноос өмнө шилжин ирэгчдийн 81.7 хувь, 2002 оноос хойш шилжин ирэгчдийн 33.7 хувь нь тус тус Улаанбаатар хотын аль нэг дүүрэг, хороонд хаягийн бүртгэлтэй гэжээ. Мөн А2 бүлэг буюу гадуур хоноглож буй иргэдийн хувьд хаягийн бүртгэлтэй байдал түр хоноглох төвүүдэд байрлан амьдарч буй иргэд (А1 бүлэг)-ийнхээс бага түвшинтэй, анхаарал татахаар байгааг **Зураг 4.1.2**-оос харж болно. Тухайлбал 2002 оноос хойш шилжин ирсэн гадуур хоноглож буй иргэдийн 28.6 хувь нь нийслэлд хаягийн бүртгэлтэй байгаа нь түр хоноглох төвүүдэд байрлан амьдарч буй иргэдийнхээс 7.7 нэгж хувиар бага байна.

Зураг 4.1.2 Улаанбаатар хотод хаягийн бүртгэлтэй ГОТИ-ийн хувь, шилжих хөдөлгөөнд оролцсон байдлаар




Улаанбаатар хотод хаягийн бүртгэлтэй судалгаанд хамрагдсан ГОТИ хотын бүхий л дүүрэгт байгаа боловч дийлэнх нь нийслэлийн төвийн 6 дүүрэгт бүртгэлтэй байна. Тухайлбал, 31.0 хувь нь Сонгинохайрхан, 29.3 хувь нь Баянзүрх, 13.6 хувь нь Чингэлтэй, 11.6 хувь нь Хан-Уул, 7.5 хувь нь Сүхбаатар, 5.8 хувь нь Баянгол, 1.4 хувь нь алслагдсан 3 дүүрэгт тус тус бүртгэлтэй байна.

Зураг 4.1.3 Улаанбаатар хотод хаягийн бүртгэлтэй ГОТИ-ийн хувь, дүүргээр



Судалгаанд хамрагдсан ГОТИ-ийн боловсролын үзүүлэлтүүд улсын дунджаас доогуур байна. Судлагдсан ГОТИ-ийн 11.4 хувь нь дээд, 10.1 хувь нь техникийн болон тусгай мэргэжлийн, 36.5 хувь нь бүрэн дунд, 25.7 хувь нь суурь, 7.7 хувь нь бага боловсролтой байгаа бол 8.6 хувь нь боловсролгүй байна. Боловсролгүй гэж хариулсан ГОТИ-ийн бичиг үсгийн мэдлэгийн байдлыг харвал, 28.6 хувь нь энгийн өгүүлбэр уншиж, бичиж чаддаг, 57.1 хувь нь энгийн нэмэх, хасах үйлдлийг хийж, тоо бодож чаддаг гэжээ. Судалгаанд хамрагдсан эмэгтэй ГОТИ-ийн боловсрол эрэгтэйчүүдийнхээс доогуур байна. ГОТИ-дийн бичиг үсгийн мэдлэгийг хүйсээр нь авч үзвэл эрэгтэйчүүдийн 94.1 хувь, эмэгтэйчүүдийн 92.3 хувь байсан ба эмэгтэйчүүдийн бичиг үсгийн мэдлэг улсын дунджаас 6.6 пунктээр доогуур байна. ГОТИ-ийн боловсролын түвшинг хүйсээр задлан харвал, эмэгтэйчүүдийн дээд болон тусгай дунд боловсрол эзэмшсэн байдал (17.3 хувь) эрэгтэйчүүдийнх (22.1 хувь)-ээс бага, харин боловсролгүй, бага болон бүрэн дунд боловсролтой эмэгтэйчүүдийн хувийн жин эрэгтэйчүүдийнхээс 2-4 пунктээр өндөр байна

Зураг 4.1.4 Судалгаанд хамрагдсан ГОТИ-ийн хувь, боловсролын түвшнээр



ГОТИ-ийн дунд гэрлэлтээ цуцлуулсан, тусгаарласан, бэлэвсэн хүмүүс их байна. Судлагдсан ГОТИ-ийн 30.6 хувь нь гэрлэлтээ албан ёсоор цуцлуулсан, 17.8 хувь нь салаад тусдаа амьдарч байгаа гэсэн бол 26.2 хувь нь огт гэрлээгүй, 9.6 хувь нь бэлэвсэрч үлдсэн байна. Судалгаанд хамрагдсан ГОТИ-ийн гэрлэлтийн байдлыг хүйсээр харвал гэрлэсэн эмэгтэйчүүдийн хувийн жин эрэгтэйчүүдийнхээс 3.6 дахин өндөр байгаа бол гэр бүл салсан эмэгтэйчүүдийн хувийн жин эрэгтэйчүүдийнхээс 2.7 дахин бага байна. Эдгээрээс дүгнэхэд, ГОТИ-ийн, ялангуяа эрэгтэй ГОТИ-ийн гэр бүлийн тогтворгүй байдал нь тэдний гэр оронгүй гадуур хоноглож байгаатай нягт уялдаатай байж болзошгүй байна.

Хүүхэдтэй иргэд дунджаар 2 хүүхэдтэй ч хүүхдээсээ тусдаа амьдарч байна. Хүүхэдтэй эмэгтэйчүүдийн 8.5 хувь, харин хүүхэдтэй эрэгтэйчүүдийн 2.2 хувь нь л хүүхдүүдтэйгээ хамт амьдардаг байна. Ийнхүү дийлэнх хүүхэдтэй ГОТИ хүүхэдтэйгээ хамт амьдарч чадахгүй байгаа нь олон шалтгаантай ба тэдгээрийн дунд архины хамаарал, гэр бүлийн амьдралын тогтворгүй байдал зэрэг хүчин зүйл томоохон үүрэг гүйцэтгэдэг нь чанарын судалгаануудаар түгээмэл харагдсан.

Шигтгээ 4.1.1:

... Архинаас бүрэн гарах, орон гэртэй болох, охинтойгоо цуг амьдрахыг хүсдэг. Эхний эхнэрийн дараа дахиад нэг эмэгтэйтэй танилцаж хүүхэдтэй болсон. Гэхдээ одоо надтай уулзуулдаггүй, хүүхдээ хараагүй л байна. Уулзахыг хүсэж байгаагаа хэлэхэд уулзуулна гэхчээд дандаа зугатдаг....

Ганцаарчилсан ярилцлагаас, 37 настай, эрэгтэй, ТББ-ын түр хоноглох байр

4.2. Гэр оронгүй, тэнэмэл иргэдийн амьдарч буй ахуйн нөхцөл

Судалгаанд хамрагдсан ГОТИ-ийн ахуйн нөхцөлд дараах гол анхаарах зүйлс байна:

- Улаанбаатарт байгаа ГОТИ харьцангуй урт хугацаанд (дунджаар 9.8 жил, медиан үзүүлэлт 7 жил) тогтсон гэр оронгүй, хэсүүчлэн амьдарч буй иргэд байна.
- Нийслэлд байгаа гэр оронгүй, тэнэмэл 10 хүн тутмын 4 нь урьд өмнө өөрийн гэсэн гэр оронгүй, хамаатан/найзындаа болон түрээсийн байр/гэрт байсан, эсхүл засан хүмүүжүүлэх болон асрамжийн газраас гарсан иргэд байна.
- ГОТИ дулааны үед ихэвчлэн гудамж, зуслан, ой мод, голын эрэг (37%), орон сууцны орц, хонгил зэрэгт (36.3%), харин хүйтний үед ТББ, сүм хийд, улсын байгууллагын ажиллуулдаг түр хоноглох төвүүд (75.1%)-д хоноглож байна.
- ГОТИ тогтвортой ундны усны эх үүсвэргүй, ихэвчлэн айл, байгууллага, нийтийн ус түгээх байр, орон сууц, хонгилийн төвлөрсөн шугам зэрэг олон эх үүсвэрээс гуйх байдлаар (дулааны үед ГОТИ-ийн 79.4%, хүйтний үед 86.9%) усны хэрэгцээгээ хангадаг ба энэ байдал түр хоноглох төвүүдэд байгаа ГОТИ-тэй харьцуулахад төвүүдэд байрлаагүй ГОТИ-ийн дунд 2 дахин илүү байна.
- ГОТИ-ийн баталгаагүй ундны ус хэрэглэх байдал нь дулааны улиралд хүйтний улирлынхаас 2 дахин илүү байна.
- Түр хоноглох төвүүдэд байгаа ГОТИ өдөр бүр хооллох, унтаж амрах, ариун цэвэр сахих суурь хэрэгцээнүүдээ 80-аас дээш хувийн сэтгэл ханамжтайгаар хангаж чадсан байхад, түр хоноглох төвөөс гадуур байгаа ГОТИ сүүлийн 7 хоногт дунджаар 2.2 хоногт нь л халуун хоол идсэн, 1.9 хоногт нь зориулалтын бие засах газарт орсон, 1.7 хоногт нь бүтэн нойртой, тухтай унтаж чадсан, 2.5 хоногт нь гараа савандаж угаасан, сүүлийн 1 сард халуун усанд орсон дундаж тоо нь 1 ч хүрэхгүй байна.

Судалгаанд хамрагдсан ГОТИ-ийн тогтсон гэр оронгүй, тэнэмэл байдлаар амьдарсан хугацаа нь дунджаар 9.8 жил байна. Судалгаанд хамрагдсан ГОТИ дунд хамгийн багадаа 1 жил хүрээгүй, хамгийн ихдээ 51 жил гэр оронгүй амьдарсан хүмүүс байгаагаас харвал, Улаанбаатар хот дахь ГОТИ-ийн хэсүүчлэн амьдрах асуудал нь нэлээд ужгирсан болох нь харагдлаа. Ялангуяа А1 бүлгийн иргэд (дунджаар 10.1 жил) А2 бүлгийнхнээс илүү урт хугацаагаар тогтсон гэр оронгүй, хэсүүчлэн амьдарсан байдалтай байна.

Хүснэгт 4.2.1. ГОТИ-ийн хэсүүчлэн амьдарч буй хугацааны статистик үзүүлэлтүүд, хүн ам зүйн шинж байдлаар


Хүн ам зүйн шинж байдал	Гэр оронгүй амьдарч буй хугацаа (жил)				Хариулагчдын тоо
	Дундаж	Хамгийн бага	Хамгийн их	Медиан	
Судалгаанд оролцогчдын бүлэг					
Түр хоноглох төвд байгаа ГОТИ	10.1	0.0	35.0	7.0	300
Түр хоноглох төвөөс гадуурх ГОТИ	9.0	0.0	51.0	5.0	100
Хүйс					
Эрэгтэй	9.8	0.0	51.0	7.0	348
Эмэгтэй	9.5	0.0	35.0	5.5	52
Насны бүлэг					
19-35	5.2	0.0	22.0	3.0	39

36-45	9.3	0.0	31.0	6.0	117
46-55	9.9	0.0	35.0	8.0	144
56+	12.0	0.0	51.0	7.0	100
Гэрлэлтийн байдал					
Гэрлээгүй	10.0	0.0	28.0	5.0	104
Гэрлэсэн/хамтран амьдрагчтай	9.0	0.0	31.0	7.0	63
Салсан/тусгаарласан	9.5	0.0	35.0	7.0	195
Бэлэвсэн	12.1	1.0	51.0	10.0	38
Боловсролын түвшин					
Боловсролгүй/бага	10.5	0.0	29.0	7.0	63
Суурь	11.0	0.0	51.0	9.0	104
Бүрэн дунд	9.3	0.0	35.0	6.5	146
Тусгай дунд/дээд	8.6	0.0	35.0	5.0	87
Нийт ГОТИ	9.8	0.0	51.0	7.0	400*

Тэмдэглэл: 5 иргэн мэдээллээ дутуу өгсөн тул хасч тооцсон.


Нийслэлд байгаа гэр оронгүй, тэнэмэл 10 хүн тутмын 4 нь урьд өмнө өөрийн гэсэн гэр оронгүй, хамаатан/найзындаа болон түрээсийн байр/гэрт байсан, эсхүл засан хүмүүжүүлэх болон асрамжийн газраас гарсан иргэд байна. Судалгаанд хамрагдсан ГОТИ одоогийн замд орохоос өмнө хаана/хэнийд амьдарч байсныг асуухад дийлэнх буюу 10 хүн тутмын 6 нь өөрийн хашаа гэр, хашаа байшин, орон сууцтай байсан, 3 нь нь түрээсийн байр/гэр, хамаатан, танилынд, 1 нь анхнаасаа өөрийн гэсэн гэр оронгүй, засан хүмүүжүүлэх газар, асрамжийн газарт амьдарч байсан иргэд байна. Иймд асрамжийн газар болон засан хүмүүжүүлэх газраас гарч буй иргэдийг нийгэмд бие даан амьдрахаар гарах үед гэр орон зэрэг суурь хэрэгцээгээ хангахад нь анхаарсан хөтөлбөр, бодлогыг боловсруулж, хэрэгжүүлэх шаардлага байгаа нь харагдаж байна. Мөн гэр оронгүй тэнэмэл 10 хүн тутмын 3 нь урьд нь түрээсийн байр/гэрт амьдарч байсан иргэд байгаа нь хувь хүний хүчин зүйлээс гадна Улаанбаатар хотод орон байр, өргөн хэрэглээний барааны өртөг өндөр, ядуурал өндөр байгаатай холбоотой болов уу.

Зураг 4.2.1. ГОТИ-ийн хувийн жин, гэр оронгүй болохоос өмнө хэнийд/хаана амьдарч байснаар



ГОТИ-ийн хувьд цаг агаар, улирлын байдлаас хамааран өөр өөр газар, байр/оромж зэрэгт амьдардаг нь туршилтын судалгаанаас харагдсан тул бид судалгаанд хамрагдсан ГОТИ-ийн одоогийн амьдарч буй гэр орны байдлыг судлахдаа дулааны болон хүйтний үед гэж ялган судалсан. Ялангуяа Монгол Улс жилийн дөрвөн улиралтай, улирал хооронд цаг агаарын хэмийн ялгаа ихтэй, өвөлдөө эрс хүйтэн бөгөөд дулаан гэр оронгүйгээр хүн амьд байх боломжгүй онцлогтой. Тус онцлогийг харгалзан Монгол Улсын Засгийн газраас гэр оронгүй иргэдийг осгож амь насаа алдахаас сэргийлэх үүднээс түр хоноглох байр ажиллуулах хөтөлбөрийг улсын болон ТББ-аар дамжуулан хэрэгжүүлдэг. Тэгвэл Улаанбаатарт байгаа ГОТИ сүүлийн нэг жилд тус хөтөлбөрт хамрагдсан байдал, хамрагдаагүй бол өөр хаана хоноглож байсан талаарх мэдээллийг **Зураг 4.2.2-т** харуулав.

Зураг 4.2.2. ГОТИ-ийн хувь, сүүлийн нэг жилд хоноглосон орон байрны төрлөөр.
А. Дулааны үед (4-10 сард) **Б. Хүйтний үед (11-3 сард)**



Тэмдэглэл: хариулагч олон хариулт хэлж болох асуулт тул хариултын нийлбэр 100%-аас илүү.

ГОТИ дулааны үед гудамж, зуслан, ой мод, голын эрэг, орон сууцны орц хонгил, хонгил зэрэгт, харин хүйтний үед ТББ, сүм хийд, улсын байгууллагын ажиллуулдаг түр хоноглох төвүүд болон хамаатан/найз/танил айлд ихэвчлэн хоноглодог байна. Улаанбаатарт байгаа судалгаанд хамрагдсан ГОТИ-ийн хамгийн их хоноглодог газрууд нь дулааны үед гудамж, зуслангийн задгай газар/эзгүй байр, ой мод, голын эрэг/бургас (түр хоноглох төвд байгаа иргэдийн 33.1 хувь, төвд байрлаагүй иргэдийн 49 хувь) зэрэг байна. Түүнчлэн давхардсан тоогоор түр хоноглох төвд байгаа ГОТИ-ийн 27.6 хувь, төвөөс гадуур байгаа ГОТИ-ийн 63 хувь нь орон сууцны орц,

хонгил, хонгил зэрэгт хоноглосон нь бусад төрлийн хариултаас өндөр хувьтай байна. Дээрх газруудаас гадна шөнө ажилладаг үйлчилгээний байгууллагууд, нүхэн гарц, траншейн, хогийн цэг (эдгээр нь судалгааны үед түр хоноглох төвөөс гадуур байрлаж байсан ГОТИ-ийн дунд илүү), манаачийн шовгор/ажлын байр, нийтийн байр (түр хоноглох төвд байрладаг ГОТИ-ийн дунд илүү) зэрэг газруудад ГОТИ хоноглодог байна. Хүйтний улиралд, цаг агаарын эрс хүйтнийг давж гарахын тулд ГОТИ-ийн ихэвчлэн хоноглодог газрууд нь ТББ-ын ажиллуулдаг түр хоноглох төвүүд (түр хоноглох төвд байгаа иргэдийн 67.5 хувь, төвөөс гадуур байгаа иргэдийн 11.0 хувь), төрийн байгууллагын ажиллуулдаг түр хоноглох төв (түр хоноглох төвд байгаа иргэдийн 27.7 хувь, төвөөс гадуур байгаа иргэдийн 3.0 хувь), хамаатан найз, танилынх (15.1-23 хувь) зэрэг эх үүсвэрүүд байв.

ГОТИ тогтвортой ундны усны эх үүсвэргүй, ихэвчлэн олон төрлийн эх үүсвэрээс гуйх байдлаар усны хэрэгцээгээ хангадаг ба энэ байдал түр хоноглох төвүүдэд байгаа ГОТИ-гэй харьцуулахад төвүүдэд байрлаагүй ГОТИ-ийн дунд илүү байна. Дулааны үед ГОТИ-ийн 79.4 хувь, хүйтний үед 86.9 хувь нь өөрсдийн хоол, унданд хэрэглэдэг усаа айл өрх, албан байгууллагын болон нийтийн ус түгээх байр, орон сууц, хонгилийн гэх мэт төвлөрсөн шугамаас ихэнхдээ гуйж авдаг ба энэ хандлага А2 бүлгийнхэн дунд А1 бүлэгтэй харьцуулахад бараг 2 дахин өндөр байна. Мөн эрүүл ахуйн хувьд баталгаат эх үүсвэр болох нийтийн худаг/ус түгээх байр, хамгаалагдсан хувийн худгууд, хамгаалагдсан булаг шанд зэрэг эх үүсвэрээс усны хэрэгцээгээ хангадаг А2 бүлгийнхний хувь (дулааны үед 3-17 хувь, хүйтний үед 4-16 хувь) А1 бүлгийнхнээс дулааны үед 2.4-3.6 дахин, хүйтний үед 1.8-3.3 дахин доогуур, харин хаягдал савтай ус гэх мэт эх үүсвэрийн ус хэрэглэх байдал нь А2 бүлгийнхэн дунд А1 бүлгийнхнээс 3.2-4.1 пунктээр өндөр байна. Эдгээрээс, ундны усаар тасалдахгүй байх, ариун цэврийн баталгаа хангагдсан усыг хоол хүнсэндээ хэрэглэх зэрэг “ундны усны аюулгүй байдал”-ын асуудал ГОТИ-ийн, ялангуяа А2 бүлгийн иргэдийн хувьд анхаарал татсан хэмжээнд байгааг дүгнэж болохоор байна.

Түр хоноглох төвөөс авсан ихэнх үйлчилгээнийхээ талаар НХТТ болон ТББ-ын төвүүдэд байгаа ГОТИ-ийн аль аль нь 80-аас дээш хувьтай “сайн” гэсэн сэтгэл ханамжийн үнэлгээ өгсөн байна. Гэхдээ улсын болон ТББ-ын ажиллуулдаг түр хоноглох төвүүдээр үйлчлүүлж буй иргэдийн сэтгэл ханамж зарим үзүүлэлт дээр хоорондоо бага зэрэг ялгаатай байна. Тухайлбал, хоол цайны тоо, хэмжээ, чанар, орон байрны тав тух, ариун цэврийн үйлчилгээ, эрүүл мэндийн үйлчилгээ зэрэг материаллаг хангамжтай холбоотой үйлчилгээний тухайд “сайн” үнэлгээ өгсөн хувь нь ТББ-уудын ажиллуулдаг түр хоноглох төвүүдэд илүү байсан бол соёлын ба мэдээллийн үйлчилгээ, сэтгэл зүйн эмчилгээ зэрэг үйлчилгээний тухайд НХТТ-д илүү байлаа. Харин ажилтнуудын зан харилцаа, мэргэжлийн ур чадвар зэрэг үзүүлэлтүүд дээр “сайн” үнэлгээ өгсөн байдал улсын ба ТББ-ын түр хоноглох төвөөр үйлчлүүлэгчдийн хувьд бараг ялгаагүй байна. Эдгээр үйлчилгээнээс гадна зарим ТББ-ын ажиллуулдаг төвүүдэд ГОТИ-ийг ажил мэргэжлийн дадалтай болгох, ажилд зуучлахад чиглэсэн үйл ажиллагаа хэрэгжүүлдэг ба ТББ-ын төвөөр үйлчлүүлж буй нийт ГОТИ-ийн 27-43 орчим хувь нь уг үйлчилгээг

авсан, тэдний дийлэнх (21.2-38.5 хувь) нь сэтгэл ханамжаа “сайн” гэж илэрхийлсэн байна. Энэ талаар чанарын судалгааны оролцогчид мөн эерэг сэтгэгдлээ багагүй илэрхийлж байсан.

Зураг 4.2.3 ГОТИ-ийн амьдралын нөхцөл, түр хоноглох байрын төрлөөр



Шинэ амьдрал ялагч ТББ-ын түр хоноглох төв



НХТТ-ийн эрчүүдийн өрөө

Шигтгээ 4.2.1:

... Энэ газарт ирснээс хойш ирээдүйдээ итгэх итгэл төрж эхэлж байна. Энд биднийг маш сайн асардаг, бараг хүүхдээ асарч байгаа юм шиг л ...

Ганцаарчилсан ярилцлагаас, 48 настай, эрэгтэй, ТББ-ын түр хоноглох байр

ГОТИ-тэй хийсэн ганцаарчилсан болон бүлгийн ярилцлагуудаас харахад нийтлэг зүйл нь тэд архины хамаарал ихтэй, хэсэг бүлгээрээ хамтарч байдаг, амьдралын тодорхой зорилго багатай, албан бус салбарын орлого багатай тогтмол бус ажил эрхэлж бага орлого олдог ч орлогоо ихэвчлэн архинд зарцуулдаг байна. Мөн хоол хүнс, хувцасны хэрэгцээгээ хангахдаа хаягдал хүнс, хувцас ихэвчлэн хэрэглэдэг, усанд орох, ариун цэвэр сахих зэрэг нь бараг боломжгүй, нэн хүнд байдаг нь харагдсан. Хүний суурь хэрэгцээгээ хангах байдал нь хангалтгүйгээс ГОТИ ажил хөдөлмөр олж чадахгүй байх, сэтгэл зүйн хувьд амар тайван биш байх, гадуурхагдах, дээрэлхэлт, аюулд өртөх зэрэг эрсдэлтэй, сөрөг нөхцлүүд ч бий болдог байна

Хүснэгт 4.2.2. Судалгааны үед түр хоноглох төвөөр үйлчлүүлж байсан ГОТИ-ийн хувийн жин, тухайн төвийн үйлчилгээний талаарх сэтгэл ханамжаар

Түр хоноглох байрнаас авсан үйлчилгээний төрөл	Улсын түр хоноглох төвөөр үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамж					Бүгд	Хариулагчдын тоо	ТББ-ын түр хоноглох төвөөр үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамж					Бүгд	Хариулагчдын тоо
	сайн	дунд	муу	Мэдэхгүй	Тухайн үйлчилгээ үзүүлээгүй			сайн	дунд	муу	Мэдэхгүй	Тухайн үйлчилгээ үзүүлээгүй		
Хоол цайны тоо, хэмжээ	79.7	14.9	5.4	0.0	0.0	100.0	74	96.2	3.0	0.4	0.4	0.0	100.0	231
Хоол, цайны чанар	89.1	9.5	1.4	0.0	0.0	100.0	74	97.0	2.2	0.4	0.4	0.0	100.0	231
Орон байрны тохь тух	87.8	10.8	1.4	0.0	0.0	100.0	74	96.1	2.6	0.4	0.9	0.0	100.0	231
Ариун цэврийн үйлчилгээ	89.2	8.1	2.7	0.0	0.0	100.0	74	93.5	5.2	0.0	0.9	0.4	100.0	231
Эрүүл мэндийн үйлчилгээ	81.0	12.2	1.4	4.1	1.4	100.0	74	86.6	2.6	0.0	1.7	9.1	100.0	231
Соёлын, мэдээллийн үйлчилгээ	91.8	4.1	2.7	1.4	0.0	100.0	74	87.9	3.5	0.0	1.7	6.9	100.0	231
Сэтгэл зүйн эмчилгээний үйлчилгээ	81.0	4.1	2.7	4.1	8.1	100.0	74	72.7	6.9	0.9	3.9	15.6	100.0	231
Ажилтнуудын зан харилцаа	93.2	5.4	1.4	0.0	0.0	100.0	74	92.6	3.5	0.9	2.6	0.4	100.0	231
Ажилтнуудын мэргэжлийн ур чадвар	89.2	5.4	0.0	5.4	0.0	100.0	74	88.8	6.9	0.0	3.9	0.4	100.0	231
Ажилд зуучлах	21.5	4.1	0.0	12.2	62.2	100.0	74	38.5	3.5	0.9	6.5	50.6	100.0	231
Ажил, мэргэжлийн дадал олгох	13.4	4.1	0.0	12.2	70.3	100.0	74	21.2	4.8	0.9	10.4	62.7	100.0	231

4.3. Гэр оронгүй, тэнэмэл иргэдийн эрүүл мэндийн байдал

Судалгаанд хамрагдсан ГОТИ-ийн эрүүл мэндтэй холбоотой дараах анхаарах зүйлс байна:

- ГОТИ-ийн 74.8% нь биедээ ямар нэг өвчин, зовиуртай байна. Тэд зүрх судасны эрхтэн тогтолцоо, үе мөч, осол гэмтлийн төрлийн өвчлөлөөр хамгийн түгээмэл (харгалзан 32.8%, 27.9% 25.9%) өвдсөн байна.
- ГОТИ-ийн дундах хөгжлийн бэрхшээлд өртсөн түвшин (27.9%) улсын дундаж үзүүлэлт (3.3%)-ээс өндөр байна.
- ГОТИ-ийн дунд Ковид19-өөр өвчилсөн түвшин (11.6%) байсан ба ГОТИ-ийн 62.2% нь Ковид19-ын вакцины II буюу бүрэн тундаа хамрагдсан.
- ГОТИ-ийн 18.3% нь өвдсөн ч эмнэлэгт очдоггүй, эмнэлэгт хандсан хүмүүс хамгийн ихээр Энэрэл эмнэлэг (28.9%), өрхийн эмнэлэг/улсын эмнэлэг (25.9%), сүмийн эмч/эмнэлэг (6.9%) зэрэгт ханддаг ба ГОТИ эрүүл мэндийн үйлчилгээ авахад бичиг баримтгүй, даатгалгүй, гадуурхалд өртдөг зэрэг саад бэрхшээлтэй элбэг тулгардаг.

Бид судалгаанд хамрагдсан ГОТИ-ийн эрүүл мэндийн байдлыг дүгнэхдээ, аливаа өвчний шинж тэмдэг илэрч байгаа талаарх судалгаанд оролцогчдын өөрсдийн өгүүлэмжид нь суурилан авч үзсэн. ГОТИ-ийн мэдээлсэн өвчин, зовиуруудаас дүгнэхэд, тэдний дунд хамгийн их зонхилж буй 5 өвчлөл, зовиурт 1) зүрх судасны эрхтэн тогтолцооны өвчин, 2) үе мөчний өвчин, 3) осол, гэмтэл, 4) толгой өвдөх, 5) элэг, цөс ходоод өвдөх зэрэг орж байна. Судалгаагаар авч үзсэн өвчин, зовиурууд гадуур хэсүүчлэн хоноглож байгаа ГОТИ-ийн дунд түр хоноглох төвүүдэд байгаа ГОТИ-ийнхээс өндөр, мөн осол гэмтэл, бусдад зодуулж гэмтэх зэргээс бусад төрлийн өвчин, зовиур илэрсэн байдал эмэгтэй ГОТИ-ийн дунд эрэгтэйчүүдийнхээс өндөр байна. Иймд, гадуур хэсч хоноглодог, эмэгтэй ГОТИ эрүүл мэндийн хувьд илүү хүнд байдалд байна.

Судалгаанд оролцсон ГОТИ-дэд илэрч буй өвчний шинж тэмдгүүд дунд зүрх судасны эрхтэн тогтолцооны өвчний үед илрэх шинж тэмдгүүд хамгийн их (32.8%) байна. Тухайлбал, хүзүү хөшиж өвдөх, нүд бүрэлзэх, даралт ихсэх, зовиуртай байх нь зүрх судасны эрхтэн тогтолцооны өвчлөлийн гол шинжүүд байдаг бөгөөд эдгээр шинжүүд удаан хугацаагаар илрэх, биед зовиуртай байх нь тархинд цус харвах, түүнээс үүдэлтэй биед таллан болон бүтнээр саажилт үүсэх, цаашлаад зүрхний шигдээс гэнэт болж нас барах гэх зэрэг эрсдэлтэй юм. Дээрх өвчний шинж тэмдэг ГОТИ-ийн байрлаж буй газар, хүйсээр хэр ялгаатай байгааг харвал, гадуур хоноглож буй ГОТИ-ийн дунд (37 хувь) түр хоноглох төвүүдэд байгаа ГОТИ-ийнхээс 5.5 пунктээр (Зураг 4.3.1), эмэгтэйчүүдийн дунд (42.3 хувь) эрэгтэйчүүдийнхээс 10.9 пунктээр их байгаа нь гадуур хэсдэг, эмэгтэй ГОТИ зүрх судасны эрхтэн тогтолцооны өвчлөлд өртөх илүү эрсдэлтэй байгааг харуулж байна.

Зураг 4.3.1. ГОТИ-ийн хувь, судалгааны үед илэрч байсан өвчин/зовиураа нэрлэсэн байдлаар, амьдарч буй байршлаар.



Тэмдэглэл: хариулагч олон хариулт хэлж болох асуулт тул хариултын нийлбэр 100%-аас илүү.

Тухтай, тайван, тогтмол унтах газар байхгүйн улмаас жижиг зайнд, хүйтэнд, атирч, нугаларч, шахаж хэвтэх, унтах, суух зэргээс үүдэлтэй үе мөчөөр өвддөг болох, хавдах, шингэн том жижиг үенд хуралдах зэрэг зовиурууд илэрч болдог. **Нийт ГОТИ-ийн дунд үе мөчөөр өвдөх, улайх, хавагнах зовиуртай хүмүүс 27.9 хувийг** (Түр хоноглох төвүүд дээр байрлаж байгаа ГОТИ-ийн 26.2 хувь, гадуур хонголодог ГОТИ-ийн 33 хувь) эзэлж байгаа нь тэдний дунд илэрч буй хоёр дахь түгээмэл өвчлөлийн төрөл байна. Уг өвчлөл, зовиурыг хариулагчдын хүйсээр ялган харвал, эмэгтэйчүүдийн дунд (36.5 хувь) эрэгтэйчүүдийнхээс (26.6 хувь) илүүтэй илэрсэн байна. Тогтмол амьдрах гэр оронтой болсноор ГОТИ амьдралын суурь хэрэгцээний нэг болох дулаан тухтай орчинд унтаж амрах, хөл гараа бүтэн тэнийлгэх хэрэгцээгээ хангах боломжтой болох юм. Судалгаагаар, хүйтний улиралд архи ууж, ухаанаа алдан гудамжинд унтсанаар хөл гараа хөлдөөсөн, хурууны үзүүрүүдийг тайруулсан гэсэн хэд хэдэн тохиолдолтой таарсан бөгөөд, түүнээсээ болж ажил хөдөлмөр хийх боломжгүй, зарим тохиолдолд амьдралын наад захын хэрэгцээ болох хувцасаа өмсөх, нүүр гараа угаах, хоолоо өөрөө идэх боломжгүй болсон байсан нь ихээхэн эмгэнэлтэй явдал байв (**Шигтгээ 4.3.1**).

Шигтгээ 4.3.1:

...Би 2 жилийн өмнө машинд мөргүүлээд, хөлөө хадуулсан, хадаастай хөл явж болдоггүй, нугалж болдоггүй, одоо хүртэл эдгэж аниагүй. Архиа уух юм бол өвчнөө мэдэрдэггүй. Архиа бага уувал хөдөлж чаддаггүй...

Фокус бүлгийн ярилцлагаас, эрэгтэй, улсын түр хоноглох байр - НХТТ


Архи согтууруулах ундаа их хэрэглэдэг, шим тэжээлтэй хоол хүнс тогтмол хэрэглэж чаддаггүй, олдсон зүйлээ л иддэг гэх зэрэг олон шалтгааны улмаас хоол боловсруулах эрхтэн тогтолцооны эмгэг, өвчтэй байх магадлал ГОТИ-ийн дунд түгээмэл байна. Хоол боловсруулах эрхтэн тогтолцооны өвчтэй, өөрчлөлтэй байгаа байдал (24.2 хувь) нь ГОТИ-ийн дунд түгээмэл илэрч буй өвчин, зовиуруудын 5-р байранд байна. Судалгаанд оролцогсдын маш өндөр хувь нь архи, цогтууруулах ундаа тогтмол хэрэглэдэг, хамааралтай байгаа нь хоол боловсруулах замын өвчний хүндрэлээр нас барах эрсдэл маш өндөр байна гэсэн үг юм.

Судалгаанд хамрагдсан ГОТИ-ийн дундах хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хувь 27.9 хувь байгаа нь улсын дунджаарх хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хувиас 8 дахин өндөр байна (3.3%). Хөгжлийн бэрхшээлтэй байдал ГОТИ-ийн хүйсийн байдлаар онцын ялгаагүй ч 46-аас дээш насны ГОТИ дунд (32.4-36.1 хувь) бусад насныхнаас илүү өндөр байна. Хөгжлийн бэрхшээлийг төрлөөр нь ангилан харвал давхардсан тоогоор нийт ГОТИ-ийн 12.6 хувь харааны, 12.3 хувь хөдөлгөөний бэрхшээлтэй байгаа нь хамгийн түгээмэл тохиолдсон бэрхшээлүүд байв.

ГОТИ-ийн дунд Ковид19 өвчлөлийн түвшин 11.6 байна. Хариулагчдын хүн ам зүйн шинжээр нь ялган харвал, түр хоноглох төвд байгаа, эрэгтэй, 45-аас доош насны ГОТИ-ийн дунд Ковид19-ийн халдвараар өвдсөн байдал бусад бүлгийнхнээс өндөр хувьтай байна. Тухайлбал, **Зураг 4.3.2**-оос харахад, түр хоноглох төвд байрлаж байгаа ГОТИ-ийн Ковид19 халдвараар өвдсөн байдал (13.1 хувь) гадуур хэсч хоноглодог ГОТИ-ийнхээс 1.8 дахин их, эрэгтэйчүүдийн өвдсөн байдал (12.2 хувь) эмэгтэйчүүдийнхээс 1.5 дахин их, 19-45 насныхны өвдсөн байдал (12.5-16.0 хувь) 56-аас дээш насныхнаас 1.8-2.3 дахин өндөр байна. Ийнхүү ГОТИ дунд халдварт өвчнөөр өвчилсөн түвшин өндөр байгааг олон хүчин зүйлтэй холбон тайлбарлаж болно. Тухайлбал, судалгааны явцын ажиглалтаар түр хоноглох төв дээр олон хүн бөөгнөрөн байрлах, нэг өрөөнд, гэрт бүлгээрээ байх зэрэг нь халдварт өртөх эрсдэлийн нэмэгдүүлж болох нөхцөл байсан. Мөн ГОТИ тогтсон гэр оронгүй, ариун цэврийн наад захын стандарт бүрдээгүй орчинд хоноглож амьдардаг, ихэнхдээ албан бус салбарын ажил эрхэлж орлого/амьжиргаагаа залгуулдаг, орлого багатай иргэд байгаа тул Ковид19-ийн хатуу дэглэмийн үед ариун цэвэр сахих, нэг удаагийн маск хэрэглэх зэрэг халдвар хамгааллын наад захын дэглэмийг мөрдөхөд ихээхэн хүндрэлтэй байсан талаараа чанарын судалгааны ярилцлагын үеэр илэрхийлж байсан. Иймд нийтийг хамарсан халдварт өвчин тархах эрсдэлтэй үед ГОТИ гэх мэт эмзэг бүлгийн иргэд рүү онцгойлон чиглэсэн зарим хамгааллын арга хэмжээг гамшгийн үед төрөөс хэрэгжүүлдэг бодлого, үйл ажиллагааны баримт, бичгүүдэд тусган хэрэгжүүлдэг байх нь зүйтэй гэж судлаачдын зүгээс үзэж байна. Тухайлбал, бичиг баримтгүй, банкны дансгүй ГОТИ төрийн халамжид хамрагдах боломжийг бий болгох, ТББ ба олон нийтийн оролцоонд түшиглэн маск/наад захын эм хэрэгсэл, орон байр, хоол хүнсний тусламжийн арга хэмжээ хэрэгжүүлэх гэх мэтийг хэрэгжүүлж болох юм. Монгол Улсад Ковид19-ийн халдвараас урьдчилан сэргийлэх вакциныг иргэдэд үнэ төлбөргүй хийсэн ба энэ үйл ажиллагаанд ГОТИ ч тодорхой хэмжээнд хамрагдсан байна. Хариулагчдын өгсөн

мэдээллээр, аль ч тундаа хамрагдаагүй ГОТИ нийт хариулагчдын 8.4 хувийг л эзэлж байсан ба давхардсан тоогоор 62.2 хувь нь II тун, 58.5 хувь нь III тундаа хамрагдсан байсан.

Зураг 4.3.2. ГОТИ-ийн хувийн жин, Ковид-19-өөр өвдсөн эсэх, хүн ам зүйн шинжээр



Бид судалгаагаар ГОТИ-ээс “өвдсөн үедээ ихэвчлэн ямар эмнэлэгт ханддаг” талаар асуухад, 17.3 хувь нь өвдөөгүй тул эмнэлэгт хандаагүй, **18.3 хувь нь өвдсөн ч эмнэлэгт очдоггүй** гэсэн байна. Харин эмнэлэгт хандсан хүмүүс эмзэг бүлгийн иргэдэд баримт бичиг шаардахгүйгээр үйлчилгээ үзүүлдэг Энэрэл эмнэлэг (28.9 хувь), мөн өрхийн эмнэлэг/улсын эмнэлэг (25.9 хувь), сүмийн эмч/эмнэлэг (6.9 хувь) зэрэгт ханддаг гэсэн мэдээллийг өгчээ. Эндээс, өвдсөн ГОТИ-д хамгийн ойр эрүүл мэндийн байгууллага бол Энэрэл эмнэлэг болох нь харагдсан. Тус эмнэлгийн талаар чанарын судалгааны үеэр ч оролцогчид эерэг сэтгэгдэл цөөнгүй хэлж байсан. Энэрэл эмнэлэг эмнэлэг төвүүдэд очиж үзлэг, тусламж үйлчилгээ үзүүлэхээс гадна эмнэлэг дээрээ хүлээн авч үйлчилдэг. Өвдсөн ч эмнэлэгт очдоггүй ГОТИ-ээс эмнэлэгт ханддаггүй шалтгааныг асуухад, давхардсан тоогоор 52.7 хувь нь өөрийгөө аргалж, эмчилдэг, 31.1 хувь нь эрүүл мэндийн даатгалгүй, 29.7 хувь нь бичиг баримтгүй, 17.6 хувь нь хүлээн авдаггүй/гадуурхагддаг, 13.5 хувь нь мөнгөгүй, 12.2 хувь нь бусад хүн тусалдаг зэрэг шалтгааныг хэлсэн байна. Чанарын судалгааны явцад ч ГОТИ өвдөөд эмнэлэгт очиход хүлээж авдаггүй, сэжиглэдэг, өмссөн хувцас байгаа байдлаар гадуурхдаг гэсэн хариулт цөөнгүй байсан. Эдгээрээс, ГОТИ эрүүл мэндийн үйлчилгээ авахад бичиг баримт, даатгалгүй, гадуурхалд өртдөг зэргээр багагүй саад бэрхшээлтэй тулгардаг нь харагдлаа.

4.4. Гэр оронгүй, тэнэмэл иргэдийн ажил эрхлэлт, орлого, амьжиргаа


ГОТИ-ийн ажил эрхлэлт, орлого, амьжиргааны байдал дараах гол онцлогтой байна:

- ГОТИ бүгд хөдөлмөрийн насны хүмүүс байгаа ч дөнгөж 43.0% нь ажиллах хүчинд оролцож (үүний 35.6% нь ажил эрхэлсэн, 7.4% нь ажил эрхлээгүй ч ажил хайсан, ажил хийхэд бэлэн байсан), 57% нь ажиллах хүчнээс гадуур байна.
- ГОТИ-ийн ажил эрхлэлтийн түвшин 17.2 хувь байгаа нь улсын дунджаас 2 дахин их байна
- Ажил эрхэлсэн түр хоноглох байрны ГОТИ-ийн сарын дундаж орлого 475.4 мянга, гадуур хоноглож буй ГОТИ-ийнх 281.7 мянга байгаа нь улсын дунджаарх ажил эрхэлж буй иргэдийн орлогоос 3.0-5.1 дахин бага байна.
- Ажил эрхэлсэн эрэгтэй ГОТИ-ийн дундаж орлого эмэгтэйчүүдийнхээс 37.2%-иар илүү байна.
- Нас ахих тусам, мөн боловсролын түвшин бага байх тусам ГОТИ-ийн орлогын хэмжээ багасч хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс доогуур цалин/орлоготой ажиллах нь түгээмэл байна
- Ажилгүй ГОТИ-ийн ажилгүй байгаа хамгийн түгээмэл шалтгаан нь архинд донтолт байна.
- Түр хоноглох байрууд гэр оронгүй хүмүүсийг хүйтний улиралд олноор нь хүлээж авч, тэдний анхдагч хэрэгцээ болох хоол хүнс, гутал хувцас, хоноглох байрыг хангах тал дээр ихээхэн үүрэг гүйцэтгэж байна. Гэвч түр хоноглох байрнаас гадуур байгаа ГОТИ тогтворгүй орлого, хаягдал болон ТББ-уудаас олгодог үнэгүй хоол, хувцсаар хэрэгцээгээ хангаж байна.

ГОТИ бүгд хөдөлмөрийн насны хүмүүс байгаа ч дөнгөж 43.0 хувь нь сүүлийн 3 сард дор хаяж 7 хоног эдийн засгийн идэвхтэй (үүнээс 35.6 хувь нь ажил эрхэлсэн, үлдсэн 7.4 хувь нь ажилгүй ч ажил хайж, олдвол хийхэд бэлэн байсан), харин 57 хувь нь эдийн засгийн идэвхгүй буюу ажиллах хүчнээс гадуур байжээ. Ажиллах хүчнээс гадуурх ГОТИ өндөр насны тэтгэвэр тогтоолгосон, хөгжлийн бэрхшээлтэй, ажил хийх итгэл алдарсан зэрэг шалтгаанаар ажил эрхлээгүй, эсхүл тухайн хугацаанд ажил хийхэд бэлэн биш/боломжгүй, мөн ажил хийх сонирхолтой, боломжтой ч ажил хайх оролдлого хийгээгүй идэвхгүй хүмүүс байв. Түр хоноглох байранд байсан иргэдийн 39.3 хувь эдийн засгийн идэвхтэй (үүнээс 33.4 хувь нь ажил эрхэлсэн) байхад, гадуур хоноглодог иргэдийн 54 хувь эдийн засгийн идэвхтэй (үүнээс 42.0 хувь ажил эрхэлсэн) байна.

Гадуур хоноглож буй ГОТИ түр хоноглох байранд байгаа ГОТИ-ээс илүү эдийн засгийн идэвхтэй мэт боловч ихэнх нь эдийн засгийн албан бус салбарт ажилласан байна. Түр хоноглох байрнаас ГОТИ-ийг ажилд зуучилдаг бөгөөд энэ нь А1 бүлгийн иргэдийг албан салбарт ажил хийх боломжийг нэмэгдүүлдэг болох нь **Зураг 4.4.1**-ээс харагдаж байна. Ажил эрхэлсэн ГОТИ-ийн дунд албан салбарт хамгийн түгээмэл эрхэлсэн ажлуудыг авч үзвэл, нэгдүгээрт байгууллагын туслах ажил орж байгаа бөгөөд түр хоноглох байраар үйлчлүүлж буй ажил эрхэлсэн иргэдийн 17.6 хувь, харин албан бус салбарт хамгийн түгээмэл эрхлэгдэж байгаа ажлуудаас дурдвал, хогийн цэг дээрээс юм цуглуулж зарах (А1 бүлгийнхний 3.9 хувь, А2 бүлгийнхний 33.3 хувь), хоёрдогч түүхий эд цуглуулж зарах (А1 бүлгийнхний 5.9 хувь, А2 бүлгийнхний 31 хувь) орж байна.


Зураг 4.4.1. Ажил эрхэлсэн ГОТИ-ийн хувь, эдийн засгийн салбараар, байрлаж буй газраар, хийсэн ажлын төрлөөр.



Тэмдэглэл: хариулагч олон хариулт хэлж болох асуулт тул хариултын нийлбэр 100%-аас илүү.

Түр хоноглох байранд байгаа, ажил эрхэлсэн ГОТИ-ийн олсон сарын дундаж хөлс нь 475.4 мянган төгрөг, харин гадуур хоноглодог ГОТИ-ийн дундаж хөлс нь 281.7 мянга байгаа нь **улсын дундаж цалин, хөлсний хэмжээтэй харьцуулахад, 3.0-5.1 дахин бага байна.** Ажил эрхэлсэн ГОТИ-ийн дунд гадуур хоноглодог болон настай хүмүүс хөдөлмөрийн хөлснөөс доогуур орлоготой ажиллах нь элбэг байна. **Зураг 4.4.2-** т насны бүлэг, боловсролын түвшингээр ГОТИ-ийн дундаж ажлын хөлсийг харьцуулан харуулсан. Ерөнхийдөө, нас ахих тусам ГОТИ-ийн орлого олох боломж буурдаг бол, боловсрол өндөр байх тусам орлого нэмэгдэх хандлага ажиглагдлаа. Тухайлбал, 19-35 насны залуучуудын дундаж орлого А1 бүлгийнхний хувьд 804 мянган төгрөг, А2 бүлгийнхний хувьд 470 мянган төгрөг байгаа нь тэднээс ахимаг насны бусад иргэдтэй харьцуулахад илт өндөр байна. ГОТИ-ийн дундаас хамгийн бага орлоготой ажиллаж байгаа хэсэг нь хувьд 56-аас дээш насныхан байна. ГОТИ-ийн сарын дундаж хөлсийг хүйсээр нь шинжлэхэд ерөнхий дунджаар эрэгтэйчүүд 435 мянган төгрөг, эмэгтэйчүүд 317 мянган төгрөгийн сарын орлоготой ажиллажээ. Өөрөөр хэлбэл **ГОТИ-ийн дунд эрчүүд нь эмэгтэйчүүдээс 37.2 хувиар илүү хөлстэй ажиллаж байгаа юм.**

Зураг 4.4.2. Мөнгөн хэлбэрээр цалинжсан ажил эрхэлсэн ГОТИ-ийн сард олдог ажлын дундаж хөлс, насны бүлэг болон боловсролын түвшингээр (мянган төгрөг)



Ажилгүйдлийн түвшин ГОТИ-ийн хувьд 17.2% байгаа нь улсын дунджаас (8.5%) хоёр дахин өндөр байна. Гадуур хоноглож буй ГОТИ-ийн хувьд энэ үзүүлэлт 22.2 хувь байгаа боло түр хоноглох байранд буй ГОТИ-ийн хувьд 15.0 хувь байна. Архинд донтох байдал нь гадуур хоноглодог орон гэргүй иргэдийн хувьд ажил эрхлэлтийг хязгаарлаж буй хамгийн түгээмэл хүчин зүйл болж байна. Ажил эрхлээгүй судалгаанд оролцогчдоос ажилгүй байгаа шалтгааныг тодруулахад, гадуур хоноглодог иргэдийн 36.2 хувь нь архианаас хамааралтай ажилгүй байсан бол түр хоноглох байранд амьдардаг иргэдийн дунд архины холбоотой ажилгүйдэл арай бага буюу 12.3 хувь байна.

Зураг 4.4.3. Ажил эрхлээгүй ГОТИ-ийн хувь, ажилгүй байгаа шалтгаанаар



Түр хоноглох байранд байгаа иргэдийн хувьд “Төв дээр ирээд удаагүй тул сургалтанд сууж байгаа” гэдэг нь ажил хийгээгүй хамгийн түгээмэл шалтгаан болж (32.5 хувь) байна. Ярилцлагын үеэр түр хоноглох байранд шинээр ирсэн хүмүүс эхний хэдэн сарын

хугацаанд сургалтанд суух шаардлагатай талаар дурдсан бөгөөд энэ үед гадуур ажиллах нь хориотой байдаг” гэж хариулсан.

Зарим ГОТИ мөнгөн бус хэлбэрээр буюу хоол хүнс, хувцас, хоноглуулах байраар хангуулах замаар ажлын хөлс авдаг байна. Судалгааны үр дүнгээр, ажил эрхэлж буй ГОТИ нь хөдөлмөрийн хөлсөө мөнгөн болон мөнгөн бус хэлбэрээр авдаг нь харагдсан. Тухайлбал, түр хоноглуулах байранд байрлаж ажилладаг хүмүүсийн 16.3 хувь мөнгөн бус хэлбэрээр, харин гадуур хоноглодог иргэдийн 4.8 хувь нь мөнгөн бус хэлбэрээр цалинжжээ.

Шигтгээ 4.4.1:

... Ковидын хорионы үед би орцны жижүүр хийж байсан. Цалинд хоол унд, 10 ширхэг маск гээд авчирч өгдөг байсан. Хоол хүнсэнд 5 кг будаа, 5 кг гурил, дотор махан таташ ногоог сардаа 1 удаа авдаг. Цалингийн мөнгө гэж байхгүй...

Ганцаарчилсан ярилцлага, нас 35, эмэгтэй, ТББ-ын түр хоноглох байр

A1 бүлэг буюу түр хоноглох байранд амьдардаг иргэдийн 61.5 хувь нь олсон орлогоо зөвхөн өөртөө зарцуулдаг, 22 хувь нь гэр бүлтэйгээ хуваалцдаг, 8.8 хувь нь найз/хамтрагчтайгаа хуваалцдаг гэж хариулсан байна. Нөгөө талаас A2 бүлгийн буюу гадуур хоноглодог орон гэргүй иргэдийн 55 хувь нь өөртөө л олсон орлогоо зарцуулдаг, 10 хувь нь гэр бүлтэйгээ хуваалцдаг, 35 хувь нь найзуудтайгаа хуваалцдаг гэж хариулжээ. Үүнээс үзэхэд түр хоноглох байранд байгаа иргэд ерөнхийдөө гэр бүлтэйгээ ойр байдаг бол, гадуур хоноглодог иргэд найзуудтайгаа илүү ойр байна. Ялангуяа гадуур хоноглож буй ГОТИ-ийн хувьд бүлгээрээ буюу хамтдаа нэг дор ажиллаж, идэж, унтдаг бөгөөд нөгөө талаас олсон орлогоо хоорондоо хуваалцдаг нь чанарын судалгаанаас харагдсан.


Шигтгээ 4.4.2:

... Өглөө босоод л шараа тайлна. Хоёр найзтайгаа хамт ажиллаад л хэдэн төгрөг олдог, Барс зах дээр бид нар хүний ачаа зөөгөөд өгчихдөг, ойр зуурын ногоо цэвэрлээд ялгаад өгч, мөнгө авдаг.

Фокус бүлгийн ярилцлагаас, эмэгтэй, ТББ-ын түр хоноглох байр

Түр хоноглох байр нь өвлийн улиралд ГОТИ-ийн анхдагч хэрэгцээг хангах хамгийн том эх үүсвэр нь болдог. Судалгааны үр дүнд түр хоноглох байруудад амьдардаг иргэдийн 89.2 хувь нь хүнс, 74.4 хувь хувцасны хэрэгцээгээ байрлаж буй төвөөсөө хангуулдаг гэж хариулсан байна. Нөгөө талаас гадуур хоноглодог тэнэмэл иргэд нь ТББ-уудын өгдөг үнэгүй хоол (66%), ресторан болон айлуудын хаядал (50%)-аар хүнснийхээ хэрэгцээг хангаж байна.

Зураг 4.4.4 ГОТИ-ийн хувь, хувцас, хүнсний хэрэгцээгээ хангадаг эх үүсвэрээр



Тэмдэглэл: хариулагч олон хариулт хэлж болох асуулт тул хариултын нийлбэр 100%-аас илүү.

Чанарын ярилцлагын үеэр ГОТИ-ийн ажил эрхлэлт, орлогын байдлыг сайжруулах чиглэлээр зарим ГОТИ өөрсдөө тодорхой бодол, төлөвлөгөө гаргасан, түүнд нь дэмжлэг хэрэгтэй, мөн ажил эрхлэлтийг зохион байгуулалтад оруулах, түр хоноглуулах байрны ойролцоо үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх боломжуудыг бий болгож, дэмжих, багаар нь ажиллуулахыг дэмжих, шат дараатайгаар ГОТИ-ийн бие даан амьдрах байдалд дэмжлэг үзүүлэх, архины хамаарлаас гарахад нь туслах арга хэмжээг хамт авах зэрэг саналуудыг ГОТИ онцолж байсан.

Ерөнхийдөө, **Ковид-19-ын нөхцөл байдал бүхий л иргэдийн ажил эрхлэлтэд сөргөөр нөлөөлсөн** ч гэсэн, түр хоноглуулах төвүүдэд байсан ГОТИ, орцны жижүүр хүмүүсийн орлого, хоол хүнсний хэрэглээнд харьцангуй бага нөлөөлсөн, харин төвөөс гадуур байсан иргэдэд илүү хүнд туссан байна.

Хүснэгт 4.4.1. ГОТИ-ийн орлого, хоол хүнсний байдалд үзүүлсэн COVID19-ын хорионы нөлөө

Түр хоноглуулах байрнаас гадуур байгаа ГОТИ-ийн хувьд:	Түр хоноглуулах байранд байсан ГОТИ-ийн хувьд:
...Гадуур бүх юм хаагдсан. Сэтгэл санаагаар их унасан. Бүх юм олодохоо больсон. Гитараа уул нь гудманд тоглохоор, хүмүүс 500, 1000 төг өгөөд, боломжийн байсан. Тэгээд КОВИД-ын үеэр гитараа зарахад хүрсэн дээ. <i>Ганцаарчилсан ярилцлага, 63 настай, эрэгтэй, Улсын түр хоноглох байр - НХТТ</i>	... Ковид тусах тухай айдас бид нарт байхгүй байсан, төвөөсөө гараагүй эндээ л байсан... <i>Фокус бүлгийн ярилцлагаас, эрэгтэй, ТББ-ын түр хоноглох байр</i>

<p>... Санхүүгийн асуудал гарсан. Нийтийн байр хөлсөлж амьдарч байгаад төлбөрөө төлж чадахгүй гудамжинд гарсан. Эгчийндээ түр амьдарч байсан, заримдаа гадуур. Ихэнхдээ орц, траншейнд байсан. Хог дээрээс л бүх зүйлээ болгодог байсан даа. Лааз түүдэг байсан ч сүүлдээ олохоо байсан.</p> <p><i>Ганцаарчилсан ярилцлага, нас 37, эрэгтэй, ТББ-ын түр хоноглох байр</i></p>	<p>... Би ч яахав зундаа ажил төрөл хийгээд явдаг байсан, ковид гараад ажиллаж чадаагүй. Цар тахлын үед би Нийгмийн хамгааллын тусгай төвд амьдарч байсан болохоор ч тэр үү миний өөрийн амьдралд онцын өөрчлөлт авчраагүй. Гол нь гадуур үйлчилгээний газрууд хаалгаа барьж байсан болохоор хүүхдүүддээ л санаа зовж эхэлсэн.</p> <p><i>Ганцаарчилсан ярилцлага, нас 62, эрэгтэй, Улсын түр хоноглох байр - НХТТ</i></p>
---	---

4.5. Гэр оронгүй, тэнэмэл иргэдийн гэрээсээ дайжих болсон шалтгаан

ГОТИ-ийн гэр оронгүй болсон шалтгаанууд дараах гол онцлогтой байна:

- ГОТИ-ийн гэр оронгүй амьдрах болсон шалтгаан олон хүчин зүйлээс үүдэлтэй ч архины хэт хэрэглээ хамгийн том шалтгаан (43.2%) болж байна.
- Гэр оронгүй, тэнэмэл амьдралын замд ороход нөлөөлсөн тоогоор хэмжигдэхгүй микро түвшний эрсдэлт хүчин зүйлсэд “эрх мэдэлтнийг эсэргүүцэх” зан төлөв, гэр бүл дэх бие махбодийн болон сэтгэл санааны гэх мэт төрөл бүрийн хүчирхийлэл, гэр бүлийн хүрээний хэт хайр халамжаас үүдэлтэй бэрхшээлийг даван туулах чадвар муу байдал, “ойр дотныхонтой харилцаа холбоо тасрах” байдал зэрэг багтаж байна.
- Нийгэм, эдийн засгийн хөгжлийн доогуур байдал, орон нутгийн төсвийн хүрээлцээгүй байдал зэрэг нь иргэдийг гэр оронгүй амьдралд орохоос сэргийлэх, уг байдлаас гаргахад чиглэсэн үйлчилгээний чанарт сөргөөр нөлөөлж байна.

ГОТИ-ийн гэр оронгүй амьдрах болсон шалтгаан олон хүчин зүйлээс үүдэлтэй ч архины хэт хэрэглээ хамгийн том шалтгаан болж байна. Энэхүү судалгаанд оролцогчдын хувьд гэрээсээ дайжих болсон шалтгаануудын эхэнд архинд донтож гэрээсээ хөөгдсөн/явсан шалтгаан орж байгаа (43.2 хувь) бол гэр бүл салсан (27.7 хувь), гэр бүл дэх хүчирхийллээс дайжсан юмуу гэртээ гадуурхагдаж хөөгдсөн (23.7 хувь) гэсэн шалтгаанууд удаалж байна (**Хүснэгт 4.5.1**). Архины хэт их хэрэглээ, донтолт нь ажилгүйдэл, орлого мөнгөгүй байх үр дагаврыг үүсгэх нь олонтаа бөгөөд хангалттай орлого, мөнгөгүй байдал ч гэр оронгүй амьдрах өөр нэг төрлийн шалтгаан болсон (11.6 хувь) нь харагдлаа. Дээрхээс гадна хөдөө орон нутгаас шилжин ирээд амьдрах газар, байр олж чадахгүй байх, эсхүл байгалийн гамшигт гэр орноо алдах (11.4 хувь) нь тэнэмэл амьдралд орох шалтгаан болж буйг анхаарах шаардлагатай бөгөөд тэдгээр хүмүүсийг тусгай хөтөлбөр/арга хэмжээнд цаг тухайд нь хамруулан дэмжлэг үзүүлсэн бол гэр оронгүй тэнэмэл амьдралд орохгүй байх боломж байсныг үгүйсгэх аргагүй юм. Гэр оронгүй амьдрах болсон шалтгаанууд дунд ойр дотны хүн нас барсан, туслах хүн байхгүй, ял шийтгэл эдэлж байсан тул гадуурхагдсан зэрэг асуудлууд байгааг ч мөн нийгмийн хамгаалал, халамжийн чиглэлээр ажилладаг хүмүүс эн тэргүүнд мэргэжлийн үүднээс анзааран олж харж, зохих шатны арга хэмжээнүүд хэрэгжүүлэх чиглэлээр цаашид анхаарах нь зүйтэй гэж үзэж байна.

Хүснэгт 4.5.1. ГОТИ-ийн хувь, гэр оронгүй амьдрах болсон шалтгаанаар, судалгаанд оролцогчдын бүлгээр

Гэр оронгүй амьдрах болсон шалтгаан	ГОТИ-ийн бүлэг		Нийт ГОТИ
	Түр хоноглох төвд байгаа	Түр хоноглох төвөөс гадуурх	
Архинд донтож гэрээсээ хөөгдсөн /явсан	42.3	46.0	43.2
Гэр бүл салсан	27.2	29.0	27.7
Гэр бүл дэх хүчирхийллээс дайжсан/ гадуурхагдаж хөөгдсөн	24.3	22.0	23.7
Хангалттай орлого, мөнгөгүй	13.1	7.0	11.6

Орон нутгаас шилжин ирээд газар/байр олдоогүй / Байгалийн гамшигт өртсөн	10.2	15.0	11.4
Ойр дотны хүн нас барьсан/туслах танил тал байхгүй	9.8	16.0	11.4
Өөрөөсөө болсон / ажлаасаа гарсан /гэрээ зарсан	8.5	6.0	7.9
Хүмүүст хууртаж, залилуулсан / өр зээлийн дарамт	7.2	2.0	5.9
Ял шийтгэл эдэлж байсан тул гадуурхагдсан	2.6	9.0	4.2
Үр хүүхэд болон хамаатан найздаа гэрээ өгсөн	2.3	0.0	1.7
Бусад	6.6	2.0	5.4
Хариулагчдын тоо*	305	100	405

* Тэмдэглэл: хариулагч олон хариулт хэлж болох асуулт тул хариултын нийлбэр 100%-аас илүү.

Судалгаанд оролцогчдын гэр оронгүй болсон шалтгааныг бид 1) *хүүхэд ахуй насны амьдралын нөхцөл байдал, хувь хүний эрсдэлт хүчин зүйл*, 2) *гэр бүлийн эрсдэлт хүчин зүйл*, 3) *нийгмийн эрсдэлт хүчин зүйлс* гэж бүлэглэн үр дүнг тайлбарлав.

i. Хувь хүний эрсдэлт хүчин зүйлс: Гэр оронгүй, тэнэмэл амьдралын нэг шалтгаан нь “Эрх мэдэлтнийг эсэргүүцэх” зан үйл байж болзошгүй. Хүүхдэд багаас нь үл хайхрах хүчирхийлэл дарамттай байдлыг харуулж өсгөх, эцэг эх нь нийгмийн эсрэг зан үйлтэй байх, гэмт хэрэгт холбогдож байсан, түрэмгий зан үйл болон хүчирхийлэлд холбогдож байсан түүхтэй, эцэг эхийн боловсрол, эцэг эх-хүүхдийн харилцаа таагүй байх зэрэг нь хүүхдийг түрэмгий авиртай, нийгмийн харилцааны чадвар сул, ганцаардмал, хичээл сурлагын хоцрогдолтой, амжилт сул байх, сэтгэцийн ямар нэгэн асуудалтай, урт хугацаагаар өвдөх байдалд хүргэж болдог. Дээрх нөхцөл байдлын улмаас хүүхэд насанд хүрэхдээ дасан зохицохгүй зан үйлд орох тэр дундаа архи тамхи, мансууруулах бодис хэрэглэх, гэмт хэрэгт өртсөнөөс орон гэргүй болох нь байна. Чанарын судалгааны үед судалгаанд оролцогчдоос илрүүлсэн зан үйлийн холбогдолтой шалтгаанаар орон гэргүй болсон талаарх зарим түүхийг **Шигтгээ 4.5.1**-д харуулав.

Шигтгээ 4.5.1:

... Ар гэрийн хараа хяналт муу байсан болохоор архи, согтууруулах ундаа хэрэглэж эхлэхэд минь зогсоох хүн байгаагүй. Манай аав өдөр шөнөгүй завгүй, утсаар ярихдаа минут хүрэх үгүйтэй ярьдаг байсан. Энэ нь цаашдаа архинд илүү ороход нөлөөлсөн....

Ганцаарчилсан ярилцлага, нас 27, эрэгтэй, ТББ-ын түр хоноглох байр

ii. Гэр бүл, ойрын хүрээллийн эрсдэлт хүчин зүйлс: Гэр оронгүй, тэнэмэл амьдралд ороход нөлөөлсөн өөр нэг хүчин зүйл нь өмнөх амьдралын гэр бүл дэх хүчирхийлэл байна. Гэр бүлийн харилцаа, тэр дундаа эцэг-эх, эцэг эх-хүүхдийн хоорондын харилцаа эерэг байх нь иргэдийн зөв хандлагатай байх суурь юм. Харин эцэг эхийн таагүй харилцаа, эрүүл мэнд, биеэ зохисгүй авч яваа байдал, архины хамаарал, сэтгэл гутрал, салалт, гэр бүлийн хүчирхийлэл зэрэг нь хүүхдэд бага наснаасаа гэр орноосоо дайжих, зугатах, зүй бус хандлагатай болж өсөх эрсдэлт хүчин зүйл болдог. Гэр бүлийн доторх хатуу ширүүн харилцаа, эцэг/эх нь хүчирхийлэгч байх, гэр бүл доторх үүрэг хариуцлага

сул, хүүхдээ харж хандах, зөвлөн туслахад анхаарал бага тавих нь хүүхдийн сэтгэл зүй, тархины хөгжилд маш ноцтой гэмтэл авах үр дагавартайг судлаачид тогтоосон байдаг. Монгол Улсын хувьд ч ялгаагүй, гэр бүлийн орчин дахь хүчирхийлэл нь насанд хүрэгчид, тэр дундаа эмэгтэйчүүдийн болон хүүхдүүдийн хувьд гэр орноосоо дайжих, тэнэмэл амьдралаар амьдрах нэг шалтгаан болж байна.

Хүснэгт 4.5.2. ГОТИ-ийн хувь, гэр оронгүй амьдрах болсон шалтгаанаар, судалгаанд оро

Хүчирхийлэгч хамтран амьдрагчаас зугтахын тулд	Хүчирхийлэгч гэр бүлийн гишүүнээс зугтахын тулд
<p>... 1998 онд нөхрөөсөө шууд зугтсан. Нөхөр над руу сүх шидээд тэгээд л шийдээд ганцаараа гараад л явчихсан, 2 хоног яваад юм ч олж идээгүй, өлсөөд цангаад, орцонд хоносон.. тэгээд л энэ амьдрал руу орсон.</p> <p>ГЯ, нас 48, эмэгтэй, ТББ-ын түр хоноглох байр</p>	<p>... Аав архи их уудаг байсан. Гэр бүлийн хүчирхийллээс болоод явсан. Аав их зоддог, шийтгэдэг байсан болохоор гэрээсээ явсан. Гэртээ буцаж очмоор байсан ч айдаг. Гэрийнхнээсээ холбоо тасарсан.</p> <p>ГЯ, нас 37, эрэгтэй, ТББ-ын түр хоноглох байр</p>
<p>...Нөхөртэйгээ их муудалцдаг байсан, тэгээд хүүхдээ үлдээгээд зугтах аас өөр аргагүй байдалд хүрсэн. 2008 оноос л жинхэнэ шуудай үүрээд л гудамжинд явдаг, архины мөнгө л олох гэж тэнээд л явдаг болсон.</p> <p>ГЯ, нас 40, эмэгтэй, ТББ-ын түр хоноглох байр</p>	<p>... Аавын эгчийн хүү эмээ, өвөө дээр ирээд хамт амьдарч эхэлсэн. Намайг зоддог, талх авчрахдаа булангаас нь хазсан байхад л зоддог байсан. Намайг 13 настай байхад хүчиндсэн, тэгээд эмээ өвөөдөө хэлбэл аавыг чинь шоронгоос гаргахгүй шүү гэсэн. Тэгээд би гэрээсээ гараад явчихсан</p> <p>ГЯ, нас 37, эмэгтэй, НХТТ-ийн түр хоноглох байр</p>

Гэр оронгүй, тэнэмэл амьдралын өөр нэг хүчин зүйл нь гэр бүлийн хүрээний хэт хайр халамжаас үүдэлтэй бэрхшээлийг даван туулах чадвар муу байдал байна. Монголчуудын хувьд хүүхдийг “хэт” хайрлаж өсгөх үзэгдэл байдаг нь судалгааны үр дүнгээс нийтлэг ажиглагдаж байна. Тухайлбал, монголчуудын хувьд эрэгтэй хүүхдээ хэтэрхий их дээдлэх, тэр дундаа отгон хүү эсвэл ганц хүү, өргөж авсан хүүхэддээ хайрын үнэ цэнийг хэтрүүлэн өсгөх байдал байна. Зарим тохиолдолд “буруу эрхэлсэн”, “эрх танхи” өссөн байдал нь амьдралын бэрхшээл, сорилтын үед шийдвэр гаргах, даван туулах, эрсдлийг тооцоолох чадваргүй, хариуцлагын мэдрэмж султай, эцэг эх, хэн нэгнээс үргэлж хамааралтай байх, ямар ч үед өрөвдүүлэх, хайрлуулах хэрэгцээгээ бусдаас хүсэмжилж байдаг хандлагад сургадаг ба энэ нь сэтгэл гутралд орох, архины хамааралд автах улмаар гэр бүлийн байдал тогтворгүй, орон гэргүй болох эрсдлийг бий болгож байгааг судалгаанд оролцогчдын түүхээс харж болохоор байна.

iii. Нийгмийн эрсдэлт хүчин зүйлс: Улсын хөгжлийн доогуур байдал, хөгжлийн төлөвлөлт, төсвийн хүрээлцээгүй байдал зэрэг нь иргэдийг гэр оронгүй амьдралд орохоос сэргийлэх, уг байдлаас гаргахад чиглэсэн үйлчилгээний чанарт сөргөөр нөлөөлж байна. Нийгэм, орон нутгийн түвшин дэх ядуурал, ажилгүйдэл, эдийн засгийн

тааламжгүй байдал, нийгмийн хамгаалал, дэмжлэгийн системийн дутмаг, хүртээмжгүй байдал, эдийн засгийн нөөц боломж хязгаарлагдмал байдал, нийгмийн идэвхтэй үйл ажиллагаа барагтай явагддаггүй байдал, орон нутгийн түншлэл, хариу арга хэмжээ, нийгмийн үйлчилгээ сул хөгжсөн байдал, амьжиргааны түвшин доогуур хүн амын хувь их байх, РС, цагийн буудал, бар, караоке гэх мэт хэт олон байх нь нийгмийн эрсдэлт хүчин зүйлсэд багтана. Эдгээр хүчин зүйлс зарим иргэнийг гэр оронгүй амьдралаар явах замд тодорхой хэмжээгээр нөлөөлсөн болох нь чанарын судалгаануудаар илэрсэн.

Шигтгээ 4.5.2:

... Хараад байхад, шилжин ирсэн хүмүүст хамгийн наад зах нь ирсний дараах хоёр жилийн хугацаанд маш том дэмжлэг яаралтай үзүүлэх хэрэгтэй байдаг юм билээ. Тэгж байж ирсэн хүмүүсийг хөлөө олоход нь туслаж, тэд маань ядууралд хүрэхгүй байх боломж нэмэгдэнэ гэж үзэж байгаа. Энэ нь тэднийг ядуу, орон гэргүй болчихоос сэргийлэх, орон гэргүй тэнэмэл хүмүүс нэмэгдэхгүй байх бас нэг нөхцөл нь болж өгнө. Боловсролгүй залуучууд ажиллаж байгаад ажилгүй болчихвол, тэгээд эцэг эх, ах дүү нар нь хотод байхгүй бол орон гэргүй болоод л явчихна. Гэр бүлээсээ саллаа, бас л орон гэргүй болоод явчихна. Ер нь ямар нэгэн том асуудал гарахад автоматаар орон гэргүйчүүдийн эгнээнд орчихно шүү дээ...

Үндсэн мэдээлэгчтэй хийсэн ярилцлага, Олон улсын байгууллага

4.6. Гэр оронгүй, тэнэмэл иргэдийн хамрагдаж буй үйлчилгээ

Энэ бүлгийн 4.6.1 хэсэгт төрийн болон ТББ-ууд гэр оронгүй, тэнэмэл иргэдэд хууль эрх зүй, гэрээт ажлын хүрээнд ямар үйлчилгээг явуулдаг талаар “үйлчилгээ үзүүлэгч”-ийн мэдээлэлд үндэслэн авч үзсэн. Харин 4.6.2 хэсэгт үйлчилгээнд хамрагдагч буюу ГОТИ-ийн мэдээлэлд үндэслэн төрийн болон ТББ-аас авч буй үйлчилгээний талаар авч үзсэн.

4.6.1. ГОТИ-д төрийн болон төрийн бус байгууллагаас үзүүлж буй үйлчилгээ, тулгамдаж буй асуудал

ГОТИ-д үзүүлдэг үйлчилгээнд дараах гол анхаарах зүйлс байна гэж мэргэжилтнүүд үзэж байна:

- НЗД-ын захирамжийн дагуу ГОТИ-ийг жил бүр 1-3 удаа, хүйтний улиралд илрүүлж Төрийн үйлчилгээний байгууллага болох НХТТ болон магадлан итгэмжлэгдсэн ТББ-ын түр хоноглох төвүүдэд байршуулах ажлыг зохион байгуулдаг ч энэ нь “түр гал унтраах” арга хэмжээ гэж үзэж байна.
- НХТТ жилийн 4 улиралд тогтмол үйл ажиллагаа явуулдаг ба нэг дор 150 хүн хүлээн авах хүчин чадалтай ч 19 ажилтан жилдээ дунджаар давхардсан тоогоор 39000, давхардаагүй тоогоор 460 хүнд үйлчилгээ үзүүлж байгаа нь үйлчилгээний чанарт сөргөөр нөлөөлж байна.
- Магадлан итгэмжлэгдсэн ТББ-ын төвүүд нийгмийн халамжийн сангаас зөвхөн хүйтний үед, дунджаар 3-5 сарын урсгал зардлын дэмжлэг аван ГОТИ-д үйлчилгээ үзүүлж байна.
- Түр хоноглох төвүүд *Нийгмийн хамгааллын тухай* хуулийн 18.1-р заалтад заасан үйлчилгээнүүдийг ГОТИ-дэд үзүүлэх ёстой ч ихэнх нь хооллох, байршуулахаас өөр үйлчилгээ үзүүлж чадахгүй, хүний нөөц, тохижилт хангалтгүй байна. Гэхдээ “Өлзийт Асар”, “Шинэ амьдрал-ялалт” зэрэг ТББ-ууд ГОТИ-ийг хооллох, хоноглохаас гадна төвдөө урт хугацаанд байршуулж, нийгэмшүүлэхэд чиглэсэн ажлууд хийж буй сайн туршлагауд байна.
- Улсын хэмжээнд бичиг баримтгүй нийгмийн эмзэг бүлэгт эмнэлгийн тусламж, үйлчилгээ хүргэх зорилго бүхий ганцхан эмнэлэг үйл ажиллагаа явуулж байна.
- Нийгмийн халамжийн салбар ТББ-аар дамжуулан ГОТИ-дэд үйлчилгээ үзүүлж байхад ижил үйлчилгээ үзүүлдэг НХТТ нь НЗДТГ-ын харьяанд үйл ажиллагаа явуулж байгаа нь нэгдсэн бодлого, салбар хоорондын уялдаа, үйл ажиллагаа дутагдалтай байгааг харуулж байна.

А. Төрийн үйлчилгээ.

ГОТИ-ийг олж илрүүлэх, байршуулах, тусламж, үйлчилгээ үзүүлэх ажил нь Монгол Улсад цагдаа, эрүүл мэнд, халамжийн байгууллагуудын хамтарсан үйл ажиллагаан дээр тулгуурладаг аж. Мөн олон нийтийн оролцоонд түшиглэсэн байдлаар ГОТИ-д үйлчилгээ үзүүлдэг төрийн бус байгууллагууд ч байна. Судалгаагаар эдгээр байгууллагуудын хариуцсан мэргэжилтнүүдтэй ганцаарчилсан ярилцлага хийж, гэр оронгүй тэнэмэл иргэдийн асуудлыг ярилцсан үр дүнг дор нэгтгэн бичив. **Хүснэгт 4.6.1-**д төрийн байгууллагуудын үзүүлж буй үйлчилгээний талаар, **Шигтгээ 4.6.1-**д ТББ-ын үзүүлж буй үйлчилгээний талаар танилцууллаа.

Хүснэгт 4.6.1. ГОТИ-д төрийн байгууллагуудаас үзүүлж буй үйлчилгээ, байгууллагаар

Байгууллагын нэр	Үзүүлж буй үйлчилгээний төрөл
Цагдаа	<ul style="list-style-type: none"> • ГОТИ-ийн амьдарч буй газруудыг дүүрэг, хороодын хэмжээнд гаргах • Илрүүлэг арга хэмжээ зохион байгуулж, цуглуулах, байршуулах • Гэмт хэрэгт өртөх эрсдлээс хамгаалах, урьдчилан сэргийлэх.
Нийгмийн халамж	<ul style="list-style-type: none"> • ГОТИ-дэд үйлчилгээ үзүүлэх зорилгоор байгуулагдсан ТББ-дыг магадлан итгэмжлэх • Магадлан итгэмжлэгдсэн ТББ-ын ГОТИ-дэд үзүүлж үйлчилгээг хянах, үйл ажиллагаанд үнэлгээ өгөх • Магадлан итгэмжлэгдсэн ТББ-ыг санхүүжүүлэх • Үйлчилгээ, санхүүжилтын аргачлал арга зүйг батлах • ГОТИ-ийн талаарх мэдээлэл цуглуулах
Эрүүл мэнд	<ul style="list-style-type: none"> • Амбулаторийн үйлчилгээ • Хэвтэн эмчлүүлэх үйлчилгээ (хэвтэн эмчлүүлэгчдийн 40 хувийг эмзэг бүлгийн иргэд эзэлдэг, тэнэмэл иргэдийг оочер дараалалгүй хүлээн авдаг) • Урьдчилан сэргийлэх үйлчилгээ (ТББ-тай хамтран жилдээ 5-6 удаа үзлэг хийдэг) • Илрүүлэг арга хэмжээнд оролцдог (жилд 3 удаа) • Дархлаажуулалтанд хамруулдаг (Ковид цар тахлын үед дархлаажуулалтанд ГОТИ сайн хамрагдсан). • Эмнэлгийн үйлчилгээг үнэ төлбөргүй хүргэх үүрэгтэй.

Шигтгээ 4.6.1:

...Хамтран ажилладаг ТББ-аас гадна магадлан итгэмжлэгдээгүй ч ГОТИ-дэд туслалцаа үзүүлдэг арав орчим байгууллага байдаг. Тэдний дийлэнх нь христийн шашны байгууллага байдаг. Санхүүжилтээ өөрсдөө босгоод үйлчилгээгээ үзүүлдэг. Ихэнх ТББ өөрийн гэсэн тусгай байргүй нийтийн байр түрээслээд 3 сар үйл ажиллагаагаа явуулаад л больчихдог бараг л ашгийн төлөө байгууллага болж хувирсан. Төвүүдийг шалгахад тэнэмэл иргэдийг 1-3 хоног байршуулчихаад биднээс 90 хоног байрлуулсан гээд л мөнгө авчихсан тохиолдол ч байсан. Сайн ТББ ч байгууллага байна. Жишээ нь “Өлзийт асар” ТББ. Эдний үйл ажиллагаа нэлээд жигдэрсэн...

Үндсэн мэдээлэгчтэй хийсэн ярилцлага, Нийгмийн халамжийн хэлтэс

Цагдаагийн байгууллага: ГОТИ-дэд үйлчилгээ үзүүлэх хүрээнд цагдаагийн байгууллага гэр оронгүй, тэнэмэл иргэдийг илрүүлэх, нийгэмшүүлэх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үүрэгтэй ажилладаг байна. Ялангуяа Нийслэлийн цагдаагийн газрын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хэлтэс өвлийн улиралд ГОТИ-ийг илрүүлэх, хамгаалах, түр хоноглох төвүүдэд байршуулах ажлыг идэвхтэй хийдэг ба “нийгэмшүүлэх” чиглэлээр төдийлөн сайн ажиллаж чаддаггүйгээ илэрхийлж байсан. ГОТИ иргэд нийслэлийн төвийн 6 дүүрэгт ихэвчлэн байршдаг бөгөөд Нийслэлийн засаг даргын захирамжийн дагуу жил бүр 1-3 удаа, хүйтний улиралд илрүүлэх, байршуулах ажлыг зохион байгуулдаг. 2021 онд илрүүлэг арга хэмжээг НЗДТГ-ын Нийгмийн бодлогын хэлтэс, цагдаа, эрүүл мэнд, халамжийн байгууллагуудтай хамтран 3 удаа зохион байгуулж, нийт 506 гэр оронгүй, тэнэмэл иргэдийг илрүүлсэн ба тэдний 91

хүнийг ар гэрт нь буцааж, үлдсэн хүмүүсийг нь Нийслэлийн засаг даргын шууд харьяа байгууллага болох Нийгмийн хамгааллын тусгай төв, магадлан итгэмжлэгдсэн ТББ-уудад байршуулжээ. Хүйтний улиралд илрүүлэг арга хэмжээ зохион байгуулах гол шалтгаан нь өвлийн улиралд монголд маш хүйтэн байдаг учраас гэр оронгүй иргэдийг гар хөлөө хөлдөөх, амь насаа алдах эрсдлээс урьдчилан сэргийлэх явдал бөгөөд үүнээс гадна халуун хоол ундаар хангах, бичиг баримтжуулах, эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэх зорилготой юм байна. ГОТИ-ийн дийлэнхийг хүчээр байршуулж, байршуулсан газарт нь эхний 2-3 хоног өндөржүүлсэн бэлэн байдалд байлгадаг. ГОТИ-ийг түр хоноглох төвд байлгах хоногийн тоо өвлийн улиралд 90 хоног байсан бол 2021 оноос санхүүжүүлэлт нэмэгдсэнтэй холбоотойгоор 5 сар болгожээ. ГОТИ-дэд зориулсан арга хэмжээнд төрөөс 2021 онд 369 сая төгрөгийн санхүүжүүлэлт олгосон байна.

Нийгмийн халамжийн салбар: ТББ-аар дамжуулан ГОТИ-дэд үйлчилгээ үзүүлдэг. *Нийгмийн халамжийн тухай* хуулинд ГОТИ-дэд хүргэх төрийн үйл ажиллагааг олон нийтийн оролцоонд суурилан явуулахаар заасан байдаг бөгөөд ГОТИ, тэдний гэр бүлийн гишүүдийн амьдрах итгэлийг нэмэгдүүлэх, нийгэмшүүлэх, бичиг баримтжуулах, түр хоноглох байранд байршуулах үйлчилгээг нийслэлийн хэмжээнд магадлан итгэмжлэгдсэн 6 төрийн бус байгууллага гэрээлэн гүйцэтгэж байна. Баянзүрх, Хан-Уул, Сонгинохайрхан, Чингэлтэй дүүргүүдэд байрладаг “Шинэ амьдрал ялагч”, “Дөлгөөн минж”, “Өлзийт асар”, “Хаган богда”, “Титэм констракшн”, “Тэрэм уул” ТББ-уудын гэрээ 2022 оны 03 дугаар сарын 31-ний өдрийг дуустал хүчинтэй бөгөөд 2022 онд магадлан итгэмжлэлээ сунгасан байгууллагуудтай гэрээ сунгаж ажиллах юм байна. Дээрх ТББ-уудтай ижил үйл ажиллагааг нийслэлд явуулж буй төрийн үйлчилгээний өөр нэг байгууллага бол Нийгмийн хамгааллын тусгай төв юм. Тус төв НЗДТГ-ын харьяанд, жилийн дөрвөн улирал тогтмол үйл ажиллагаа явуулдаг ба санхүүжүүлэлт нь нийслэлээс гардаг байхад, ТББ-уудын зарим нь жилдээ цөөн хэдэн сар ажиллаад, санхүүжүүлэлтээ нийгмийн халамжаас авдаг байна. **Иймээс ГОТИ-д үзүүлэх үйлчилгээг нэгдсэн бодлоготой болгож, салбар хоорондын уялдаа холбоог сайжруулах, үйл ажиллагааг нэгдсэн удирдамж, арга зүйгээр явуулах шаардлагатай нь харагдсан.**

Энэрэл эмнэлэг: Тус эмнэлэг нь 1998 онд Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч, Эрүүл мэнд, Нийгмийн хамгааллын сайдын хамтарсан А/84, А/68 дугаар тушаалаар байгуулагдсан, улсын хамжээнд нийгмийн эмзэг бүлэгт эмнэлгийн тусламж, үйлчилгээ хүргэх зорилгоор байгуулагдсан цорын ганц эмнэлэг юм. Харин тус эмнэлэг ЭМД-д хамруулах, нийгэмшүүлэх үүрэг хүлээдэггүй байна.

Дээрх байгууллагуудад тулгамдаж буй асуудлын талаар ярилцагчидтай хийсэн ярицлагын үр дүнг **Хүснэгт 4.6.2, Шигтгээ 4.6.2**-т нэгтгэн харууллаа.

Хүснэгт 4.6.2. ГОТИ-дэд төрийн байгууллагуудаас үйлчилгээ үзүүлэхэд тулгамдаж буй асуудлууд, байгууллагаар

Байгууллагын нэр	Үйлчилгээ үзүүлэхэд тулгамдаж буй асуудлууд
Нийгмийн халамж	<ul style="list-style-type: none"> • ТББ-уудын хүний нөөц, орон байрны хүрэлцээ хангамж хангалтгүй • ГОТИ-ийг зөвхөн хүйтний улиралд хөлдөөж осгоохгүйн тулд хоноглох, хооллохоос өөр ажил бараг хийгдэггүй • Сургалт, сэтгэл зүйн үйлчилгээ явагдаж чадахгүй байна. • Төлөвшүүлэх, нийгэмшүүлэх үндсэндээ хийгдэж чадахгүй байна. • Зарим ТББ-уудын санхүүгийн сахилга бат хангалтгүй • ГОТИ-ийн талаарх мэдээлийн нэгдсэн сан хангалтгүй.
Эрүүл мэнд	<ul style="list-style-type: none"> • Эрүүл мэндийн даатгал байхгүй учраас нарийн мэргэжлийн эмчид үзүүлэх, өндөр өртөгтэй шинжилгээ хийх боломжгүй. Мөн дараагийн шатлалын эмнэлэгт үзүүлэх боломж хомс. • ГОТИ-дэд чиглэсэн салбар дундын хамтын ажиллагаа, эрх зүйн орчин сул • Хэвтрийн, асаргаа шаардсан орон гэргүй иргэдийг эмчилж сайжруулсны дараа хүлээлгэн өгөх газар байдаггүй. • Диспансерийн хяналтанд эмчлэн эрүүлжүүлэх шаардлагатай иргэдэд үр дүнтэй хяналттай тусламж, үйлчилгээ үзүүлэх боломжгүй • Эмнэлгийн тусламж үйлчилгээ авах шаардлагагүй ухаангүй согтуу иргэдийг эмнэлэгт олон тоогоор нь авчирдаг, цагдаагийн байгууллагатай байнгын асуудал, маргаан үүсдэг. Эрүүлжүүлэх авдаггүй, ар гэр байхгүй, Өвлийн улиралд эмнэлэг эрүүлжүүлэх шиг хонож байна. • Эмзэг бүлгийн иргэдийг Эрүүл мэндийн даатгалд хамруулах боломжгүй, олон жилээр төлөгдөөгүй байдаг. Санхүүгийн эх үүсвэр байхгүй.
Цагдаа	<ul style="list-style-type: none"> • ГОТИ-ийг илрүүлэх ажил санхүүгийн хязгаарлагдмал байдлаас болж тогтмол хийгдэж чаддаггүй. • Түүр хоноглох байрны хүрэлцээ хангамж муу. • ГОТИ-дэд зориулсан төсөл хөтөлбөр хэрэгждэг ч тодорхой үр дүнд хүрээд зогсдог. • ГОТИ-ийн талаарх хууль эрх зүйн орчныг зохицуулсан бодлогын баримт бичиг байхгүй. Мөн одоогоор хэрэгжиж байгаа хууль тогтоомжийн хэрэгжилт хангалтгүй. • Цагдаагийн байгууллагын зорилгод ГОТИ-ийг нийгэмшүүлэх гэж байдаг боловч энэ ажил хийгдэхгүй, илрүүлэлтээр хязгаарлагдаж байна.

Шигтгээ 4.6.2:

...Эдгээр иргэдийг нийгэмшүүлэхэд нэг удаа байрлуулаад дуусчихна гэж бодож болохгүй. Нийгэмшүүлэхэд маш олон давтамжтай сэтгэл зүйн сургалт заслууд хийх хэрэгтэй болдог. Гэтэл өнөөдөр бидний аваачиж байршуулж байгаа ихэнх газарт сэтгэл зүйч битгий хэл нийгмийн ажилтан ч байхгүй байгаа шүү дээ. Ийм нөхцөлд нийгэмшүүлэх асуудал үнэндээ хол харагдаж байна...

Үндсэн мэдээлэгчтэй хийсэн ярилцлага, Нийслэлийн цагдаагийн газар

... ГОТИ-ийн бараг 90 гаруй хувь нь архины хамааралтай байдаг. Энэ чинь өвчин шүү дээ тэгэхээр архианаас гаргах, сэтгэл зүйн эмчилгээ хийх, архины албадан эмчилгээнд явуулах, мөн ААА-гийн арга хэмжээг хамгийн үр дүнтэй арга гэж боддог. Наркологийн төвд бол “Зангиатай архичид” эмчлүүлдэг, манай эмзэг давхаргынханд үйлчилдэггүй. Ер нь ТББ бүрт сэтгэл засалч ажилуулах шаардлагатай. Ялангуяа бүлгийн сэтгэл засал их үр дүнтэй гэж боддог...

Үндсэн мэдээлэгчтэй хийсэн ярилцлага, Энэрэл эмнэлэг

Ийнхүү, өнөөгийн байдлаар ГОТИ-ийг илрүүлэх, түр хоноглох төвүүдэд байршуулах, хооллох, эрүүл мэндийн яаралтай тусламж үзүүлэх зэрэг арга хэмжээг авч байгаа боловч энэ нь “түр гал унтраах” арга хэмжээ гэдэгтэй ярилцлаганд оролцсон хүмүүс санал нэгтэй байв. Учир нь ГОТИ-ийг “нийгэмшүүлэх” талаар холбогдох хууль эрх зүйн бүх баримт бичигт дурьдсан байгаа боловч энэ үүргийг төдийлөн хэрэгжүүлж чадахгүй байгаагаа мэргэжилтнүүд илэрхийлж байсан (Шигтгээ 4.6.3). Ер нь нийгмийн халамж, эрүүл мэнд, цагдаагийн байгууллагаас өөр төрийн байгууллага ГОТИ-ийн талаарх үйл ажиллагаанд оролцдоггүй аж. Гэтэл боловсрол, бүртгэлийн байгууллагуудын оролцоо байхаар хуульчлагдсан байгааг анхааралдаа авах хэрэгтэй байна.

Шигтгээ 4.6.3:

... Өнгөрсөн жил үйлчлүүлсэн хүмүүсээс 61 хүнийг нийгэмшүүлж гэрт нь буцаасан байдгийн. Харамсалтай нь тэдний зарим нь энэ жил буцаад ирсэн. Бидний хувьд нийгэмшүүлэх ажилд тэр бүр анхаарч чадахгүй байгаагаа хэлэх хэрэгтэй...

Үндсэн мэдээлэгчтэй хийсэн ярилцлага, НХТТ

Цаашид ГОТИ-дэд үзүүлэх төрийн үйлчилгээг сайжруулахын тулд хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээний талаарх саналуудыг гол мэдээлэгчдийн ярилцлагаар бид асуусан ба мэргэжилтнүүдийн саналуудыг нэгтгэн үзвэл, салбаруудын уялдаатай нэгдсэн бодлого төлөвлөлт, үйл ажиллагаа нэн тэргүүнд чухал болох нь харагдаж байсан (Шигтгээ 4.6.4).

Шигтгээ 4.6.4:

... Ер нь ГОТИ-ийн асуудлыг орон нутагт нь шилжүүлж, улмаар үйл ажиллагаагаа төрийн байгууллагатай уяж, зардлыг Засаг даргын албанаас гаргаад явах нь зүйд нийцэх болов уу. Тэгэхгүй бол ганц халамж дээр тавиад байна. Халамжийн байцаагч энэ олон үйлчилгээ явуулж, ачаалалтай ажилладаг хүн хэдийдээ хянаж, хэдийдээ сургалт явуулж байгаа эсэхийг хянаж, ажлын үр дүн нөлөөллийг тооцох вэ дээ. Үүнийг бодлого болгох хэрэгтэй байна. Маш хурдан. Зүгээр ч бодлого биш цогц бодлого гаргах хэрэгтэй...

Үндсэн мэдээлэгчтэй хийсэн ярилцлага, ХХҮЕГ

Мөн дараах үйл ажиллагааны саналуудыг мэргэжилтнүүд дэвшүүлсэн. Үүнд:

- ТББ-аар дамжин нийгэмшүүлэх ажлыг болиулж, түр хоноглох улсын төвийн тоог нэмэх
- Салбар дундын бодлогын баримт бичгийг яаралтай гаргах, хариуцах чиг үүргийг тодорхой болгох
- Одоо 4 дүүрэгт магадлан итгэмжлэгдсэн байгууллага байгааг 9 дүүрэгт болгон өргөжүүлэх
- Орон нутагт ядаж аймаг болгонд чадахгүй юм аа гэхэд бүсчилсэн байдлаар түр хоноглох төвүүдийг байгуулж, ажиллуулах

- Боловсрол, эрүүл мэнд, бүртгэлийн байгууллагыг ГОТИ-ийн үйл ажиллагаанд татан оролцуулах
- Төрийн байгууллагуудын уялдаа холбоог сайжруулах, хуульчлах, бодлогын баримт бичиг гаргах
- ГОТИ-ийг өөр эмнэлгүүд хүлээн авдаггүй учраас Энэрэл эмнэлгийн өрөө тасалгааны тоо, эмнэлгийн тусламж, үйлчилгээний төрлийг нэмэгдүүлэх, шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах.
- Энэрэл эмнэлгийг түшиглэн сувилал, асаргааны төв байгуулж тэнд зөвхөн урт хугацааны эмчилгээ, сувилгаа шаардлагатай очих газаргүй иргэдийн байршуулах
- ГОТИ-ийн нийгмийн үүрэг хариуцлагыг дээшлүүлэхийн тулд тэдэнтэй ажиллах сэтгэл зүйч, сэтгэл засалч, эмч, эмнэлгийн ажилтан гээд байнгын бүтэцтэй байгууллагыг бий болгох
- Олон улсын оновчтой туршлагыг нэвтрүүлэх шаардлагатай байна.

Б. Нийгмийн хамгааллын тусгай төв ба ТББ-уудын үйлчилгээ

Судалгааанд гэр оронгүй, тэнэмэл иргэдэд үйлчилгээ үзүүлдэг НЗДТГ-ын харьяа **Нийгмийн халамжийн тусгай төв (НХТТ)**, магадлан итгэмжлэгдсэн төрийн бус 6 байгууллагаас 3 байгууллага (Өлзийт асар, Шинэ амьдрал ялагч, Титэм констракшн), магадлан итгэмжлэгдээгүй 3 ТББ (Сэргэлт өөд, Найдварын өргөө, Ган зам итгэл)-ыг төлөөлөл болгон сонгон авч холбогдох мэргэжилтнүүдтэй уулзаж ярилцлага хийсэн. Нийгмийн хамгааллын тусгай төв нь Монгол Улсын Засгийн газрын 2003 оны 06 дугаар сарын 04-ний өдрийн 138 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2003 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн 272, 2003 оны 10 дугаар сарын 07-ны өдрийн 417 дугаар захирамжаар байгуулагдсан тусгай статустай, төрийн үйлчилгээний байгууллага юм. Тус байгууллагад нийтдээ 19 хүн ажилладаг. Жилдээ дунджаар давхардсан тоогоор 39000 давхардаагүй тоогоор 460 хүнд үйлчилгээ үзүүлдэг. Байгууллагын хүчин чадал 150 хүн. Шинэ байр Баянзүрх дүүргийн 8-р хорооны нутаг дэвсгэрт баригдаж байгаа, одоогоор нийт ажлын 30 хувь нь хийгдсэн ба шинэ барилга ашиглалтанд орохоор 39 хүний орон тоотой, хүчин чадал 250 хүн болж нэмэгдэхээр төлөвлөгдөж байна. Нийгмийн хамгааллын тусгай төвөөс дараах үйлчилгээг ГОТИ-д үзүүлж байна. Үүнд:

- Бүртгэл судалгаа
- Хооллох, байршуулах
- Эрүүл мэндийн үйлчилгээ
- Сэтгэл зүйн үйлчилгээ
- Бичиг баримтжуулах
- Нийгмийн халамжийн бусад үйлчилгээ
- Сургалт, соёл хүмүүжлийн үйлчилгээ
- Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх
- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих
- Төсөл хөтөлбөрт хамруулах

- Бие даасан амьдралд шилжүүлэх.

Нийгмийн хамгааллын тусгай төв мэргэжлийн чиг баримжаа олгох 21 хоногийн эсгий урлал, оёдол, гар урлал, гар утас засварлах, цахилгаан засвар, үсчний мэргэжлээр сертификаттай сургалт явуулдаг нь ГОТИ-ийг нийгэмшүүлэхэд чухал ач холбогдолтой арга хэмжээ байсан ч Ковид-19 цар тахлын хоёр жилд мэргэжлийн чиг баримжаа олгох дээрх сургалтууд хийгдээгүй байна.

Нийгмийн халамжийн тухай хуулинд заасанчлан ГОТИ-дэд хүргэх үйл ажиллагааг олон нийтийн оролцоонд суурилан явуулахдаа ХХҮЕГ Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайдын (хуучин нэрээр) 2014 оны 5 дугаар сарын 12-ны өдрийн А/52 тоот тушаалаар батлагдсан “ОНОТХҮ үзүүлэх байгууллагыг магадлан итгэмжлэх журам”-ыг үндэслэн байгууллагын дэргэд магадлан итгэмжлэх орон тооны бус зөвлөл байгуулан ажилладаг байна. Энэ зөвлөл зорилтот бүлгүүд, энэ дотроо ГОТИ-ийн асуудлуудад үзүүлэх үйлчилгээ, аргачлал, санхүүжүүлэх зэрэг асуудлыг шийдвэрлэх үүрэгтэй бөгөөд тухайн чиглэлээр ажиллаж байгаа ТББ-ыг сонгох журмын дагуу магадлан итгэмжлэх ажлыг гүйцэтгэдэг. Магадлан итгэмжлэгдсэн төрийн бус байгууллагуудад жил бүр, өвлийн 3-5 сард хэдэн хүнд үйлчилгээ үзүүлсэнтэй нь уялдуулан холбогдох зардлыг нийгмийн халамжаас өгч байна. Харин магадлан итгэмжлэгдээгүй ТББ нь харьцангуй биеэ даасан, бусдаас хамааралгүй, ихэвчлэн шашны байгууллагын дэмжлэг, санхүүжүүлэлт, хандив тусламж, аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх замаар үйл ажиллагаагаа явуулж, өөрсдийн итгэл үнэмшлээр ГОТИ-дэд үйлчилгээ үзүүлж байна.

Ярилцлагад оролцсон магадлан итгэмжлэгдсэн, магадлан итгэмжлэгдээгүй ТББ-ууд нь өөрийн хүчин чадлаас хамааран харилцан адилгүй тооны хүмүүст үйлчилгээ үзүүлж байна. Тэд *Нийгмийн хамгааллын тухай* хуулийн 18.1-р заалтын дагуу үйлчилгээ үзүүлэх ёстой боловч **ихэнх магадлан итгэмжлэгдсэн ТББ байгууллагууд өнөөгийн байдлаар ГОТИ-ийг хооллох, байршуулахаас өөр үйлчилгээ үзүүлж чадахгүй, хүний нөөц, тохижилт хангалтгүй байна.** Түүнчлэн магадлан итгэмжлэгдсэн зарим байгууллага гэрээний дагуу биш ашгийн төлөө ажиллаж байгаа талаар ч ярьцгааж байв. Гэхдээ магадлан итгэмжлэгдсэн ТББ-ууд дунд **ахиц дэвшилтэй, үлгэр жишээ болохуйц байгууллагууд ч байна.** Тодруулбал, “Өлзийт Асар”, “Шинэ амьдрал-ялалт” ТББ-ууд ГОТИ-ийг хооллох, хоноглохаас гадна бага ч гэсэн нийгэмшүүлэх сургалт зохион байгуулж, хөдөлмөрлөх сонирхолтой хүмүүст ажиллах боломж олгон, урт хугацаанд байршуулах ажлыг хийж тодорхой үр дүнд хүрч байна (**Шигтгээ 4.6.5**).

Шигтгээ 4.6.5:

... Өвлийн улиралд нь төрөөс санхүүжүүлэлт авчихдаг, харин бусад үед нь хамтаараа барилгын бригад болоод ажилладаг. Манай бригадын залуучуудад компаниуд их ам сайтай байдаг. Мөн хүлэмжтэй ногоо тарьж өөрсдийнхөө хэрэгцээг хангаж байгаа. Тахиа, нохой үржүүлгийн ажил хийж байна. Өндөгөө өөрсдөө хэрэглэхинэ. Ингэж л ажиллаж жилийн туршид амьдрах санхүүжүүлэлтээ босгодог...

Үндсэн мэдээлэгчтэй хийсэн ярилцлага, Магадлан итгэмжлэгдсэн ТББ

ГОТИ-дэд үйлчилгээ үзүүлж байгаа ТББ-ууд дунд гэр оронгүй, тэнэмэл амьдралыг өөрийн биеэр туулж, даван гарсан хүмүүс багагүй байна. Эдгээр хүмүүс тэнэмэл амьдралтай иргэдэд чин сэтгэлээсээ хандаж, тэдэнд итгэл найдвар өгч, нийгэмшүүлэхэд хувь нэмэр оруулж байна.

Хүснэгт 4.6.3-т ГОТИ-дэд үйлчилгээ үзүүлдэг ТББ-ын үйл ажиллагаанд тулгамдаж буй асуудлуудыг багцлан харуулав. Үйлчилгээ үзүүлж байгаа байгууллагын төрлөөс үл хамааран ТББ-дад тулгардаг гол асуудлууд нь тэнэмэл иргэдийг бичиг баримтжуулах, эрүүл мэндийн үйлчилгээнд хамруулах, төсөв мөнгөний хүрэлцээгүй асуудал зэрэг болж байна. Энэ талаарх баримтыг мөн **Шигтгээ 4.6.6**-аас харах боломжтой.

Хүснэгт 4.6.3. ГОТИ-дэд түр хоноглох төвүүдээс үйлчилгээ үзүүлэхэд тулгамдаж буй асуудлууд, байгууллагын төрлөөр

Байгууллагын төрөл	Үйлчилгээ үзүүлэхэд тулгамдаж буй асуудлууд
Нийгмийн хамгааллын тусгай төв	<ul style="list-style-type: none"> • Төрийн байгууллагуудын хоорондын уялдаа холбоо хангалтгүй. Ялангуяа, эрүүл мэндийн даатгалгүйгээс нарийн мэргэжлийн эмч, эмнэлэгт үзүүлэх боломж муу. Мөн дүүрэг, хороо, аймгуудтай харилцахад маш хүндрэлтэй. • Иргэнийг бичиг баримтжуулах ажлыг хөөцөлдөхөд хүндрэлтэй. • Нийт төсвийн 80 хувь нь цалин, хоолонд зарцуулагддаг учраас нийгмийн бусад үйлчилгээ явуулахад хүрэлцдэггүй. Үүнээс үндсэн зарим зорилтуудыг хэрэгжүүлж чаддаггүй. • Нийгэмшүүлэх ажил хангалтгүй, үр дүн багатай • Байгууллагын үндсэн зорилт нь түр хоноглох гэж байгаа боловч ар гэр нь авахгүй, тухайн иргэн явахгүйгээс болоод хамгийн удаан үйлчлүүлж байгаа иргэн гэхэд тус төвд 19 жил амьдарч байна. • Ажиллагсдын эрүүл мэнд, аюулгүй байдал хангагдаагүй. • Хэрэгжиж байгаа дүрэм журам хуучирчихсан байгаа учраас өөрчлөх хэрэгтэй байна. Байгаа дүрэм журам нь хоорондоо зөрчилтэй яг мөрдөж дагах боломжгүй.
Магадлан итгэмжлэгдсэн ТББ	<ul style="list-style-type: none"> • Эрүүл мэндийн үйлчилгээ авахад хүндрэлтэй, ялангуяа донтолтын эмчилгээ хийлгэх шаардлагатай • Бичиг баримтжуулах асуудал маш хүндрэлтэй • Хувцаслах асуудал хүндрэлтэй • Нийгэмшүүлэх ямар ч зардал төрөөс өгдөггүй • Батлагдсан төсвийн хүрэлцээ муу, санхүүжүүлэлт цаг хугацаандаа ордоггүй, үнийн өсөлтийг тооцдоггүй • Сургалтын зардал өгдөггүй, модуль байхгүй
Магадлан итгэмжлэгдээгүй ТББ	<ul style="list-style-type: none"> • Эрүүл мэндийн үйлчилгээ авахад хүндрэлтэй, ялангуяа архины эмчилгээ хийх боломж муу • Бичиг баримтжуулахад хүндрэлтэй • Сэтгэл зүйч, сэтгэл засалч, сургагч багш ажиллуулах боломж муу • Тогтмол усанд оруулахад хүндрэлтэй бидэнд гэрээлэх байгууллага олдодгүй • Хувцасны асуудлаар хангахад хүндрэлтэй

Шигтгээ 4.6.6:

... Энд үйлчилгээ авч байгаа хүмүүсийн 90 хувь нь архины хамааралтай. Ачигдаад ирэхдээ архины гүн хордлогод орчихсон байдаг. Тэр хүмүүсийг хордлогоос гаргах хэрэгтэй болдог харамсалтай нь наркологийн эмч нар үзээд авдаггүй. За тэгээд гар хөл нь хөлдчихсөн, машинд дайруулчихсан гээд олон төрлийн ил гэмтэл бэртэлтэй хүмүүс ирдэг. Үнэхээр ялгаварлан гадуурхдаг манай хүмүүсийг авдаггүй. Манай байгууллага унаагүй учраас ажилчдынхаа унаанд суулгаад очиж байгаа шүү дээ...

Үндсэн мэдээлэгчтэй хийсэн ярилцлага, НХТТ

Батлагдсан төсвөөр хоол унд болон байршлын зардлыг хүргэхийн тулд махны үйлдвэрийн дайвар бүтээгдэхүүнийг гэрээгээр авч хэрэглэдэг, Солонгос, япон, хятад комиссын бараа борлуулагч иргэдтэй хамтран ажиллаж хямд үнээр хуучин гадуур, дотуур хувцас худалдан авдаг, мөн хүнсний бараа бүтээгдэхүүнийг бөөний үнээр хүргэлтээр авч л мөнгөө хүргэж байна.

Үндсэн мэдээлэгчтэй хийсэн ярилцлага Магадлан итгэмжлэгдсэн ТББ

Эдгээр хүмүүс бичиг баримтгүй, регистрээ мэдэхгүй, бичиг үсэггүй зэрэг олон хүн байна. Бичиг баримттай болгох гэхэд хороо дүүрэг, өрхийн эмнэлэгтэй хамтран ажиллах хэрэгтэй болно. Гэтэл хороо дүүргээс асуудал их гарна. Манай байгууллагыг дураараа хэсэг бүлэг гудамжны архичид цуглуулсан, үйлчилгээ үзүүлэх гэхээр лайтай гайтай, стандартын бус хүмүүс цуглуулсан мэтээр ханддаг.

Үндсэн мэдээлэгчтэй хийсэн ярилцлага, Магадлан итгэмжлэгдээгүй ТББ

ГОТИ-дэд үйлчилгээ үзүүлдэг ТББ-аас цаашид төр засаг болон холбогдох албад дараах асуудалд анхаарал тавих хэрэгтэй гэж үзэж байна. Үүнд: Сургалтын цогц модель стандарттай болох; Сэтгэл зүй, сэтгэл заслын үйлчилгээг хийх; Эрх зүйн орчинг бүрдүүлэх, хуульчилж өгөх; Төр, ТББ гэж зааглахгүй нэг стандарт, журам, сургалттай болох; Үйлчлүүлэгчдийг хөдөлмөрөөр хүмүүжүүлэх, ингэхийн тулд төв өөрийн гэсэн бие даасан ажлын байр, материаллаг бааз бий болгох; ГОТИ-ийн эрүүл мэндийн үйлчилгээ, бүртгэлжүүлэлтийн асуудлыг шийдэх; Сайн туршлага нэвтрүүлэх; ГОТИ-тэй ажилладаг ажиллагсдын нийгмийн асуудлыг сайжруулах, цалин нэмэх шаардлагатай зэрэг нь багтаж байна (**Шигтгээ 4.6.7**).

Шигтгээ 4.6.7:

...Гэр бүлийн тухай хуулинд ч гэсэн ГОТИ-ийг асрамжлах үүргийг оруулах хэрэгтэй. Нэг жишээ хэлэхэд нэр дээр нь их хэмжээний зээл авчихаад гэрээсээ хөөгөөд, хаячихсан тохиолдлууд багагүй байна. Зээлтэй настай хүмүүсийг асрамжийн газар авдаггүй шүү дээ. Түүнчлэн төрсөн эцэг, эхээ асрамжлахаас татгалзвал төрийн үйлчилгээ үзүүлэх эрхийг нь хязгаарлах заалт оруулах хэрэгтэй гэж бодож байна. Ийм тохиолдол ч багагүй байна. Ер нь иргэд үнэгүй үйлчилгээ авсаар байгаад бүр даварч байна. Иймээс албадан хөдөлмөр хийлгүүлж төлүүлэх заалтыг ч тусгах хэрэгтэй. Тэгэхгүй бол хүний эрх яриад л тэнэмэл байдлаа өөрийнхөө давуу тал болгоод байгаа хүмүүс эдний дунд олон байдаг...

Үндсэн мэдээлэгчтэй хийсэн ярилцлага, НХТТ

Шигтгээ 4.6.7 (үргэлжлэл):

...Судлаачдын үзэж байгаагаар наркологийн хор 3 жил болоод бүрэн гардаг юм байна. Тэгэхээр энэ хүмүүс түр хоноглоод гараад явчих биш энэ хүмүүст урт хугацааны нийгэмшүүлэх үйлчилгээ шаардлагатай болох нь харагдаж байна. Иймээс ажил эдгээр иргэдээр тодорхой хэмжээний цалинтай, цалингаас нь төв үйлчилгээнийхээ хөлсийг суутгадаг, ар гэрт нь тодорхой хувийг, мэдээж өөрийнх нь гар дээр мөнгө өгөх гээд орлогыг нь хувь тэнцүүлээд хуваачихвал аль аль талдаа ашигтай, дээр нь ажлын амтанд орж нийгэмших процесс нь хурдан явагдана гэж ойлгож болно...

Үндсэн мэдээлэгчтэй хийсэн ярилцлага, НХТТ

Монгол Улсад ГОТИ гэж хэнийг хэлэх талаарх тодорхойлолт байхгүй учраас эрх зүйн хүрээнд тодорхойлж гаргах шаардлага зүй ёсоор тавигдаж байна. Иймээс судалгаанд хамрагдсан төрийн болон ТББ-дын оролцогчдоос ГОТИ гэдэгт ямар хүнийг хамруулах вэ, тэдний шинж байдлын талаар хэлнэ үү гэсэн асуултаар мэдээлэл цуглуулсан юм. Үр дүнг **Зураг 4.6.1**-д нэгтгэн харуулав.

Зураг 4.6.1. ГОТИ-ийг тодорхойлох талаарх төрийн, ТББ-ын мэргэжилтнүүдийн санал

ГОТИ гэж хэнийг хэлэх вэ?

- ГОТИ гэдгийг монголын нөхцөлд хоёр хуваан авч үзнэ. Нэгдүгээрт, огт гэр оронгүй иргэд, хоёрдугаарт, өөрийн орон гэртэй мөртлөө гэр бүлийн хүрээнд дасан зохицож амьдарч чадахгүй, гэр бүлийн гишүүд нь хүлээж авдаггүй хүмүүсийг хэлнэ.
- ГОТИ гэдэгт гэр оронгүй тэнэж амьдардаг, гэр орноосоо дайжсан, нийгэмд хүлээн зөвшөөрөгдөхөө больсон, гэр бүл хамаатан садан байвч гэрээсээ хөөгдсөн хүмүүсийг хэлнэ. Энд хараа хяналтгүй хүүхэд, ахмадын асрамжийн гэр оронгүй настан бас багтана. Насны хязгаар тавьж болохгүй.
- ГОТИ орон гэртэй боловч ямар нэгэн шалтгаанаар гэрээсээ дайжсан, хорих ял эдлээд гарч ирэхэд нь ар гэр нь хүлээж авдаггүй, хөдөөнөөс ирээд хөл алдсан, архины хамааралтай хүнийг хэлнэ.
- ГОТИ гэдэг нь амьдрах орчин нь бүрдээгүй, тэнэмэл, айлаар явж амьдардаг, орц, траншейн зэрэг хүн амьдрах боломжгүй газарт амьдарч байгаа хүнийг хэлнэ.
- ГОТИ гэдэг нь хүний эрхийн бүх үйлчилгээ авч чадахгүй, эдлэх эрхээ ч эдлэж чадахгүй хүнийг хэлнэ.

ГОТИ-ийн шинж байдал

- Архинд донтсон
- Бохир
- Тогтсон гэр оронгүй
- Багадаа өнчирсэн
- Салсан
- Хөдөөнөөс ирээд хөл алдсан
- Хүчирхийлэлд өртсөн
- Эцэг эх нь салсан, нас барсан
- Ажилгүй
- Орлогогүй
- Тогтсон хаяггүй
- Иргэний баримт бичиггүй, бичигтэй ч өөрт нь байдаггүй
- Гэр бүл, хамаатан садангүй
- Өөртөө итгэлгүй
- Сэтгэцийн өөрчлөлттэй
- Түр хоноглох байранд амьдардаг

Судалгааны мэдээлэл цуглуулагчид ГОТИ-ээс судалгаа авахдаа тэдний шинж байдлын талаар ажиглалт явуулж тухайн хүн бүрийн асуулгын хуудасны дор тэмдэглэл хөтөлсөн. Энэхүү ажиглалтын тэмдэглэлийг нэгтгэн дүгнэж, **Зураг 4.6.2**-т харуулав.

Зураг 4.6.2. ГОТИ-ийн талаарх судлаачдын ажиглалт*Гадаад төрх*

- Бэртэлтэй
- Ядруу
- Бохир, заваан
- Хувцаслалт муу
- Шартсан
- Хөгжлийн бэрхшээлтэй
- Согтуу
- Шарх сорвитой

Жич: Түр хоноглох төвүүдэд байгаа хүмүүс харьцангуй цэвэрхэн хувцасласан, архи уугаагүй, тогтмол хоол ундтай болохоор царай зүс нь сайхан байв.

Нийтлэг зан төрх

- Нээлтэй биш
- Өөртөө итгэлгүй
- Зожиг
- Ганцаардмал
- Ноомой, дуу цөөтэй
- Үл итгэсэн
- Эргэж буцсан
- Сэтгэл зовсон шинжтэй
- Уцаартай
- Хэл ярианы бэрхшээлтэй
- Шаналсан

Жич: Зарим хүмүүс яриасаг, илэн далангүй байсан...

4.6.2. ГОТИ-ийн үйлчилгээ авч буй байдал**ГОТИ-ийн нийгмийн суурь үйлчилгээнд хамрагдах байдалд дараах тулгамдсан асуудал байна:**


- ГОТИ-ийн 45.7% иргэний үнэмлэхгүй байна. Үнэмлэхгүй байдал түр хоноглох төвөөс гадуур байгаа, орон нутгаас шилжин ирсэн, боловсрол доогуур ГОТИ-ийн дунд өндөр байна.
- ГОТИ-ийн дийлэнх нь өөрийн хариуцлагагүй байдлаас болж иргэний үнэмлэхээ алдсан, улмаар нийгмийн суурь үйлчилгээг хүртэх боломжгүй байна.
- Гэр оронгүй, тэнэмэл гурван иргэн тутмын хоёр нь эрүүл мэндийн даатгалд хамрагдаагүй, 92.1% нь нийгмийн даатгалд хамрагдаагүй ба эдгээрийн гол шалтгаан нь ажил/орлогогүй байдал болж байна.
- Гэр оронгүй, тэнэмэл таван хүн тутмын нэг нь л төрөөс ямар нэгэн тэтгэвэр, тэтгэмж авдаг.
- ГОТИ төрийн үйлчилгээний байгууллагууд дундаас эрүүл мэндийн байгууллагад хамгийн их ханддаг, тэндээсээ ч дийлэнх нь тусламж авч чадаж байна.
- ГОТИ-ийн нэн түрүүнд шийдвэрлэхийг хүсч байгаа асуудлууд нь өөрийн орон байртай болох (51.6%), ажил/орлоготой болох (41.0%), бичиг баримттай болох (15.3%), архины эмчилгээнд хамрагдах (15.1%), эрүүл мэндийн үйлчилгээнд хамрагдах (12.1%) зэрэг байна.

Судалгаанд хамрагдсан ГОТИ-ийн 45.7 хувь нь иргэний үнэмлэхгүй байна.

Хүн ам зүйн шинжээр нь авч үзвэл, иргэний үнэмлэхгүй тохиолдлын хувь гадуур байгаа тэнэмэл иргэдийн дунд (58 хувь) түр хоноглох төвд байршиж байгаа иргэдийнхээс 16.4 пунктээр, орон нутгаас шилжин ирсэн ГОТИ-ийн дунд (50.0 хувь) нийслэлийн уугуул иргэдийнхээс 10 орчим пунктээр, боловсролгүй иргэдийн дунд (54.6 хувь) дээд боловсролтой иргэдийнхээс 15.5 пунктээр өндөр байна (**Зураг 4.6.3**). Иймд, эдээгээр

ГОТИ дунд иргэний үнэмлэхээр авдаг төрөл бүрийн нийгмийн үйлчилгээнд хамрагдаж чадахгүй байх эрсдэл өндөр байна.

Зураг 4.6.3. ГОТИ-ийн хувийн жин, иргэний үнэмлэхтэй эсэхээр, хүн ам зүйн шинжээр.




Иргэний үнэмлэхгүй ГОТИ-ээс иргэний үнэмлэх байхгүй шалтгааныг тодруулахад 66.5 хувь нь гээгдүүлсэн, 10.3 хувь нь бусдад хадгалуулсан, 7.6 хувь нь огт авч байгаагүй, эсхүл 45 нас хүрээд сунгуулаагүй гэсэн хариултууд бусад шалтгаанаас өндөр хувьтай байна. Зээлийн барьцаанд тавьсан (4.9 хувь) гэсэн хариултын хувь бага хэдий ч анхаарал татаж байлаа. Ер нь бол тодорхой төлбөр төлж иргэний үнэмлэхээ дахин авах боломж эдгээр иргэдийн хувьд нээлттэй байгаа ч үнэмлэхгүй байгаагаас, ГОТИ-ийн дийлэнх нь өөрийн хариуцлагагүй байдлаас болж иргэний үнэмлэхээ алдсан, улмаар нийгмийн суурь үйлчилгээг хүртэх боломжгүй болжээ гэж дүгнэж болохоор байна.

“Монгол Улсын иргэн эрүүл мэндийн улмаас учирч болзошгүй санхүүгийн эрсдэлээ хуваалцах зорилгоор эрүүл мэндийн албан журмын даатгалд заавал даатгуулна. Эрүүл мэндийн даатгал нь албан журмын болон сайн дурын нэмэлт даатгал гэсэн төрөлтэй байна”²⁹ гэж *Эрүүл мэндийн даатгалын тухай* хуулинд заасан байдаг. Гэвч гэр оронгүй, тэнэмэл 3 иргэн тутмын хоёр нь эрүүл мэндийн даатгал төлөхгүй байна. Судалгаанд хамрагдсан ГОТИ-ийн 66.7 хувь нь эрүүл мэндийн даатгалын аль ч төрлийг төлдөггүй, 17.3 хувь нь төрөөс, 7.4 хувь нь өөрөө даатгалаа төлдөг бол бусад нь байрлаж байгаа төвөөс болон бусад эх үүсвэрээр төлүүлдэг гэж хариулжээ. Эрүүл мэндийн даатгал өөрөө төлдөг гэсэн хариултын хувь насны бүлэг нэмэгдэх тусам нэмэгдэж байна. Харин 60 ба түүнээс дээш насанд төрөөс төлдөг гэж ойролцоогоор хоёр

²⁹ “Эрүүл мэндийн даатгалын тухай хууль”, 4 дүгээр зүйл, 2015

хүн тутмын нэг хариулжээ. Үүнийг залуучуудын хувьд өвчлөх, эрүүл мэндийн эрсдлээс өөрийгөө хамгаалах талаар мэдээлэл сайтай байгаагаар, харин ахмадуудын хувьд эрүүл мэндийн даатгалыг төрөөс төлдөгтэй холбон тайлбарлаж болно.

Зураг 4.6.4 Эрүүл мэндийн даатгалд хамрагдсан ГОТИ-ийн хувь, төлбөрийн төрөл, байршиж буй газраар




Эрүүл мэндийн даатгалд хамрагдаагүй шалтгааныг авч үзвэл түр хоноглох төвд байршиж буй ГОТИ-ийн 53.0 хувь, гадуур хоноглож байгаа ГОТИ-ийн 75.6 хувь нь ажилгүй, орлогогүй учир хамрагдаагүй гэж хариулсан. Мөн түр хоноглох төвд байршиж байгаа ГОТИ-ийн 21.2 хувь, гадуур хоноглож байгаа ГОТИ-ийн 6.4 хувь нь даатгалд хамрагдах шаардлагагүй гэж хариулжээ.

Монгол Улсад ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, өнчин болон нярай хүүхдүүд, жирэмсний болон амаржсаны амралттай байгаа эмэгтэйчүүд, бие даан амьдрах чадваргүй олон хүүхэдтэй ганц бие эхчүүд зэрэг эмзэг бүлгийн иргэдэд төрийн дэмжлэг үзүүлэхэд төсвөөс санхүүждэг нийгмийн халамжийн тогтолцоо чухал үүрэг гүйцэтгэдэг. Өнөөгийн байдлаар Монгол Улсад төрөөс халамжийн чиглэлээр 72 төрлийн үйлчилгээ үзүүлж байна. Гэвч, **ГОТИ-ийн дийлэнх нийгмийн халамжийн үйлчилгээнд хамрагдаж чадахгүй байна.** Судалгаанд оролцож байгаа хүмүүс эмзэг бүлэгт хамаарагдаж, нийгмийн хамгааллын үйлчилгээнд хамрагдах зорилтот бүлгийн нэг билээ. Гэвч судалгаанд оролцогчдын 18.8 хувь нь, өөрөөр хэлбэл, таван хүн тутмын нэг нь л төрөөс ямар нэгэн тэтгэвэр, тэтгэмж авдаг гэж хариулжээ. Оролцогчдын шинж байдлаар харвал, 60 ба түүнээс дээш насныхан (60.9 хувь), бэлбэсэн (35.9 хувь), дээд боловсролтой (34.8 хувь), эмэгтэйчүүд (32.7 хувь)-ийн ямар нэгэн тэтгэвэр, тэтгэмж, халамж авдаг хувь бусдаасаа арай өндөр байна. Мөн түр хоноглох төвд байршиж байгаа хүмүүс гадуур амьдарч байгаа хүмүүсээс ойролцоогоор хоёр дахин их ямар нэгэн тэтгэвэр тэтгэмжийн үйлчилгээнд хамрагдаж чадсан байна.

ГОТИ төрийн үйлчилгээний байгууллагууд дундаас эрүүл мэндийн байгууллагад хамгийн их ханддаг, тэндээсээ ч дийлэнх нь тусламж авч чадаж байна. Хариулагчдаас төрийн аль нэг байгууллагад хандаж байсан эсэх талаар асуухад гурван хүн тутмын нэг нь өрх, дүүргийн гэх мэт улсын эмнэлэгт, долоон хүн тутмын нэг нь халамжийн мэргэжилтэн/байгууллагад, 8 хүн тутмын нэг нь нийгмийн ажилтанд хандаж байжээ.

Зураг 4.6.5 Төрийн аль нэг байгууллагад хандсан ГОТИ-ийн хувь, байгууллагын төрөл, байршиж буй газраар



Тэмдэглэл: хариулагч олон хариулт хэлж болох асуулт тул хариултын нийлбэр 100%-аас илүү.

ГОТИ-дэд нэн түрүүнд шийдвэрлэхийг хүсч байгаа ямар асуудал байгаа талаарх асуултанд оролцогчид: өөрийн орон байртай болох (51.6 хувь), ажил орлоготой болох (41.0 хувь), бичиг баримттай болох (15.3 хувь), архины эмчилгээнд хамрагдах (15.1 хувь), эрүүл мэндийн үйлчилгээнд хамрагдах (12.1 хувь), эхнэр/нөхөр/хүүхэдтэйгээ уулзах (9.1 хувь) гэсэн хариултуудыг хамгийн ихээр өгсөн болно. Эдгээр хариултаас дүгнэвэл, ГОТИ-дэд үйлчилгээ үзүүлж байгаа төрийн болон ТББ-уудын мэргэжилтнүүдийн хариулсан ГОТИ-ийн талаарх шийдвэрлэвэл зохих асуудлууд болон оролцогчдын хүсч байгаа зүйл хоорондоо нийцэж байна гэж болохоор байна.

4.7. Гэр оронгүй, тэнэмэл иргэдийн нийгмийн сүлжээ, хүрээлэл, өөрийгөө үнэлэх үнэлэмж

Масловын хэрэгцээний шатлалын онолын дагуу хувь хүмүүсийн амьдралын явцад хоол хүнс, хувцас, орон байр зэрэг физиологийн хэрэгцээ, ажил, орлого, эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын үйлчилгээ авах зэрэг нийгэм, эдийн засгийн аюулгүй байдлын хэрэгцээнээс гадна “харьяалагдах ба хайрлах хэрэгцээ”, “хүндлэх, хүндлүүлэх хэрэгцээ” зайлшгүй гардаг. Эдгээр хэрэгцээ ГОТИ-ийн хувьд хэр хангагдсан байдлыг бид энэхүү бүлэгт авч үзсэн. ГОТИ-ийн гэр бүл, найз нөхөд, хамт олон зэрэг нийгмийн хүрээлэл, сүлжээний байдлыг судлах замаар тэдний хувьд “харьяалагдах ба хайрлах хэрэгцээ” хэрхэн хангагдаж буйг 4.7.1 хэсэгт авч үзсэн. Мөн 4.7.2 хэсэгт ГОТИ-ийн өөрийн үнэлэмжид тулгуурласан байдлаар тэдний өөрийгөө хүндлэх, өөртөө итгэх, бусдаар хүндэтгүүлэх зэрэг “хүндлэх, хүндлүүлэх хэрэгцээ” хэрхэн хангагдаж байгаа талаар авч үзсэн.

4.7.1 ГОТИ-ийн нийгмийн харилцааны сүлжээ, хүрээлэл

ГОТИ-ийн нийгмийн харилцааны сүлжээ, хүрээлэлд дараах тулгамдсан асуудлууд байна:

- Гадуур хоноглож буй ГОТИ-ийн 51% гэр оронгүй найз, танилуудтайгаа хүрээлэл үүсгэн амьдарч байна.
- ГОТИ-ийн 49.4% нь гэр бүлийнхэнтэйгээ уулзах хүсэлтэй ч хүссэн үедээ уулзаж чаддаггүй.
- Бусдаас тусламж авах хэрэгцээ гарахад ГОТИ эхнэр/нөхөр/хүүхдээс илүүтэйгээр аав, ээж, ах, эгч дүү болон түр хоноглох төвийн ажилчдад ханддаг.
- ГОТИ дэмжлэг авахаар бусдад хандсан үедээ олон төрлийн дэмжлэг авдаг ч хоол хүнс, гутал хувцас, хоноглох байр зэрэг материаллаг тусламжийг л илүүтэй авдаг.
- ГОТИ хамгийн их тусалдаг, өөрт нь ойр дотно санагддаг хүнээр ах, эгч, дүү (27.9%) болон асрах/түр хоноглох төвийн ажилчид (20.7%)-ыг нэрлэсэн ч эдгээр нь хариулагчдын тал хувьд ч хүрэхгүй байна.
- Нийгмийн сүлжээ муутай байгаагаас ГОТИ ганцаардах, нийгмээс тусгаарлагдах, өөртөө итгэлгүй болох хандлага байна.

ГОТИ голчлон гэр оронгүй найзууд, танилуудтайгаа хүрээлэл үүсгэн хамт амьдарч байна. Тухайлбал, “сүүлийн 1 сард Та хэнтэй хамт амьдарч байна вэ?” гэсэн асуултад түр хоноглох төвд байгаа ГОТИ-ийн 80.7 хувь, гадуур хоноглож байгаа ГОТИ-ийн 51 хувь нь “гэр оронгүй найзууд, танилуудтайгаа” гэсэн хариултыг хэлжээ. Харин бусдаас харьцангуй тусгаарлагдмал буюу ганцаараа амьдарсан байдал гадуур хэсүүлэн хоноглож буй ГОТИ-ийн дунд (49.0 хувь) түр хоноглох байранд ирсэн иргэдийнхээс 4 дахин илүү, мөн эрэгтэй ГОТИ-ийн дунд эмэгтэйчүүдийнхээс 6.9-8.3 пунктээр илүү байна.

Шигтгээ 4.7.1:

... Гадуур явдаг байхдаа ганцаараа явдаг байсан. Бусад хүмүүстэй нэг их хамт уудаггүй байсан. Надад ганцаараа байх нь илүү амар санагддаг. Яагаад гэвэл олуулаа байхад хулгай, үл ойлголцол, зодоон гээд асуудал ихтэй. Ганцаараа явдаг байсан болохоор нэг их дээрэлхүүлж, дарамтлуулаад байдаггүй... Орон гэргүй гудамжинд амьдрахад найз нөхөдтэй болох, хүнтэй суух боломжийг хязгаарладаг учир нийгмээс тусгаарлагдаж их ганцаарддаг. Тэгээд орон гэргүй байгаа маань миний ажил олох боломжийг хязгаарлачихдаг. Хэвийн өглөө яваад, орой ирдэг ажил хийе гэхээр хаана амьдрах билээ? Гэхдээ ковид намжсаны дараа эргээд ажил хийгээд явна гэдэг талаараа ирээдүйдээ итгэлтэй байна...

Ганцаарчилсан ярилцлага, нас 34, эрэгтэй, ТББ-ын түр хоноглох байр

Судалгаанд оролцсон ГОТИ-ээс гэр бүлийнхэнтэйгээ “хүссэн үедээ уулзаж чаддаг эсэх”-ийг асуухад, тал хувь нь чаддаггүй гэсэн бол, 41.4 хувь нь уулзаж холбоотой байгаа, 9.6 хувь нь уулзахыг хүсдэггүй гэжээ. Уулзаж чаддаггүй хүмүүс гол шалтгаанаа өөрөө хүсдэггүй (31.4-38.1 хувь), гэр бүлийнхэн зөвшөөрдөггүй (19.7-30.2 хувь), хол амьдардаг (23.8-24.1 хувь), гэр нүүсэн/хаяг мэдэхгүй (12.7-17.5 хувь) зэрэгтэй холбон тайлбарласан байна.

Хэдийгээр ихэнх ГОТИ гэр бүлээс тусдаа амьдарч байгаа ч гэр бүл хамаатан саднаасаа бүрэн тусгаарлаагүй, өөрт тулгарсан бэрхшээл асуудлын үед эргээд аав, ээж, ах дүү, хуучны найз нөхөд, танилдаа ханддаг, тусламж дэмжлэг хүсдэг, тэр хэрээр туслуулж дэмжүүлээд явдаг хүмүүс ч байна. ГОТИ-дэд тусламж дэмжлэг үзүүлдэг харилцааны сүлжээг **Хүснэгт 4.7.1**-т харууллаа.

Хүснэгт 4.7.1. ГОТИ-ийн хувь, материаллаг эд зүйлсийн тусламж, сэтгэл санааны дэмжлэг, зөвлөгөө хэрэг болоход ханддаг, тусалдаг хүмүүсээ нэрлэсэн байдлаар

Тусламж, дэмжлэг авахаар хандсан хүмүүс	Түр хоноглох төвд байгаа ГОТИ		Гадуур хоноглож байгаа ГОТИ	
	Хандсан	Тусалсан	Хандсан	Тусалсан
Түр хоноглох/байрлуулах төв: ТББ	57.7	98.9	47.0	97.9
Түр хоноглох/байрлуулах төв: НХТТ	24.6	98.7	12.0	100.0
Сүмийн ажилтнууд, итгэгчид	24.3	98.6	30.0	96.7
Аав, ээж, ах/эгч/дүү	40.3	93.5	49.0	98.0
Хуучны найз нөхөд, танил	24.9	89.5	31.0	93.5
Одоогийн найз нөхөд, танил	18.0	87.3	26.0	96.2
Эхнэр, нөхөр, хүүхэд	17.0	88.5	13.0	100.0
Гэр бүлээс бусад садан төрөл	14.4	86.4	19.0	94.7
Ажилладаг байгууллага/хамт олон	8.5	100.0	10.0	100.0
Дотоод/гадаадын хүмүүнлэгийн байгууллага	3.0	88.9	4.0	100.0
Хөрш	0.7	50.0	1.0	100.0

Тэмдэглэл: хариулагч олон хариулт хэлж болох асуулт тул хариултын нийлбэр 100%-аас илүү.

Бусдаас тусламж дэмжлэг авах хэрэгцээ гарахад ГОТИ эхнэр/нөхөр/хүүхдээс илүүтэйгээр аав, ээж, ах, эгч дүү болон түр хоноглох төвийн ажилчдад ханддаг

байна. Өөрт нь материаллаг, материаллаг бус дэмжлэг хэрэг болоход давхардсан тоогоор түр хоноглох төвд байгаа ГОТИ-ийн 57.7 хувь нь төвийн ажилтанд, 40.3 хувь нь аав, ээж, ах, эгч, дүүдээ, 24.9 хувь нь хуучны танил/найз нөхөддөө ханддаг гэсэн нь бусад төрлийн хариултаас өндөр хувьтай байна. Харин гадуур хоноглож байгаа ГОТИ-ийн хувьд хамгийн их ханддаг хүмүүс нь аав, ээж, ах, эгч, дүү (49 хувь), ТББ-ын түр хоноглох байрны ажилтнууд (47.0 хувь), сүмийн ажилтан/итгэгчид (30 хувь), хуучны танил/найзууд (31 хувь) байна. ГОТИ бусдаас тусламж, дэмжлэг хүссэн үедээ ихэвчлэн дэмжлэг, туслалцаа авч чаддаг байна. Эхнэр/нөхөр, хүүхэддээ хандаж тусламж авдаг байдал дээрх хариултуудаас харьцангуй бага (13-17 хувь) байгаа нь тэдний гэр бүлийн харилцаа сул, үр хүүхэд, салсан эхнэр/нөхөртэйгээ асуудалтай, ихэнхдээ хол хөндий байдагтай холбоотой. Мөн чанарын судалгаагаар тэнэмэл, архины хамааралтай амьдралдаа өөрөө буруутай гэж үзэж байгаа учир ГОТИ тэр бүр гэр бүлдээ хандаад байх хүсэлгүйгээ илэрхийлж байсан (**Шигтгээ 4.7.2**).

ГОТИ-ийн бусдаас авдаг тусламж, дэмжлэгийг материаллаг болон материаллаг бус гэсэн хэсэгт хуваан хамгийн их авдаг давтамжаар эрэмбэлж, **Хүснэгт 4.7.2**-т харуулав. Ерөнхийдөө ГОТИ бусдаас олон төрлийн дэмжлэг авдаг ба материаллаг бустай харьцуулахад материаллаг тусламжийг илүү ихээр авдаг байна. Тухайлбал, бусдаас ямар нэгэн тусламж авч байсан ГОТИ-ийн 85.3%– 73.7% нь хоол хүнс, гутал хувцас, хоноглох байр зэрэг материаллаг тусламжийг авч байсан нь бусад төрлийн тусламжаас өндөр хувьтай байна. Материаллаг бус дэмжлэгийн хувьд, хамгийн их авсан нь “сэтгэл санаагаар дэмжих” (67.0 хувь), “бусдад өөрийгөө сонгож, ярилцах” (63.4 хувь), “сэтгэл заслын үйлчилгээ” (27.4 хувь) зэрэг дэмжлэгүүд байв. ГОТИ хамгийн их тусалдаг, өөрт нь ойр дотно санагддаг хүнээр ах, эгч, дүү (27.9 хувь) болон асрах/түр хоноглох төвийн ажилчид (20.7 хувь)-ыг нэрлэсэн байна. Энэ хариулт тухайн хүний гэрлэлтийн байдал, үр хүүхэдтэй эсэхээр онцын ялгаагүй байв.

Хүснэгт 4.7.2. Бусдад хандан, тусламж дэмжлэг авч байсан ГОТИ-ийн хувь, авсан тусламжаа нэрлэсэн байдлаар.



Нийгмийн сүлжээ муутай байгаагаас ГОТИ ганцаардах, нийгмээс тусгаарлагдах, өөртөө итгэлгүй болох хандлага байна. Ихэнх ГОТИ архины хамааралтай, ажилгүй, гэр бүл үр хүүхдийн өмнө хүлээх “үүрэггүй болсон”, нийгмийн байр сууриа алдсан байгаа нь

тэднийг ойр дотно хүмүүс нь хүлээж авахгүй, холбоо тасрах, улмаар нийгмээс тусгаарлагдах, өөртөө итгэлгүй болох нөхцөл болж байдгийг чанарын судалгаанд оролцогчдын ярилцлагаас харж болохоор байсан (**Шигтгээ 4.7.3**).

Шигтгээ 4.7.3:

... Сэтгэл санаагаар их унадаг байсан. Архи уугаагүй байсан бол гэр оронтой болчих байсан. Би ингэж явж байхаар үхье гэсэн бодол орж ирдэг байсан. Ах дүү нар туслах боломжтой боловч архи аваад уучихна гээд мөнгө төгрөг өгдөггүй. Энэ төвд ирснээр архи уухаа больж, ирээдүйдээ итгэлтэй болсон. Ахлагч маань надад их тусалдаг, миний хамгийн их итгэдэг хүн...

Ганцаарчилсан ярилцлага, нас 33, эмэгтэй, ТББ-ын түр хоноглох байр

4.7.2 ГОТИ-ийн өөрийгөө үнэлэх үнэлэмж

ГОТИ-ийн сэтгэл зүй (“харьяалагдах”, “хүндлэлийн” хэрэгцээгээ хангах байдал) дараах онцлогтой байна:


- “Холбоо хамаарал бүхийн асуумж”-аар ГОТИ-ийн 60% нь бие даан шийдвэр гаргах, хүнд нөхцлөөс өөрийгөө авч гарах, хүмүүс дорд үзэхэд тоохгүй байх, өөрийгөө хүндлэх, өөртөө итгэх, ирээдүйдээ итгэх зэрэг хувь хүний субьектив ур чадвартаа “сайн” үнэлгээ өгсөн. Мөн Розэнбергийн “өөрийгөө үнэлэх сэтгэл зүйн шинжүүр”-ээр ГОТИ-ийн 85.7% нь “дунджаас дээгүүр” түвшинд өөрийгөө үнэлсэн байна.
- ГОТИ өөрийгөө үнэлэх үнэлэмж өндөр байгаа нь соёлын онцлог буюу монгол хүний бие даасан хэв шинжтэй холбоотой байх талтай.
- Ихэнх ГОТИ өөрсдийн ур чадвар, сэтгэл зүйн байдлыг харьцангуй сайнаар үнэлж байгаа ч архины хамаарал, сөрөг зуршил, зан үйлийн сөрөг үйлдлүүд нь гэр бүл, үр хүүхэд, нийгэмд эзлэх байр сууриа алдах, сэтгэл зүйн хүнд нөхцөлд оруулдаг гэдгийг хүлээн зөвшөөрч байна.
- Дийлэнх ГОТИ архины хамааралтай (долоо хоног бүрт 4, түүнээс олон удаа архи хэрэглэдэг байдал эрэгтэйчүүдийн дунд 65.7%, эмэгтэйчүүдийн дунд 51.9%) байна.

Судалгаагаар гэр оронгүй иргэдийн өөрийгөө үнэлэх үнэлэмж, сэтгэл зүйн байдлыг илрүүлэх, хэмжихийн тулд бид “холбоо хамаарал бүхийн асуумж” болон Розэнбергийн “өөрийн үнэлгээг хэмжих сэтгэл зүйн тест”-ийн аргачлалыг ашигласан. Өөрийгөө үнэлэх нь тухайн хүний хүрээлэн буй орчинтойгоо харилцах харилцааг тодорхойлдог хамгийн чухал чанаруудын нэг юм. Розэнбергийн өөрийгөө үнэлэх хэмжүүр нь нийт 10 асуулттай бөгөөд тухайн хүн өөрийгөө дотооддоо эерэг эсвэл ямар нэг хэмжээгээр сөрөг хэмээн тодорхойлох субьектив үнэлгээг илэрхийлж, өөрийн үнэ цэнд итгэх итгэл, амьдрах, аз жаргалтай байх эрхтэй холбоотой эерэг зарчим, бодол санаа, хүсэл, хэрэгцээг зохих ёсоор илэрхийлэх мэдрэмжийг тодорхойлдог юм. Энэ тестээр хүн өөрийгөө хэр зэрэг хүндэлдгийг тодорхойлох боломжтой бөгөөд хувийн шинж чанарыг илүү илэрхийлдэг.

ГОТИ-ийн аливаа асуудалд хариу арга хэмжээ авах байдал, тэмцэх чадвар, сэтгэлийн тэнхээтэй байх зэрэг хувь хүний субьектив чадварыг 1) *Бие даан шийдвэр*

гаргах байдал, 2) Хүнд нөхцлөөс өөрийгөө авч гарах чадвар, 3) Бусад хүмүүс дорд үзэхэд тоохгүй/хямрахгүй байх чадвар, 4) Өөрийгөө хүндлэх, өөртөө итгэлтэй байдал, 5) Ирээдүйдээ итгэх байдал, гутранги бус байдал гэсэн үзүүлэлтүүдээр өөрсдөөр нь үнэлүүлсэн. Ингэхдээ үзүүлэлт бүрт сайн, дунд, муу, огт байхгүй гэсэн хувилбар бүхий хариултуудаас сонгуулан үнэлүүлсэн. Судалгааны үр дүнг нэгтгэхэд, **ГОТИ-ийн 60% нь бие даан шийдвэр гаргах, хүнд нөхцлөөс өөрийгөө авч гарах, хүмүүс дорд үзэхэд тоохгүй байх, өөрийгөө хүндлэх, өөртөө итгэх, ирээдүйдээ итгэх зэрэг хувь хүний субъектив ур чадвартаа “сайн” үнэлгээ өгсөн.** Хүн ам зүйн шинжээр нь ГОТИ-ийг бүлэглэн авч үзвэл: ГОТИ-ийг хаана байрлаж буйгаар нь ангилж, өөрийн ур чадвараа үнэлсэн байдал нь хэр ялгаатай байгааг харвал, ихэнх үзүүлэлтэд илэрхий ялгаа харагдахгүй байна. Мөн хүйсээр авч үзвэл, өөрийн ур чадварын үнэлгээнд мөн л илэрхий ялгаатай байдал харагдахгүй байна.

Зураг 4.7.2 ГОТИ-ийн хувийн жин, өөрийн ур чадварыг үнэлсэн байдлаар, хүйсээр



Розенбергийн “өөрийгөө үнэлэх сэтгэл зүйн шинжүүр”-ээр илрүүлсэн ГОТИ-ийн сэтгэл зүйн байдлын талаарх үр дүнг нэгтгэж харуулав. Тус шинжүүрээр хариулагчийн өөрийн үнэлэмжийг тодорхойлохдоо, сэтгэл зүйн хэмжүүр үзүүлэлтдээ өгсөн хариултыг нь тодорхой оноонд шилжүүлдэг ба хариулагч бүх хэмжүүр үзүүлэлтүүдээс нийт 10-18 оноо авбал “бага”, 19-22 оноо авбал “дундаж”, 23-34 оноо авбал “дунджаас дээгүүр”, 35-40 оноо авбал “өндөр” түвшинд өөрийгөө үнэлсэн гэж үздэг. Розенбергийн “өөрийгөө үнэлэх сэтгэл зүйн шинжүүр”-ээр ГОТИ-ийн дийлэнх нь “дунджаас дээгүүр” түвшинд өөрийгөө үнэлж байна. **Розенбергийн “өөрийгөө үнэлэх сэтгэл зүйн шинжүүр”-ийн³⁰ үр дүнг харвал оролцогчдын 85.7 хувь нь 23-34 оноотой буюу “өөрийн үнэлэмж дунджаас дээгүүр” байна.** Хүйсээр ялган харвал, эрэгтэйчүүдийн 85.6 хувь,


³⁰ Morris Rosenberg, “Society and the adolescent self-image,” Princeton university press, 2015.

эмэгтэйчүүдийн 82.4 хувь нь өөрийн үнэлэмж дунджаас дээгүүр байна. Энэ нь ГОТИ-ийн хувьд өөртөө итгэх итгэлтэй байдал давамгайлсан, өөрийгөө хүндэлдэг үнэлэмжийн түвшин харьцангуй өндөр байгааг илэрхийлж байна. Розенбергийн шинжүүрээр үнэлсэн өөрийн үнэлэмжийн үзүүлэлтийг хариулагчдын хүн ам зүйн шинжүүдээр задалж харвал, түр хоноглох төвд эсхүл гадуур хэсч явдаг эсэх, боловсролын байдал, гэрлэлтийн байдал, хүүхэдтэй эсэх, орон гэргүй явсан хугацаанаас үл хамааран өөрийгөө үнэлэх үнэлэмж 23-34 оноо буюу дунджаас дээгүүр байна. Энэ нь ГОТИ өөрийн давуу болон сул талуудыг хангалттай үнэлж чаддаг, буруутай гэдгээ хүлээн зөвшөөрч чаддаг, бүтэлгүйтсэн тохиолдолд өөрийгөө хүндэтгэдэг, өөртөө итгэх итгэлтэй, гэхдээ заримдаа өөрийгөө удаан хугацаагаар буруутгах (85 хувь) хандлагатай байгааг харуулж байна. **ГОТИ өөрийгөө үнэлэх үнэлэмж өндөр байгаа нь монгол хүний бие даасан хэв шинжийн онцлогтой холбоотой хэмээн үзэж байна.** Энэ нь гэр оронгүй, тэнэмэл амьдалтай хүмүүсийн бүлэгт хамрагдаж буй байдлаасаа шалтгаалахгүйгээр хувь хүн өөрийгөө тусдаа, бие даасан, онцгой гэж үзэх үзлийн илэрхийлэл бөгөөд монгол ахуй, соёлын хүчин зүйлстэй ч холбоотой гэж үзэж болно. Монгол ахуй, соёл зарим улс орнуудтай харьцуулахад хувь хүний бие даасан байдал, индивидуал байдлаараа ихээхэн ялгаатай. Тухайлбал ард түмний соёлын ялгааг тодорхойлох гол хүчин зүйл болох *эрх мэдлийн зааг* (аливаа бүлэг дотор эрх мэдлийн тэнцүү бус хуваарилалтыг хэвийн зүйл хэмээн хүлээн авах үзүүлэлт), *бие даасан хэв шинж* (бүлэгт хамрагдаж буй байдлаасаа шалтгаалахгүйгээр хувь хүн өөрийгөө тусдаа бие даасан, онцгой гэж үзэх), *эрэгтэйлэг хэв шинж* (өрсөлдөх чадвар, хувийн амбиц, ажил, эд баялгийн амжилт), *эрсдэлээс зугатах хандлага* (тодорхойгүй, зааваргүй, эрсдэлтэй үйлдлүүдээс нарийн зааварчилгаа, тодорхой хууль дүрмийг илүүд үзэх хандлага), *алсын хараа* (тэвчээртэй, тууштай, биеэ хянасан зэрэг ирээдүйд чиглэсэн хэв маягийг шулуухан, биеэ сул тавьсан, өнөөдөртөө амьдарсан хэв маягаас илүүд үзэх байдал) гэсэн таван үзүүлэлтээр Орос, Монгол, Польшийн иргэдтэй харьцуулахад Монголчуудын хувьд индивидуал буюу бие даасан хэв шинж, эрсдлээс зугатах хандлага гэсэн хоёр үзүүлэлтийн хувьд өндөр байдаг.³¹ Харин индивидуал буюу бие даасан хэв шинжийн үзүүлэлтээр Зүүн Өмнөд Азидаа Монголчууд өндөр үзүүлэлттэй байдаг нь ГОТИ-ийн өөрийн ур чадварын үнэлэмж өндөр гарсан үзүүлэлттэй нийцэж байна.

Өөрийн ур чадвар, үнэлэмж нь дунджаас дээгүүр түвшинд хэдий ч **дийлэнх буюу эрэгтэйчүүдийн дунд 65.7 хувь, эмэгтэйчүүдийн дунд 51.9 хувь нь долоо хоног бүрт 4 ба түүнээс дээш удаа архи хэрэглэж, архины хамааралтай байна.** Гэр бүлийн хувьд салсан, ганц бие, хүүхэдтэй, 3-аас дээш жил орон гэргүй тэнэмэл амьдралаар яваа иргэдийн 81.3-аас дээш хувь нь өөрсдийгөө архины хамааралтай байгааг хүлээн зөвшөөрч байна.

³¹ Aleksandra Tkaczyk, Z. B. (2010). Cultural dimensions analysis.

Зураг 4.7.3 ГОТИ-ийн хувийн жин, архи, согтууруулах ундаа хэрэглэдэг байдал, хүйсээр



Ийнхүү архины хамаарал ГОТИ нарын дунд маш өндөр байгаагаас тэд гэр бүл, үр хүүхэд, нийгэмд эзлэх байр сууриа алдах зэрэг олон асуудалд хүрсэн нь харагдсан ба үүнийгээ ч ихэнх нь хүлээн зөвшөөрснийг чанарын судалгааны маш олон баримтуудаас харах боломжтой байсан. Мөн ГОТИ-ийн хувьд өөрийн амьдралын хэв маяг, нөхцөл байдалдаа өөрийгөө буруутгах хандлага дийлэнхи хувийг эзэлж байна. Тухайлбал эрэгтэйчүүдийн 85.8 хувь өөрийгөө буруутгасан бол 5.4 хувь нь эхнэр, хамаатан гэр бүл найз нөхдөө, 2 хувь нь “хувь тавилан нөхцөл ийм болголоо”, 1.4 хувь төр засаг буруутай гэж үзсэн байна. Харин эмэгтэйчүүдийн 76.9 хувь нь өөрийгөө, 13.5 хувь нь нөхөр хамаатан садан, гэр бүл, ээж аав, найз нөхөд гэх мэт бусад хүмүүсийг буруутай хэмээн үзсэн байна. Энэ хариултын хувь нас, хүйс, боловсрол, гэрлэлтийн байдал, хүүхэдтэй эсэх, шилжилт хөдөлгөөн, орон гэргүй болсон хугацаагаар харьцуулахад ялгаа төдийлөн харагдахгүй өөрийгөө буруутгах хандлага 81.1 хувиас дээш байна.

5. УЛААНБААТАР ХОТЫН ГЭР ОРОНГҮЙ, ЗОРИУЛАЛТЫН БУС СУУЦАНД АМЬДАРЧ БУЙ ИРГЭДИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

Орон сууцны орц, хонгил зэрэг зориулалтын бус сууцанд амьдарч буй иргэдийн хувьд тэднийг гэр оронгүй иргэд гэж томъёолох хууль эрх зүйн баримт бичиг Монгол улсад байхгүй ч олон улсын ойлголт, тодорхойлолт болон судалгааны хүрээ тодорхойлох уулзалтын үеэр талуудын тавьсан хүсэлтийн дагуу энэхүү судалгаанд тодорхой төлөөллийг хамруулан судаллаа. Улаанбаатар хотод амьдарч буй гэр оронгүй, зориулалтын бус сууцанд амьдарч буй иргэдийн хүн ам зүйн шинж, өдөр тутмын амьдралын ахуйн нөхцөл, эрүүл мэнд, орлого ба амьжиргааны байдал, зориулалтын бус сууцанд амьдрах болсон шалтгаан, өөрийн үнэлэмж, нийгмийн хүрээлэл, төрийн ба төрийн бус байгууллагуудын үйлчилгээнд хамрагдаж буй байдал зэргийг энэхүү бүлэгт авч үзсэн.


5.1. Гэр оронгүй, зориулалтын бус сууцанд амьдарч буй иргэдийн хүн ам зүйн шинж байдал

Судалгаанд хамрагдсан ГОЗБСАИ-ийн хүн ам зүйн шинж дараах онцлогтой байна:

- Гэр оронгүй, зориулалтын бус сууцанд амьдарч буй 10 хүн тутмын 7 нь эмэгтэй, 64% нь 45-аас дээш насны иргэд байна.
- Орон нутгаас 2010 оноос хойш шилжин ирсэн ГОЗБСАИ-ийн 71.2% нь Улаанбаатарт хаягийн бүртгэлгүй байна.
- ГОЗБСАИ-ийн дундах боловсрол, бичиг үсгийн мэдлэгийн түвшин улсын дунджаас доогуур байна.
- ГОЗБСАИ-ийн дунд гэр бүл салсан, бэлэвсэн иргэдийн хувийн жин өндөр байна.


Судалгаанд ГОЗБСАИ-ээс 200 хүнийг хамруулсан бөгөөд эдгээр иргэдийн 29.5 хувь нь эрэгтэй, 70.5 хувь нь эмэгтэй байв. Судлагдсан ГОЗБСАИ-ийн нас, хүйсийн бүтцийг суваргаар **Зураг 5.1.1**-д харуулав. Судлагдсан гэр оронгүй зориулалтын бус сууцанд амьдарч буй 3 хүн тутмын 2 нь эмэгтэй, дундаж нас нь 46.4 байна. Судалгаанд хамрагдсан ГОЗБСАИ-ийг хүйсээр харвал эмэгтэйчүүд давамгайлж байсан бөгөөд хүйсийн харьцаа нь 2 эмэгтэйд 1 эрэгтэй ногдож байна. Насны бүтцээр авч үзвэл ГОЗБСАИ-ийн дундаж нас 46.4, хамгийн залуу нь 19, хамгийн ахимаг нь 72 насны хүмүүс байна. Голч насаар нь харвал, ГОЗБСАИ-ийн тал хувь нь 49 хүртэл, үлдсэн тал хувь нь 49-өөс дээш насны иргэд байв. Эдгээр насны үзүүлэлтийг нарийн задалж харвал, ГОЗБСАИ-ийн 64 хувь нь 45-аас дээш насны, үүний 45.0 хувь нь эмэгтэйчүүд байна.

Зураг 5.1.1. Судалгаанд хамрагдсан ГОЗБСАИ-ийн хувь, нас, хүйсээр




Улаанбаатарт байгаа, судалгаанд хамрагдсан гэр оронгүй, зориулалтын бус сууцанд амьдарч буй 3 иргэн тутмын нэг нь орон нутгаас шилжин ирэгчид байна. Шилжих хөдөлгөөний байдлаар нь ялган харвал, нийслэлийн уугуул ГОЗБСАИ-ийн 95.5 хувь, 2010 оноос өмнө шилжин ирэгчдийн 82.8 хувь, 2010 оноос хойш шилжин ирэгчдийн 28.8 хувь нь Улаанбаатар хотын аль нэг дүүрэг, хороонд хаягийн бүртгэлтэй гэжээ (Зураг 5.1.2).

Зураг 5.1.2. Улаанбаатар хотын аль нэг хороонд хаягийн бүртгэлтэй ГОЗБСАИ-ийн эзлэх хувь, шилжих хөдөлгөөнд оролцсон эсэхээр



ГОЗБСАИ-ийн боловсролын үзүүлэлтүүд улсын дунджаас доогуур, эрэгтэй ГОЗБСАИ-ийн боловсрол эмэгтэйчүүдийнхээс доогуур байна. Судлагдсан ГОЗБСАИ-ийн 8.5 хувь нь дээд, 12.5 хувь нь техникийн болон тусгай мэргэжлийн, 44.0 хувь нь бүрэн дунд, 21.5 хувь нь суурь, 5.5 хувь нь бага боловсролтой байгаа бол 8.0 хувь нь боловсролгүй байна. Боловсролгүй гэж хариулсан ГОЗБСАИ-ийн бичиг үсгийн мэдлэгийн байдлыг харвал, 12.5 хувь нь энгийн өгүүлбэр уншиж, бичиж чаддаг, 50.0 хувь нь энгийн нэмэх, хасах үйлдлийг хийж, тоо бодож чаддаг гэжээ.

Зураг 5.1.3. Судалгаанд хамрагдсан ГОЗБСАИ-ийн хувь, боловсролын түвшнээр




ГОЗБСАИ-ийн дунд гэрлэлтээ цуцлуулсан, тусгаарласан, бэлэвсэн хүмүүс их байна. ГОЗБСАИ-ийн дунд гэр бүл салсан, бэлэвсэн иргэдийн хувийн жин улсын дунджаас өндөр байна (тус бүр 4.8 болон 3.2 дахин)

Зураг 5.1.4 Судалгаанд хамрагдсан ГОЗБСАИ-ийн хувь, гэрлэлтийн байдлаар



Судалгаанд хамрагдсан ГОЗБСАИ-ийн 87.5 хувь нь хүүхэдтэй (**Зураг 5.1.5**) ба хүүхэдтэй нэг иргэн дунджаар 2.7 хүүхэдтэй, үүнээс 16 ба түүнээс доош насны хүүхдийн тоо 0.9 байна. Тэдгээр иргэдийн 61.1 хувь нь хүүхэдтэйгээ хамт амьдардаг/уулздаг гэж мэдээлсэн.

Зураг 5.1.5 Судалгаанд хамрагдсан хүүхэдтэй ГОЗБСАИ-ийн хувь



5.2. Гэр оронгүй, зориулалтын бус сууцанд амьдардаг иргэдийн ахуйн нөхцөл

Судалгаанд хамрагдсан ГОЗБСАИ-ийн ахуйн нөхцөлд дараах гол анхаарах зүйлс байна:

- ГОЗБСАИ харьцангуй урт хугацаанд (дунджаар 7.6 жил, медиан үзүүлэлт 5 жил) зориулалтын бус сууцанд амьдарч буй иргэд байна.
- Хүн ам зүйн шинжээр эмэгтэй, ахимаг насны, бэлэвсэн, боловсрол доогуур иргэд илүү урт хугацаагаар хүн амьдрах зориулалтгүй сууц/газарт амьдарч байна.
- Судалгаанд хамрагдсан зориулалтын бус сууцанд амьдарч буй 10 хүн тутмын 1 нь урьд өмнө өөрийн гэсэн гэр оронгүй, эсхүл засан хүмүүжүүлэх, асрамжийн газраас гарсан, 4 нь түрээсийн байр/гэр болон хамаатан/найзындаа байсан, бусад нь өөрийн орон сууц, хашаа байшин/гэртэй байсан иргэд байна.
- ГОЗБСАИ жилийн ихэнх хугацаанд орон сууцны орцны хэсэг, хонгилд амьдардаг ба хүйтний үед энэ байдал (82.5%) нь дулааны улирлынхаас 9 пунктээр илүү байна.
- ГОЗБСАИ-ийн дийлэнх нь дулааны ба хүйтний улиралд төвлөрсөн шугамаас ундны усаа авч хэрэглэж баайгаа ч усаа зөөвөрлөж хэрэглэдэг тул усны ариун цэврийн байдал алдагдах эрсдэлтэй байна.

Судалгаанд хамрагдсан ГОЗБСАИ-ийн зориулалтын бус сууцанд амьдарч буй хугацаа нь дунджаар 7.6 жил байна (**Хүснэгт 5.2.1**). Хугацааг медиан үзүүлэлтээр авч үзвэл, ГОЗБСАИ-ийн тал хувь нь 5 хүртэл жил, харин үлдсэн тал хувь нь 5-аас дээш жил зориулалтын бус сууцанд амьдарч буй иргэд байв. Судалгаанд хамрагдсан ГОЗБСАИ дунд хамгийн багадаа 1 жил хүрээгүй, хамгийн ихдээ 32 жил гэр оронгүй, хүн амьдрах зориулалтын бус газарт амьдарсан хүмүүс байгаагаас дүгнэвэл, тэдний гэр оронгүй амьдрах нь ужгирсан асуудал болох нь харагдлаа.

Хүснэгт 5.2.1. ГОЗБСАИ-ийн хувийн жин, зориулалтын бус сууцанд амьдарч буй хугацаагаар, хүн ам зүйн шинж байдлаар

Хүн ам зүйн шинж байдал	Зориулалтын бус сууцанд амьдарч буй хугацаа (жил)					Хариулагчдын тоо
	Дундаж	Стандарт хазайлт	Хамгийн бага	Хамгийн их	Медиан	
Хүйс						
Эрэгтэй	6.6	6.4	0.0	28.0	4.0	57
Эмэгтэй	8.1	7.0	0.0	32.0	6.0	137
Насны бүлэг						
19-35	4.8	5.1	0.0	27.0	3.0	39
36-45	5.6	5.7	1.0	26.0	4.0	35
46-55	8.2	6.8	0.0	27.0	6.0	71
56+	10.6	7.6	1.0	32.0	10.0	49
Гэрлэлтийн байдал						
Гэрлээгүй	5.0	4.5	0.0	15.0	3.0	31
Гэрлэсэн/хамтран амьдрагчтай	7.8	7.8	0.0	32.0	4.0	90

Салсан/тусгаарласан	7.6	6.4	0.0	26.0	6.0	38
Бэлэвсэн	9.5	6.0	1.0	25.0	9.0	35
Боловсролын түвшин						
Боловсролгүй, бага	8.7	7.4	1.0	28.0	8.0	26
Суурь	10.2	6.7	1.0	27.0	9.0	42
Бүрэн дунд	7.2	7.3	0.0	32.0	4.0	87
Тусгай дунд/дээд	5.1	4.5	0.0	17.0	4.0	39
Хүүхэдтэй эсэх						
Тийм	7.9	6.7	0.0	32.0	6.0	171
Үгүй	5.7	7.6	0.0	28.0	3.0	23
Шилжих хөдөлгөөнд оролцсон байдал						
Нийслэлийн уугуул	8.2	7.5	1.0	32.0	5.5	62
Шилжин ирэгч	7.4	6.6	0.0	27.0	5.0	132
Нийт ГОЗБСАИ	7.6	6.9	0.0	32.0	5.0	194*

*6 иргэн асуултад мэдэхгүй/санахгүй гэж хариулсан.

ГОЗБСАИ жилийн ихэнх хугацаанд орон сууцны орцны хэсэг, хонгилд амьдардаг ба хүйтний үед энэ байдал (82.5 хувь) нь дулааны улирлынхаас илүү байна. Судалгаанд хамрагдсан ГОЗБСАИ -ийн дийлэнх нь сүүлийн нэг жилд цэвэрлэж, манах зэрэг ажил хийдэг ажлын байрныхаа аль нэг хэсэг/булан, хонгилд буюу хүн амьдрах зориулалтгүй газарт гэр бүлийн хамт амьдарсан байна. Тодруулбал, дулааны улиралд ГОЗБСАИ-ийн 83.5 хувь, хүйтний улиралд 92.5 хувь нь орц, хонгил, хонгилд амьдарсан байгаа (**Хүснэгт 5.2.2**) ба уг оромж/байр нь зай талбай, агааржуулалт, ариун цэврийн байгууламж, усан хангамж, гэрэлтүүлэг, цахилгаан, дуу чимээ тусгаарлах, аюулгүй байдал гэх мэт маш олон талаасаа хүн тухтай амьдрахад шаардлагатай наад захын нөхцлийг хангаагүй орчин юм. **Зураг 5.2.2**-т Улаанбаатар хотын орцонд амьдардаг өрхүүдийн нийтлэг төрхийг жишээ болгон харууллаа. Дээрхээс гадна судалгаанд хамрагдсан ГОЗБСАИ дунд өнгөрсөн 1 жилд орцноос өөр газарт, тухайлбал орчин үеийн төвлөрсөн халаалт, ус, ариун цэврийн шугам сүлжээнд холбогдоогүй нийтийн байр, хамаатан/найз, танилынд, эсхүл бүр гадуур хэсүүчлэн хоноглох тохиолдол ч байжээ.

Хүснэгт 5.2.2. ГОЗБСАИ-ийн хувь, сүүлийн нэг жилд хоногдсон орон байрны төрлөөр

Сүүлийн 1 жилд амьдарсан орон байрны төрөл	Дулааны үед (4-10 сар)	Хүйтний үед (11-3 сар)
Орон сууцны орц, хонгил, хонгилд	83.5	92.5
Ах, эгч, дүү, найз нөхөд, танилынд/ өөрийнхөө гэрт	10.0	7.5
Нийтийн түрээсийн байранд	8.5	4.5
ТББ-ын түр хоноглох төв	0.5	0.0
Шөнө онгорхой байдаг үйлчилгээний газар /Нүхэн гарц	1.0	0.5
Вагончик, манаачийн шовгор	0.5	0.5
Бусад	1.5	1.5
Хариулагчдын тоо*	200	200

* хариулагч олон хариулт хэлж болох асуулт тул хариултын нийлбэр 100%-аас илүү.

Зураг 5.2.1 Орц, хонгилд амьдарч буй гэр оронгүй иргэдийн ахуйн нөхцлийн бодит байдал

Зураг 1 – Баянзүрх дүүргийн байрны хонгилд амьдарч буй хүүхдүүд.

Зураг 2 – Сонгинохайрхан дүүргийн байрны орцны жижүүр.

Судалгаанд оролцогчид орон сууцны орц, хонгилд амьдарч буй онцлогтой тул дийлэнх нь бүхий л улиралд төвлөрсөн шугамаас ундны усаа авч хэрэглэж байгаа ч усаа зөөвөрлөж хэрэглэдэг тул усны ариун цэврийн байдал алдагдах эрсдэл ч байгаа гэж болно. Энэхүү байдал улирлаараа онцын ялгаагүй байв.

5.3. Гэр оронгүй, зориулалтын бус сууцанд амьдардаг иргэдийн эрүүл мэндийн байдал


- ГОЗБСАИ-ийн 65.5% нь судалгааны үед биедээ ямар нэгэн өвчин зовиуртай байна.
- Зүрх судасны өвчлөл, зовиур ГОЗБСАИ-ийн дунд хамгийн өндөр (39.5%) бөгөөд эмэгтэйчүүдийн дунд (44.7%) эрэгтэйчүүдийнхээс 1.6 дахин илүү байна.
- ГОЗБСАИ-ийн осол гэмтэл авсан, одоогоор зовиуртай байгаа байдал (8%) байна.
- ГОЗБСАИ-ийн 12% хөгжлийн бэрхшээлтэй байгаа нь улсын дунджаас 4 дахин өндөр байна.
- ГОЗБСАИ-ийн 22% ковидоор өвчилсөн байсан ба 72% нь Ковид19-ын вакцины бүрэн тундаа хамрагдсан байна.
- ГОЗБСАИ-ийн 18.5% өвдсөн үедээ эмнэлэгт очдоггүй ба гол шалтгаан нь хаягийн бүртгэлгүй (18.9%), бичиг баримтгүй (16.2%), гадуурхдаг (13.5%) зэрэг болж байна.

ГОЗБСАИ-ийн дунд тохиолдож буй өвчлөлүүд дунд тэргүүлж буй таван өвчнийг авч үзвэл, зүрх судасны эрхтэн тогтолцооны өвчний үеийн зовиурууд болох хүзүү хөших, нүд бүрэлзэх, даралт ихсэх гэсэн шинж тэмдгүүд хамгийн түгээмэл илэрдэг (ГОЗБСАИ-ийн 39.5 хувь, эмэгтэйчүүдийн 44.7 хувь, эрэгтэйчүүдийн 27.1 хувьд) байна. Үүний дараа үе мөчөөр өвдөх, улайх, бадайрах, хавдах шинж тэмдгүүд бүхий үе мөчний өвчин зонхилж байгаа бөгөөд нийт судалгаанд хамрагдсан ГОЗБСАИ-ийн 27.5 хувьд (эмэгтэйчүүдийн 33.3 хувьд, эрэгтэйчүүдийн 3.6 хувьд) илэрсэн байна. Гуравдугаарт, толгой өвдөх зовиуртай хүмүүс ГОЗБСАИ-ийн 23 хувийг эзэлсэн ба эмэгтэйчүүд (26.2 хувь) энэ шинж тэмдгээр эрэгтэйчүүд (15.2 хувь)-ээс илүү зовиурлаж байна. Эдгээр нь ГОЗБСАИ-ийн хувьд хичнээн тогтмол нэг газар амьдарч байгаа хэдий ч нийтийн байр, орцны үүд, 00-ын өрөө, хонгил зэрэгт агаарын солилцоо бага, давчуу зайтай өрөөнд олуулаа байх зэргээс шалтгаалж тухтай, эрүүл, тайван нөхцөлд амарч унтаж чаддаггүйтэй холбоотой байж болно.

Хөгжлийн бэрхшээлийг тодорхойлох Вашингтон бүлгийн арга зүйгээр судалж үзэхэд, ГОЗБСАИ-ийн 12 хувь (эмэгтэйчүүдийн 13.5 хувь, эрэгтэйчүүдийн 8.5 хувь) ямар нэг хөгжлийн бэрхшээлтэй байгаа нь ХАОСТ-2020-оор мэдээлсэн улсын дунджаас 4 дахин өндөр байв. Хөгжлийн бэрхшээлийн төрлийг нарийвчлан үзэхэд ГОЗБСАИ-ийн дунд харааны хөгжлийн бэрхшээлтэй иргэд 4.5 хувь, сонсголын бэрхшээлтэй иргэд 2 хувь, хөдөлгөөний бэрхшээлтэй иргэд 5 хувь, сэтгэц оюуны бэрхшээлтэй иргэд 4 хувь, бие махбодын хөгжлийн бэрхшээлтэй иргэд 1 хувь, хэл ярианы хөгжлийн бэрхшээлтэй иргэд 2 хувь байна. Хүйсээр авч үзэхэд, хөгжлийн бэрхшээлд өртсөн байдал эмэгтэйчүүдийн дунд төрөл тус бүр дээр эрэгтэйчүүдтэй харьцуулахад бага зэрэг өндөр байсан. Судалгаанд оролцогчдоос **Ковид-19 халдварт өвчнөөр өвдсөн эсэхийг тодруулахад, ГОЗБСАИ-ийн 22 хувь нь ‘Тийм’ гэж хариулсан.** Насны хувьд харьцангуй залуу, хүйсийн хувьд эрэгтэйчүүд эмэгтэйчүүдээс илүү Ковид-19 өвчлөлд өртсөн байна. Судлагдсан ГОЗБСАИ-ийн 72 хувь бүрэн буюу 2-р тундаа хамрагдсан

байхад, 66 хувь нь 3-р тундаа хамрагдсан ба аль ч тундаа огт хамрагдаагүй хүн 3.5 хувь байв.

Зураг 5.3.4. ГОЗБСАИ-ийн хувь, Ковид 19-өөр өвчилсөн эсэх, насны бүлэг, хүйсээ



“Та өвдсөн үедээ ихэвчлэн ямар эмнэлэгт ханддаг вэ?” гэсэн асуултанд судалгаанд хамрагдсан ГОЗБСАИ-ийн 17 хувь нь “Өвдөөгүй” тул эмнэлэгт ханаагүй гэсэн бол 18.5 хувь нь “Эмнэлэгт очдоггүй”, давхардсан тоогоор 59.5 хувь нь өрх болон улсын эмнэлэгт, 10 хувь нь бусад газарт ханддаг гэж хариулжээ. ГОЗБСАИ дунд сүм, сүмийн эмнэлэг, Энэрэл эмнэлэгт ханддаг хүмүүс байгаагүй. Эмнэлэгт очдоггүй гэж хариулсан ГОЗБСАИ-ээс эмнэлэгт очдоггүй шалтгааныг асуухад давхардсан тоогоор “өөрийгөө эмчилдэг” гэж 57 хувь, хаягийн бүртгэлгүй гэж 18.9 хувь, бичиг баримтгүйн улмаас гэж 16.2 хувь, эмнэлэгт очихоор хүлээж авдаггүй, гадуурхагддаг гэж 13.5 хувь, мөнгөгүйн улмаас гэж 13.5 хувь, эрүүл мэндийн даатгалгүй гэж 10.8 хувь нь хариулжээ. Эдгээрээс, хаягийн бүртгэлгүй, бичиг баримтгүй, эмнэлэгт хүлээж авдаггүй зэрэг бэрхшээлийн улмаас зарим ГОЗБСАИ эмнэлгийн үйлчилгээ авч чадахгүй байгааг бодлого шидйвэр гаргагч, хэрэгжүүлэгчид анхаарах шаардлагатай гэж үзэж байна. Эмнэлгээр үйлчлүүлсэн, эмнэлэгт хандсан ГОЗБСАИ-ээс хамгийн сүүлд хэдэн сарын өмнө эмч, эмнэлгийн байгууллагаар үйлчлүүлснийг тодруулахад 60.5 хувь нь 1-3 сарын өмнө, 30.7 хувь нь 4-12 сарын өмнө, 8.9 хувь нь 12-с дээш сарын өмнө эмнэлгийн үйлчилгээ авсан байна.

5.4. Гэр оронгүй, зориулалтын бус сууцанд амьдардаг иргэдийн ажил эрхлэлт, орлого, амьжиргаа

Судалгаанд хамрагдсан ГОЗБСАИ-ийн ажил эрхлэлт, орлого, амьжиргааны байдал дараах гол онцлогтой байна:

- Орцны хонгил, хонгилд амьдардаг хөдөлмөрийн насны иргэдийн 85% ажил эрхэлдэг, 3% ажил эрхлээгүй ч ажил хайж байгаа, ажиллахад бэлэн, харин 12% нь ажиллах хүчнээс гадуурх хүн ам байна.
- ГОЗБСАИ-ийн дунд архинд донтох байдал, архинаас хамааралтай ажилгүйдэл маш бага (судалгааны явцад ганц хүн л архинаас болоод ажилгүй байгаа гэсэн) байна.
- Ажил эрхэлж буй ГОЗБСАИ-ийн ажлын дундаж орлого 495.0 мянган төгрөг гарсан нь Монгол Улсад мөрдөгдөж байгаа хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнд маш ойр, улсын дундаж цалингийн хэмжээнээс 2.9 дахин доогуур байна.
- Судалгаанд хамрагдсан ГОЗБСАИ-ийн ердөө 20% ганцаараа амьдардаг, дийлэнх нь гэр бүл, хамаатан садантайгаа хамт амьдарч байна.


Судалгаанд хамрагдсан ГОЗБСАИ-ийн эдийн засгийн идэвх харьцангуй өндөр гарчээ. Өөрөөр хэлбэл, ГОЗБСАИ-ийн 88 хувь ажиллах хүчинд (85 хувь нь хөдөлмөр эрхэлж байгаа, 3 хувь нь хөдөлмөр эрхлээгүй ч ажил идэвхтэй хайж, ажиллахад бэлэн байгаа), үлдсэн 12 хувь нь ажиллах хүчинд оролцоогүй, эдийн засгийн идэвхгүй хүмүүс байв. Энэхүү эдийн засгийн идэвхийн өндөр үзүүлэлт нь судалгаанд орцны жижүүрийн ажил эрхэлж буй хүмүүс сонгогдсонтой холбоотой. Сууц өмчлөгчдийн холбоо нь орон гэргүй хүмүүс, тэр тундаа эмэгтэйчүүдийг авч орчны жижүүр, үйлчлэгчээр ажиллуулах нь түгээмэл байдаг. Ингэснээр тэдгээр орон гэргүй иргэд ажиллангаа орцны жижүүрийн өрөөнд эсвэл хонгилд байрлан амьдрах боломжтой болдог ажээ. Эдийн засгийн идэвхийн ерөнхий түвшинд ГОЗБСАИ-ийн хүйсээр онцын ялгаагүй байна.

Зураг 5.4.1. ГОЗБСАИ-ийн хувь, эрхэлсэн ажлын төрлөөр



Ажил эрхэлсэн ГОЗБСАИ-ийн ажлын дундаж цалин/хөлсний орлого нь 495.0 мянган төгрөг байгаа нь (Зураг 5.4.2) Монгол Улсад мөрдөгдөж байгаа хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнд маш ойр, улсын дундаж цалингийн хэмжээнээс 2.9 дахин доогуур байна.

Зураг 5.4.2. ГОЗБСАИ-ийн дундаж орлого (мянган төгрөг), хүйс, боловсрол, насны бүлгээр



ГОЗБСАИ-ийн хувьд архины хамаарал бараг байхгүй ба ердөө 20 хувь ганцаараа амьдардаг бөгөөд дийлэнх (80%) нь нь гэр бүл, найз нөхөд, хамаатан садантайгаа амьдарч тэдэнтэйгээ олсон орлогоо хуваалцдаг ажээ.

5.5. Гэр оронгүй, зориулалтын бус сууцанд амьдарч буй иргэдийн хамрагдаж буй үйлчилгээ

- ГОЗБСАИ-ийн иргэний үнэмлэхтэй байдал ГОТИ-ийнхээс харьцангуй дээр байгаа ч 13.5% нь иргэний үнэмлэхгүй байна.
- ГОЗБСАИ-ийн дийлэнх эдийн засгийн албан салбарт ажил эрхэлдэг ч цалин орлого хүрэлцээгүй гол шалтгаанаар 46% нь эрүүл мэндийн, 65% нь нийгмийн даатгалд хамрагдахгүй байна.
- ГОЗБСАИ-ийн 39.0% нь төрийн ямар нэг тэтгэвэр, тэтгэмжид хамрагдаж байна.
- Төрийн байгууллагаас тусламж, дэмжлэг авах шаардлага гарахад ГОЗБСАИ хамгийн ихээр эрүүл мэнд, нийгмийн халамжийн байгууллагад ханддаг, тэндээсээ ч дийлэнх нь тусламж авч чадаж байна.
- ГОТИ-ийн нэн түрүүнд шийдвэрлэхийг хүсч байгаа асуудлууд нь “Өөрийн орон байр/газар/хашаатай болох” (85.5%), “хүүхдийн ирээдүйд санаа зовдог” (23.5%), “ажил, орлогоо нэмэгдүүлэх” (19.0%), “эрүүл мэндийн үйлчилгээнд хамрагдах” (10.0%), “мэргэжилтэй болох” (8.0%), бичиг баримттай болох (7.5%) зэрэг байна.

ГОЗБСАИ-ийн 13.5 хувь нь иргэний үнэмлэхгүй байна. Иргэдийн нийгмийн үйлчилгээнд хамрагдах гол нөхцөл нь иргэний үнэмлэхтэй, тухайн амьдарч байгаа газартаа бүртгэлтэй байх шаардлагатай. Судалгаанд хамрагдсан ГОЗБСАИ-ийн 86.5 хувь нь иргэний үнэмлэхтэй, 13.5 хувь нь иргэний үнэмлэхгүй байна. Ялангуяа, эрэгтэйчүүдийн иргэний үнэмлэхгүй гэж хариулсан байдал (20.3 хувь) эмэгтэйчүүдийнхээс 9.7 пунктээр өндөр байв. Мөн нас залуу, боловсролгүй, гэрлээгүй хүмүүсийн иргэний үнэмлэхгүй байдал (20.6-25.9 хувь) бусад бүлгийнхнээс илүү байлаа. Иргэний үнэмлэхгүй шалтгааныг авч үзвэл, гурван хүн тутмын нэг нь иргэний үнэмлэхээ гээгдүүлсэн, ойролцоогоор таван хүн тутмын нэг нь хулгайд алдсан, 11 хувь нь орон нутгаас хаяг шилжүүлээгүй гэсэн хариултыг өгчээ. Иргэний үнэмлэх огт авч байгаагүй, бусдад хадгалуулж байгаа гэж тус бүр нэг хүн хариулсан байна. Ер нь судалгааны явцад хороодын бүртгэлийн ажилтнууд коронагийн цар тахлын үед төрөөс иргэдэд үзүүлсэн мөнгөн тусламж нэмэгдсэнтэй холбоотойгоор иргэний үнэмлэхээ үрэгдүүлсэн иргэд дахин авахаар ирэх нь нэмэгдсэн тухай ярьж байсан. Гэхдээ шилжин ирэгчдийг аль болох түргэн үнэмлэхжүүлэх, улмаар нийгмийн үйлчилгээний гадуур орхигдуулахгүй байх тал дээр засаг захиргааны зүгээс илүү анхаарах шаардлагатай гэж үзэж байна.


Эрүүл мэндийн даатгалд хамрагдаж буй байдлыг авч үзэхэд, судалгаанд хамрагдсан ГОЗБСАИ-ийн 36 хувь нь төлдөггүй, 54 хувь нь төлдөг (23.5 хувь өөрөө төлдөг, 26.0 хувь төрөөс төлдөг, 14.5 хувь нь бусдаар төлүүлдэг) гэж хариулжээ. Судалгаанд хамрагдсан хөдөлмөрийн насны ГОЗБСАИ-ийн дийлэнх эдийн засгийн албан салбарт хөдөлмөр эрхэлж байгаа ч дөнгөж 60.0 хувь нь эрүүл мэндийн даатгалд хамрагдсан байна. Энэ нь 2010 онд хийгдэж байсан “Шилжих хөдөлгөөн ба хот, суурины аюултай бүс, оронд амьдарч буй гэр бүл” судалгааны ижил үзүүлэлт (31.2

хувь)-ээс ойролцоогоор хоёр дахин өндөр болсон байгаа нь өнгөрсөн арав гаруй жилийн хугацаанд ГОЗБСАИ-ийн эрүүл мэндийн даатгалд хамрагдалт сайжирсныг харуулж байна.

Хүн ам зүйн шинжээр нь авч үзэхэд, эрүүл мэндийн даатгалаа төлдөггүй байдал эрэгтэй хариулагчдын дунд эмэгтэйчүүдийнхээс 1.7 дахин өндөр байна. Эрүүл мэндийн даатгалд хамрагдаагүй 72 оролцогчдын шалтгааныг тодруулахад 62.5 хувь нь орлого бага, хэрэглээ хүрдэггүй, 16.7 хувь даатгал ашиглах шаардлага гараагүй, 15.3 хувь ажил, орлогогүй, 5.6 хувь бичиг баримтгүй ба бусад шалтгаанаар гэж тус тус хариулжээ

Нийгмийн даатгал нь тухайн хүний хувьд ирээдүйн буюу тэтгэврийн насанд орлогын баталгаа болж өгдөг ч судалгаанд хамрагдсан ГОЗБСАИ-ийн дөнгөж 35 хувь нь нийгмийн даатгалын шимтгэл төлдөг ажээ. Энэ үзүүлэлтийг “Шилжих хөдөлгөөн ба хот, суурины аюултай бүс, оронд амьдарч буй гэр бүл” судалгааны дүнтэй (23.6 хувь) харьцуулахад бага зэрэг өссөн байна. Хэдийгээр цөөн тоотой боловч дээд боловсролтой хоёр хүн тутмын нэг нь нийгмийн даатгалд хамрагджээ. Нийгмийн даатгалын шимтгэл төлөхгүй байгаа шалтгааныг авч үзвэл, эрэгтэй, эмэгтэй аль ч хүйсийн хувьд нэгдүгээрт, орлого бага хэрэглээ хүрдэггүй, хоёрдугаарт, төлөх шаардлагагүй, гуравдугаарт ажилгүй, орлогогүй гэсэн шалтгаан зонхилж байв.

Зураг 5.5.1 Нийгмийн даатгалын шимтгэл төлдөггүй ГОЗБСАИ-ийн хувь, шалтгаан, хүйсээр




Судалгаанд хамрагдсан ГОЗБСАИ-ийн 39.0 хувь нь төрөөс ямар нэгэн тэтгэвэр, тэтгэмж авч байна. Энэ байдал эмэгтэй (47.5 хувь), 60 ба түүнээс дээш насны (78.3 хувь), боловсролгүй (59.3 хувь) бэлбэсэн (68.6 хувь), шилжин ирэгч (40.3 хувь) ГОЗБСАИ-ийн дунд бусдаас өндөр байна. Тэдний авч буй тэтгэвэр, тэтгэмжийг төрлөөр нь задлан харвал, давхардсан тоогоор 82.1 хувь нь нийгмийн халамжийн сангаас, 44.9 хувь нь нийгмийн даатгалын сангаас ямар нэгэн тэтгэвэр, тэтгэмж авч байна. ГОЗБСАИ нийгмийн даатгалын сангаас хамгийн их хамрагдаж байгаа тэтгэвэр нь өндөр насны тэтгэвэр (37.2 хувь) бол нийгмийн халамжийн сангаас жирэмсэн эхийн тэтгэмж болон 0-3 насны хүүхэд асарсны тэтгэмж (14.1 хувь) байв.

Төрийн байгууллагаас тусламж, дэмжлэг авах шаардлага гарахад ГОЗБСАИ хамгийн ихээр эрүүл мэндийн байгууллагад ханддаг, тэндээсээ ч дийлэнх нь тусламж авч чадаж байна. Хариулагчдаас төрийн аль нэг байгууллагад хандаж тусламж хүсч байсан эсэхийг асуухад ойролцоогоор хоёр хүн тутмын нэг нь өрх, дүүргийн гэх мэт

улсын эмнэлэгт, таван хүн тутмын нэг нь халамжийн мэргэжилтэн/байгууллагад, 6 хүн тутмын нэг нь нийгмийн ажилтанд, 8 хүн тутмын нэг иргэний бүртгэлийн ажилтанд хандаж байжээ (Зураг 5.5.2).


Зураг 5.5.2 Төрийн аль нэг байгууллагад хандсан ГОЗБСАИ-ийн хувь, байгууллагын төрлөөр



Тэмдэглэл: хариулагч олон хариулт хэлж болох асуулт тул хариултын нийлбэр 100%-аас илүү.

ГОЗБСАИ-дэд нэн түрүүнд шийдвэрлэхийг хүсч байгаа ямар асуудал байгааг асуухад, давхардсан тоогоор “Өөрийн орон байр/газар/хашаатай болох” (85.5 хувь), “хүүхдийнхээ ирээдүйд санаа зовдог” (23.5 хувь) гэсэн хариултуудыг хамгийн их давтамжтай өгсөн байна.

Зураг 5.5.3 ГОЗБСАИ-ийн хувь, нэн түрүүн шийдвэрлэхийг хүсч буй асуудлын төрлөөр



Тэмдэглэл: хариулагч олон хариулт хэлж болох асуулт тул хариултын нийлбэр 100%-аас илүү.

5.6. Гэр оронгүй, зориулалтын бус сууцанд амьдардаг иргэдийн нийгмийн сүлжээ, хүрээлэл, өөрийгөө үнэлэх үнэлэмж

- ГОЗБСАИ-ийн орон гэргүй болсон шалтгаанд: орон нутгаас шилжин ирээд өөрийн гэсэн эзэмшил газар/байр олдоогүй, хангалттай цалин орлогогүй байдал 83%-ийг эзэлж байна.
- ГОЗБСАИ гэр бүлийнхэн, үр хүүхэдтэйгээ хамт СӨХ-оос хангаж байгаа орц, хонгил зэрэг зориулалтын бус сууцанд амьдарч байна.
- ГОЗБСАИ-ийн хамгийн ойр хүрээлэлд гэр бүл, ажлын хамт олон багтаж байна. Судалгаанд оролцогчдын 70.5% нь тусламж хэрэгтэй болсон үед аав/ээж/ах/эгч/дүү, эхнэр нөхөртөө тусламж, дэмжлэг үзүүлэхийг хүсэж хандан 97% нь хариу дэм тус авдаг ба үүнд ойр зуурын мөнгө, хүнс, гутал хувцасны тусламж ихэвчлэн багтаж байна.
- Судалгаанд оролцогчдын 86.7% нь өөрийн үнэлэмжийг дунджаас дээгүүр хэмээн тодорхойлсон байна.
- Судалгаанд оролцогчдын 85.5% нь архи огт хэрэглэдэггүй/онцгой тохиолдолд хэрэглэдэг нь архины хамааралгүйг харуулсан ба тодорхой үүрэг хүлээж, ажил эрхэлдэг учраас архидан согтуурах байдал нь харьцангуй бага байна.

5.6.1 ГОЗБСАИ-ийн нийгмийн харилцааны сүлжээ, хүрээлэл

ГОЗБСАИ-ийн гэр оронгүй болсон шалтгаан хувь хүний хүчин зүйсээс гадна бүтцийн хүчин зүйлстэй ихээхэн холбоотой байна. Судалгаанд хамрагдсан ГОЗБСАИ-ийн 83 хувь нь орон нутгаас шилжин ирээд газар/байр олдоогүй, хангалттай орлого, мөнгөгүй зэрэг бүтцийн хүчин зүйлстэй холбоотой шалтгаанаар гэр оронгүй, зориулалтын бус сууцанд амьдарч байна. Орон нутгаас Улаанбаатарт шилжин ирсэн зарим хүмүүст өөрийн гэсэн сууцгүй, эзэмшиж, өмчилсөн газаргүй байх эхний бэрхшээл, мөн ажилгүй орлогогүй, хангалттай хэмжээний цалингүй байдал тулгардгаас хямд төсөр байраар хангах боломжтой газруудын нэг болох СӨХ зэрэг байгууллагад ажилд орж, ажлын хамт олон, ах дүүгийн дэмжлэгээр амьжиргаагаа болон орон байрны асуудлаа шийдвэрлэдэг байна. Мөн СӨХ-д ажиллагчдын дунд гэр бүл салсан, таних туслах хүнгүй болон хүчирхийллийн улмаас гэр орноосоо дайжсан, нийгэмд гадуурхагдсан зэрэг шалтгаанаар СӨХ-д ажиллаж, орцны үүд, хонгилд амьдарч байгаа хүн ч байсан. Судалгааны явцад тэдгээр хүмүүсийн харьяалагдаж байгаа байгууллагын удирдлага, ажилтнуудын зүгээс ажлын байраар хангахаас гадна шаардлагатай тохиолдолд амьдрал ахуйд нь туслах материаллаг болон материаллаг бус дэмжлэгийг үзүүлсээр ирсэн талаар судалгаанд оролцогчид олонтаа дурьдаж байсан юм.

ГОЗБСАИ-ийн 85.1 хувь гэр бүл, үр хүүхэдтэйгээ амьдардаг ба ганцаараа амьдардаг байдал харьцангуй бага байв. Гэхдээ өөр нэг онцлог нь ГОЗБСАИ-ийн багагүй хувийг өрх толгойлсон эмэгтэйчүүд эзэлж байсныг анхаарах шаардлагатай гэж үзэж байна. Материаллаг болон сэтгэл зүйн тусламж авахдаа ихэвчлэн гэр бүл (70.5%), ажлын хамт олондоо ханддаг байна (27.5%).

ГОЗБСАИ-ийн бусдаас авдаг тусламж, дэмжлэгийг материаллаг болон материаллаг бус гэсэн хэсэгт хуваан үзвэл, материаллаг хэрэгцээний хувьд хамгийн их

авдаг тусламж ойр зуурын хэрэглээний мөнгө – 60 хувь, хоол хүнс – 52.9 хувь, гутал хувцас – 37.9 хувь эзэлж байна. Харин материаллаг бус дэмжлэгийн хувьд, хамгийн их авсан нь “бусадтай ярилцах” (70.7 хувь), “сэтгэл санааны дэмжлэг” (52.9 хувь) зэрэг байв. Гэр бүл, ажлын газрын хамт олон энэ бүлгийн хувьд хамгийн ойр дотны хүрээлэл байна.

5.6.2 ГОЗБСАИ-ийн өөрийгөө үнэлэх үнэлэмж

ГОЗБСАИ-ээр аливаа асуудалд хариу арга хэмжээ авах байдал, тэмцэх чадвар, сэтгэлийн тэнхээтэй байх зэрэг хувь хүний субъектив чадварыг нь сайн, дунд, муу, огт байхгүй гэсэн хувилбар бүхий хариултуудаас сонгуулан үнэлүүлэхэд, үзүүлэлт тус бүрт “сайн” үнэлгээ өгсөн. Өөрийн чадвартаа өгсөн үнэлгээг насны ангиллаар харьцуулбал, 19-35 насны залуучууд таван үзүүлэлтээр хангалттай түвшинд биш хэмээн 71.4 хувь буюу дийлэнх хариулсан нь анхаарал татаж байсан. Розэнбергийн “өөрийн үнэлгээг хэмжих сэтгэл зүйн тест”-ийн аргачлалаар судалж үзэхэд, ГОЗБСАИ-ийн өөртөө итгэх итгэл дунджаас дээгүүр байна. Тухайлбал өөртөө итгэлтэй байдал давамгайлсан өөрийгөө үнэлэх үнэлэмжийн оноо харьцангуй өндөр буюу 87.9 хувьтай байгаа бол ийм эмэгтэйчүүдийн хувь 86.2 хувь байна. ГОЗБСАИ-ийн өөрийгөө үнэлэх үнэлэмжийн оноог нас, боловсрол, хүүхэдтэй эсэх, гэр оронгүй байсан хугацаагаар харьцуулахад онцгой ялгаатай үр дүн харуулаагүй болно. Харин боловсролгүй бүлэгт хамааралтай иргэдийн 66.7 хувьд нь өөрийгөө үнэлэх үнэлэмжийн “дорд үзэх байдал” илүүтэй харагдаж байгаа бол бүрэн дунд боловсролтой иргэдийн бүлэгт хамрагдаж буй оролцогчдын 44.1 хувь нь дунджаас дээгүүр үнэлгээг сонгосон хариултыг өгчээ. Ерөнхийдөө, судалгаанд хамрагдсан ГОЗБСАИ-ийн хувьд өөртөө итгэх итгэл давамгайлж, өөрийн давуу болон сул талуудыг хангалттай үнэлж чаддаг, буруутай гэдгээ хүлээн зөвшөөрч чаддаг, бүтэлгүйтсэн тохиолдолд өөрийгөө хүндэтгэдэг, гэхдээ заримдаа өөрийгөө удаан хугацаагаар буруутгах хандлага байна. Архины хэрэглээ, хамаарлын хувьд ГОЗБСАИ-ийн хувьд хамааралтай хүн маш бага, 50.0 хувь нь огт хэрэглэдэггүй, 35.5 хувь нь онцгой тохиолдолд л хэрэглэдэг гэсэн. Ийнхүү 85.5 хувь нь архи огт хэрэглэдэггүй/онцгой тохиолдолд хэрэглэдэг нь архины хамааралгүйг харуулсан ба эдгээр иргэдийн хувьд орцны жижүүр, тодорхой ажил үүрэг хүлээж, ажиллаж байгаа учраас архидан согтуурах байдал нь харьцангуй бага, архины хамааралтай болсон гэж үзэхгүй байхад нөлөөлсөн.

6. ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТ, САНАЛ

Гэр оронгүй иргэд нь нийгмийн эмзэг бүлгийн нэг бөгөөд тодорхой анхаарал хандуулах шаардлагатай бүлэг гэдгийг хүлээн зөвшөөрдөг ч тэдний бодит нөхцөл байдлыг нарийвчлан судалсан судалгаа, гэр оронгүй иргэдэд чиглэсэн нотолгоонд үндэслэсэн бодлого, үйл ажиллагаа Монгол Улсад ихээхэн дутагдалтай явсаар ирсэн. Энэхүү мэдлэг, мэдээллийн дутагдалтай байдал нь “хөгжлөөс хэнийг ч орхигдуулахгүйгээр, хамгийн эмзэг бүлгийхэнд түрүүлж хүрч үйлчилж Тогтвортой хөгжлийн зорилтуудаа нотолгоонд суурилсан байдлаар хэрэгжүүлэх” Монгол Улсын хүчин чармайлтад нэг төрлийн саад бэрхшээл болж байна.

Энэхүү судалгаагаар Улаанбаатар хотын гэр оронгүй, тэнэмэл амьдралтай иргэдийн амьдралын нөхцөл байдал, хэрэгцээнд түргэвчилсэн байдлаар үнэлгээ хийлээ. Мөн орон сууцны орц, хонгил зэрэг зориулалтын бус сууцанд амьдарч буй иргэдийн хувьд тэднийг гэр оронгүй иргэд гэж томъёолох хууль эрх зүйн баримт бичиг Монгол улсад байхгүй ч олон улсын ойлголт, тодорхойлолт болон судалгааны хүрээ тодорхойлох уулзалтын үеэр талуудын тавьсан хүсэлтийн дагуу энэхүү судалгаанд тодорхой төлөөллийг хамруулан судалсан. Судалгааг хоёрдогч тоо баримт мэдээлэл, олон улсын сайн туршлагыг судлах, гэр оронгүй иргэд болон тэдэнтэй ажилладаг мэргэжилтнүүдээс тоон ба чанарын судалгааны аргаар мэдээлэл цуглуулж шинжлэх замаар гүйцэтгэсэн. тавьсан хүсэлтийн дагуу энэхүү судалгаанд тодорхой төлөөллийг хамруулан судалсан. Судалгааг хоёрдогч тоо баримт мэдээлэл, олон улсын сайн туршлагыг судлах, гэр оронгүй иргэд ба тэдэнтэй ажилладаг мэргэжилтнүүдээс тоон, чанарын судалгааны аргаар мэдээлэл цуглуулж шинжлэх замаар гүйцэтгэсэн. Судалгаанд 405 гэр оронгүй, тэнэмэл иргэд, 200 гэр оронгүй, зориулалтын бус сууцанд амьдарч буй иргэд хамрагдсан. Түүнчлэн, төрийн болон төрийн бус байгууллага, олон улсын байгууллага, тэнэмэл иргэдийн ар гэрийн төлөөлөл болсон 26 хүнтэй үндсэн мэдээлэгчийн ярилцлага, гэр оронгүй, тэнэмэл 37 хүнийг хамруулсан 7 фокус бүлгийн ярилцлага, 29 ганцаарчилсан гүнзгийрүүлсэн ярилцлагыг 2022 оны 2-4 сард хийж, чанарын ба тоон мэдээлэл цуглуулж, дүн шинжилгээ хийн тайланг боловсруулсан.

Гэр оронгүй иргэдийн хэрэгцээг үнэлэхдээ бид Масловын хэрэгцээний шатлалын онолд авч үздэг бүтцийн дагуу хэрэгцээг ангилан судалсан. Масловын онолоор, хүний хэрэгцээг таван төрөлд ангилан үздэг ба тэдгээр хэрэгцээ тодорхой дараалал, шатлалын дагуу үүсдэг (Маслов, 1954) гэж үздэг. Шатлал тус бүр дэх хэрэгцээг товчоор i) Физиологийн, ii) Аюулгүй байдлын, iii) Харьяалагдах, хайрлах буюу Нийгмийн, iv) Хүндлэлийн, v) Хувь хүний хөгжлийн буюу Өөрийгөө идэвхжүүлэх гэж нэрлэдэг. Физиологийн ба аюулгүй байдлын хэрэгцээнүүд нь хүний үндсэн хэрэгцээ бөгөөд тэдгээр нь хангагдаагүй цагт дээд түвшний гурван хэрэгцээг хангах сонирхол төдий л удаан өрнөдөггүй бөгөөд хэрэгцээний шатлалд доогуур байр эзэлж буй хэрэгцээнүүдийн хүч, нөлөөлөл бусдаасаа илүү байдаг. Ийм ч учраас физиологийн хэрэгцээ, аюулгүй байдал бүрэн хангагдаагүй өрх, гэр бүл, нийгэмд хүний эрхийн

зөрчил, гэмт хэрэг, хүчирхийлэл, хууран мэхлэлт, ялгаварлал, гадуурхал зэрэг сөрөг үзэгдлүүд оршдог гэж үздэг.

Судалгаагаар, гэр оронгүй, тэнэмэл иргэд болон зориулалтын бус сууцанд амьдарч буй иргэдийн хүн ам зүйн шинж байдал, ахуйн нөхцөл, эрүүл мэнд, эдийн засгийн байдал, нийгмийн үйлчилгээнд хамрагдах байдал, сэтгэл зүйн байдал, гэр оронгүй болоход нөлөөлсөн хүчин зүйлсийг судлах замаар гэр оронгүй иргэдийн хэрэгцээгээ хангах байдалд судлаачдын зүгээс үнэлэлт өгсөн. Судалгааны зорилтот бүлэг болох гэр оронгүй, тэнэмэл иргэд мөн гэр оронгүй, зориулалтын бус сууцанд амьдардаг иргэдийн шинж чанар, тулгамдаж буй асуудлууд ялгаатай тул судалгааны үр дүнг бүлэг тус бүрийн хувьд тусдаа бүлэг болгон боловсруулж, дүгнэлт хийлээ.

6.1 Дүгнэлт

Судалгааны анхдагч тоо мэдээллүүдэд хийсэн шинжилгээнээс бид гэр оронгүй иргэдийн нөхцөл байдлын талаар дараах ерөнхий дүгнэлтүүдийг хийж байна. Үүнд:

1. Монгол Улсын үндсэн хуульд заагдсан хүний суурь эрхүүд гэр оронгүй иргэдийн хувьд хангалтгүй хэрэгжиж байна.
 - a. Гэр оронгүй тэнэмэл иргэд хүний хамгийн суурь хэрэгцээ болох хоол хүнс, унтаж амрах, орон гэр, хувцас зэрэг материаллаг хэрэгцээгээ хангах төдий байна. Тэдний хувьд аюулгүй байдлын хэрэгцээ (нийгмийн хамгаалал, эрүүл мэнд, боловсрол, ажил эрхлэлт, өмч хөрөнгөтэй байх зэрэг), гэр бүл, найз нөхөд, ажлын хамт олон, нөхөн үржихүйн хостой байх буюу “харьяалагдах ба хайрлах” хэрэгцээ, бусдаар хүндэтгүүлэх, өөрийгөө хүндэлж итгэх зэрэг “хүндлэлийн” хэрэгцээ, хувь хүний хөгжил/өөрийгөө идэвхжүүлэх зэрэг дараагийн шатны хэрэгцээнүүд бүгд хангагдаагүй, хүнд нөхцөл байдалтай байна. Гэр оронгүй, тэнэмэл иргэдийн дийлэнхи архины хамааралтай, архинаас болж энэ амьдрал руу орсон иргэд байна.
 - b. Гэр оронгүй, зориулалтын бус сууцанд амьдарч буй иргэдийн хувьд хоол хүнс, хувцас зэрэг физиологийн хэрэгцээ, ажил орлоготой байх эдийн засгийн аюулгүй байдлын хэрэгцээ, нийгмийн хамгаалалд хамрагдах аюулгүй байдлын хэрэгцээ, харьяалагдах хэрэгцээ хангагдсан байдал нь тэнэмэл иргэдийнхээс арай дөнгүүр байгаа ч бусад аюулгүй байдлын хэрэгцээ, хүндлэлийн хэрэгцээ, өөрийгөө идэвхжүүлэх хэрэгцээ хангагдсан байдал тэнэмэл иргэдийнхтэй адил маш хангалтгүй байна. Орон нутгаас ирэгчид шилжих хөдөлгөөний бүртгэлгүй байдалтай холбоотойгоор ийнхүү зориулалтын бус сууцанд амьдрах нь элбэг байна.
2. Гэр оронгүй иргэдэд чиглүүлэн хэрэгжүүлж байгаа өнөөгийн бодлого, үйл ажиллагаа нь зөвхөн тэнэмэл иргэдэд “хүрч үйлчлэх”, “түр хоноглох” төдийгөөр хязгаарлагдаж байгаа бөгөөд “шилжилтийн”, “байршуулан эмчлэх” үйлчилгээнүүд бараг байхгүй байна. Ялангуяа гадны хяналтгүйгээр ГОТИ нь өөрийгөө арчилж бие даан амьдрах чадвар сул байгаа тул үйлчилгээнд тус онцлогийг харгалзах

шаардлагатай. ГОТИ-ийн асуудал нь зөвхөн цагдаа, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын хариуцах асуудал мэт хандлага нийгэмд байсаар байгаа нь эдгээр иргэдийн талаар дорвитой, салбар дундын уялдаа холбоог ханган ажиллахад хүндрэлтэй нөхцлийг бүрдүүлж байна. Түүнчлэн эмзэг бүлгийн, зориулалтын бус сууцанд амьдардаг иргэд өнөө маргаашийн физиологийн хэрэгцээгээ хангаж чадаж байгаа ч орлого нь цалингийн доод хэмжээнд маш ойр, олон талын эрх ашиг нь зөрчигдсөн, тэднийг тэнэмэл амьдрал рүү орохоос “урьдчилан сэргийлэх” бодлого, хөтөлбөр огт байхгүй тул тэнэмэл амьдрал руу орох эрсдэл өндөр байна. Цаашлаад олон улсад сайн туршлага болж байгаа “Эн тэргүүнд гэр орноор хангах” гэсэн ойлголт, үйл ажиллагааны чиглэл бүх шатандаа дутмаг байна.

6.2. Санал, зөвлөмж

Судалгааны үр дүн, гэр оронгүй иргэдтэй ажиллах олон улсын сайн туршлагууд, мэргэжилтнүүдтэй хийсэн зөвлөлдөх уулзалтуудаас гарсан санал, зөвлөмжид үндэслэн гэр оронгүй иргэдийн тулгамдсан асуудлыг шийдэх чиглэлээр хэрэгжүүлбэл оновчтой хэмээн дараах бодлого, үйл ажиллагааны саналуудыг дэвшүүлж байна.

1. Гэр оронгүй, тэнэмэл иргэдэд (ГОТИ) чиглэсэн бодлого, үйл ажиллагааны зөвлөмж, санал:

Зөвлөмж, санал	Хэрэгжүүлж эхлэх хугацаа		
	Богино хугацаа (2 жил дотор)-нд:	Дунд хугацаа (2.1-5 жилд)-нд:	Урт хугацаа (5-аас дээш жилийн дараа)-нд:
1. Гэр оронгүй тэнэмэл иргэдтэй холбоотой эрх зүйн орчинг боловсронгуй болгох:			
1.1 Байгалийн гамшиг, нийтийг хамарсан халдварт өвчин тархах эрсдэлтэй үед гэр оронгүй иргэд рүү онцгойлон чиглэсэн зарим хамгааллын арга хэмжээг гамшгийн үед төрөөс хэрэгжүүлдэг бодлого, үйл ажиллагааны баримт, бичгүүдэд тусган хэрэгжүүлдэг болох. Тухайлбал, бичиг баримтгүй, банкны дансгүй ГОТИ-дийг тусгайлан анхаарах.	+		
1.2 Нийгмийн халамжийн тухай хуулийн шинэчилсэн найруулгад гэр оронгүй, тэнэмэл иргэдийн асуудлаар тусгайлан бүлэг оруулах	+		
1.3 Гэр оронгүй, тэнэмэл амьдрал руу орохоос урьдчилан сэргийлэх болон бусад арга хэмжээний талаар стратеги, бодлого, хууль боловсруулж, хэрэгжүүлэх		+	
2. Гэр оронгүй тэнэмэл иргэдтэй холбоотой бодлого, зохицуулалтыг боловсронгуй болгох:			
2.1 ГОТИ-дэд үйлчилгээ үзүүлж буй салбарууд хоорондын үйл ажиллагааг уялдуулахын тулд нэгдсэн зохицуулалт хийх чиг үүрэг бүхий байгууллага/ нэгжийг тодорхой болгох, засгийн газар бүхлээрээ хамтран ажиллах (whole of government approach)		+	
2.2 Магадлан итгэмжлэгдсэн ТББ-аас ГОТИ-д үйлчилгээ үзүүлэхэд олгодог урсгал зардлын дэмжлэгийг жилийн 4 улиралд олгох	+		
2.3 Түр хоноглох байрууд ГОТИ-ийг байрлах хугацаанд нь газар тариалан, нийгэд тустай хөдөлмөр эрхлүүлэх зэргээр ажил мэргэжлийн дадал олж авах үйл ажиллагаануудын санаачлагыг төрөөс бодлогоор дэмжих, энэ чиглэлд тогтвортой ажлын байр бий болгох төр, иргэний нийгмийн байгууллага, хувийн хэвшлийг татварын урамшуулал болон бодлогоор дэмжих	+		
2.4 ГОТИ-ийн асуудлаар ажилладаг судалгааны болон бодлогын түвшинд ажилладаг олон улсын байгууллагуудтай хамтын ажиллагааг эхлүүлэх, туршлага судлах. Тухайлбал: Дэлхийн гэр оронгүйдлийн асуудлаарх хүрээлэн (Institute of Global Homelessness)	+		
2.5 Төрийн болон төрийн бус байгууллагаар дамжиж, үйлчилгээ авч бие даасан амьдралд шилжихэд бэлэн болсон ГОТИ-дэд хашаа газар, гэр оронтой болгох чиглэлээр тусгайлсан хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх. Тухайлбал: түрээсийн төлбөр бага, огт төлбөргүй улсын орон сууц, орон		+	

сууцны ваучер, хашаа газар олгох гэх мэт хөтөлбөрүүдийг судалж, хэрэгжүүлэх, “Гэртээ харих зам”-тай төстэй төсөл/хөтөлбөр санаачлан хэрэгжүүлэх.			
2.6 Төрийн болон төрийн бус байгууллагаар дамжиж, үйлчилгээ авч бие даасан амьдралд шилжсэн иргэдийг бие даан амьдрахад нь үргэлжлүүлэн дэмжих хөтөлбөрт хамруулах. Үүнтэй холбоотой бие даан амьдрах хөтөлбөр гаргаж хэрэгжүүлэх. Жишээ нь сэтгэл зүйч, нийгмийн ажилтан, наркологийн эмч зэрэг мэргэжлийн хүмүүсээс бүрдсэн баг бие даасан амьдралтай болсон иргэдтэй үргэлжлүүлэн ажилладаг, хяналт тавьдаг байх		+	
2.7 Ахмадын асрамж, халамж, сэтгэцийн асуудалтай иргэдийг хүлээн авдаг байгуулалагуудад гэр оронгүй иргэдийг шилжүүлэх тохиолдолд үйлчилгээ үзүүлж буй төрийн, төрийн бус байгууллагын мэргэжилтнүүдийн нөхцөл байдлын үнэлгээ, тодорхойлолтыг үндэслэн хүндрэл чирэгдэлгүй хялбар шилжүүлэх боломжтой процесс бий болгох.	+		
2.8 ГОТИ-тэй ажилладаг албан хаагчдын тогтвор суурьшилтай ажиллах нөхцлийг бүрдүүлэхийн тулд төрөөс хүнд нөхцөлд ажилласны нэмэгдэл цалин олгох, бие, сэтгэл зүйн эрүүл мэндийг дэмжих, хөнгөлөлттэй нөхцлийн орон сууцны хөтөлбөрт хамруулах, мэргэжил дээшлүүлэх хөтөлбөрт хамруулах, туршлага судлах гадаад дотоодын аялалд хамруулах гэх мэтээр амьдралын баталгааг дэмжсэн хөтөлбөр хэрэгжүүлэх.	+		
2.9 ГОТИ-ийн асуудлын талаар орон нутагт үүрэг өгөх, орон нутгийн төсөвт суулгах	+		
3. Гэр оронгүй тэнэмэл иргэдийн статистик, мэдээллийг сайжруулах:			
3.1 Гэр оронгүй, тэнэмэл иргэдийн тоо мэдээллийг албан ёсны статистикаар гаргадаг тогтолцоо бүрдүүлж, мэдээллэдэг болох, салбар дундын нэгдсэн мэдээллийн сантай болох		+	
3.2 Гэр оронгүй иргэдийн судалгааны ажлыг олон улсын тодорхойлолт, жишиг болохуйц стандартад нийцүүлэн, жишээлбэл “тухайн цаг мөч”-ид (point-in-time) буюу нэг шөнийн дотор тоолох судалгааны аргаар, тогтмол давтамжтайгаар төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллагуудын оролцоотойгоор зохион байгуулдаг болох; сэдэвчилсэн судалгаанууд хийх, тухайлбал ГОТИ-ийн дундаж наслалтын талаар.		+	
3.3 “Тухайн цаг мөч”-ийн судалгаанд судалгааны арга зүйгээр сургалтад хамрагдсан судлаачдыг сайн дурын үндсэн дээр оролцуулах замаар судалгааны хамрагдалт, мэдээллийн үнэн зөв байдал, чанарыг сайжруулах		+	
4. Иргэдийг гэр оронгүй тэнэмэл амьдралд орохоос урьдчилан сэргийлэх:			
4.1 Асрамжийн газар болон засан хүмүүжүүлэх газраас гарч буй иргэдийг нийгэмд бие даан амьдрахаар гарах үед гэр орон зэрэг суурь хэрэгцээгээ хангахад нь анхаарсан хөтөлбөр, төсөл санаачлан, хэрэгжүүлэх, гэр орон олгох	+		
4.2 Шилжин ирэгчдэд зориулсан үндсэн хэрэгцээгээ хангах, дасан зохицоход нь туслах чиглэлээр хэрэгжүүлдэг төсөл хөтөлбөрүүдийн талаар иргэдэд мэдлэг, мэдээлэл олгох, төслүүдийн үйл ажиллагааг өргөжүүлэх	+		

4.3 Орон нутгаас шилжин ирж буй бүртгэлгүй, ажилгүй, өрх тойлгойлсон, гэх мэт эмзэг бүлгийн иргэдийг олон нийт, нийгмийн ажилтнуудаар дамжуулан илрүүлэх, шилжин суурьшигчдад зориулсан тусгай хөтөлбөр/арга хэмжээнд хамруулах	+		
4.4 Орон гэргүй болоход нөлөөлж байгаа хувь хүн, гэр бүл, нийгмийн түвшний эрсдэлт хүчин зүйлсийг арилгах, таслан зогсооход чиглэсэн хариу арга хэмжээ интервенцийг хэрэгжүүлэх чадавхи, нөөцийг бий болгох, эко системийг өөрчлөх, илүү иргэдэд ээлтэй болгон сайжруулах. Жишээ нь, Гэр оронгүй амьдрах болсон шалтгаанууд дунд ойр дотны хүн нас барсан, туслах хүн байхгүй, ял шийтгэл эдэлж байсан тул гадуурхагдсан зэрэг асуудлууд байгаа тул нийгмийн хамгаалал, халамжийн чиглэлээр ажиллагчид эн тэргүүнд мэргэжлийн үүднээс анзааран, олж харж, зохих шатны арга хэмжээнүүд цаашид хэрэгжүүлдэг болох	+		
5. Гэр оронгүйдлийн асуудлаас урдчилан сэргийлэх болон ГОТИ-ийн нөхцөл байдлыг олон нийтэд ойлгуулах, гэр оронгүй иргэдтэй ажиллахад олон нийтийн оролцоог бий болгох :			
5.1 ГОТИ амьдралд орохоос урьдчилан сэргийлэх, сэрэмжлүүлэх, ГОТИ-ийн нөхцөл байдлыг таниулах агуулга бүхий мэдээллийн контентуудыг олон нийтэд хүргэх гэр оронгүй иргэдтэй ажиллахад олон нийтийн оролцоог бий болгох	+		
6. Гэр оронгүй, тэнэмэл иргэдэд үзүүлж буй одоогийн үйлчилгээг сайжруулах, өргөжүүлэх:			
6.1 ГОТИ-ийн илрүүлэг, түр хоноглох төвүүдийн үйл ажиллагааг тогтмолжуулах, шаардлагатай хүний нөөц, санхүүг шийдвэрлэх, ялангуяа сургалт, сэтгэл зүйн зөвлөгөө, сэтгэл засал, нийгэмшүүлэх чиглэлийн зардал байхгүй байгааг анхаарч нэмэгдүүлэх	+		
6.2 Нийгмийн ажилтан, сэтгэл зүйч, сайн дурынхан, нийгмийн үйлчилгээний хувийн хэвшлийнхний хамтарсан багийн үйлчилгээг стандартчилж, эдгээр хүмүүсийн зан үйл, дадал хэвшлийг өөрчлөхүйц үйлчилгээг мэргэжлийн түвшинд сайжруулах	+		
6.3 Хувь хүний үүрэг хариуцлага, амьдралын зорилго, итгэл найдварыг бий болгоход чиглэсэн сургалтын хөтөлбөрийг түр хамгаалах байрны хөгжлийн үйлчилгээний стандарт үйлчилгээ болгох	+		
6.4 Түр хоноглох байрууд зайлшгүй эмч, эрүүл мэндийн ажилтантай байх, ГОТИ-дэд эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, үйлчилгээг улирлын давтамжтай тогтмол хийх			
6.5 ГОТИ-дэд сэтгэл зүйн дэмжлэг, урт хугацааны хөтөлбөрийг хэрэгжүүлэхдээ стационар эмчилгээтэй хослуулах	+		
6.6 Түр хоноглох төвүүдэд очсон ГОТИ-дэд архинд донтох өвчний эмчилгээ, сэтгэц, сэтгэл заслын эмчийн зөвлөгөө сургалтыг тогтмол явуулах, энэ талын үйлчилгээг чанаржуулах, сэтгэл зүйч, сэтгэцийн эмч нарыг хүртээмжтэйгээр ажиллуулах.	+		
6.7 Архины хамааралтай, сэтгэц/сэтгэл зүйн өөрчлөлттэй иргэдтэй ажилладаг тул гэр оронгүй иргэдтэй ажилладаг албан хаагчдын ажилдаа ирж очих, ажлын байран дээрх аюулгүй байдлыг сайжруулахад чиглэсэн бодлого/үйл ажиллагаа хэрэгжүүлэх, журам гаргах.	+		

6.8 Түр хоноглох байрууд ГОТИ-ийг байрлах хугацаанд нь газар тариалан, нийтэд тустай хөдөлмөр эрхлүүлэх зэргээр ажил мэргэжлийн дадал олж авах, зах зээлд чиглэсэн үйлдвэрлэлд оролцуулах үйл ажиллагаануудыг санаачлан хэрэгжүүлэх.	+		
--	---	--	--

II. Гэр оронгүй, зориулалтын бус сууцанд амьдарч буй иргэдэд (ГОЗБСАИ) чиглэсэн бодлого, үйл ажиллагааны зөвлөмж, санал

Зөвлөмж, санал	Хэрэгжүүлж эхлэх хугацаа		
	Богино хугацаа (2 жил дотор)-нд:	Дунд хугацаа (2.1-5 жилд)-нд:	Урт хугацаа (5-аас дээш жилийн дараа)-нд:
1. ГОЗБСАИ-тэй холбоотой бодлого, зохицуулалтыг боловсронгуй болгох:			
1.1 ГОЗБСАИ-дийг хашаа газар, гэр оронтой болгох чиглэлээр тусгайлсан хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх. Тухайлбал: төвлөрсөн орон сууцуудыг барьж, ваучер болон бага түрээсээр гэр оронтой болгох, мөн огт төлбөргүй улсын орон сууц, хашаа газар олгох гэх мэт хөтөлбөрүүдийг судалж, хэрэгжүүлэх			+
1.2 ГОЗБСАИ-дийн дунд архины хамааралгүй, ажлаа хийгээд амьдарч байгаа иргэд дийлэнхийг эзэлж буй тул тэдний дунд “Эн тэргүүнд гэр орноор хангах” загварыг хэрэгжүүлэх		+	
1.3 Бодлого боловсруулагчид, хууль тогтоогчдын гэр оронгүй, гудамжинд гарах эрсдэлд байгаа ГОЗБСАИ-ийн асуудлуудын талаарх мэдээллийг нэмэгдүүлэх, асуудлыг шийдвэрлэх улс төрийн хүсэл, эрмэлзлийг бий болгох, сонгуулийн мөрийн хөтөлбөртэй нь уялдуулах	+		
1.4 Иргэдийг орон сууцжуулах бодлогод гэр оронгүй болох эрсдэлтэй бүлгийн хүн амд чиглэсэн эрсдэлээс сэргийлэх тодорхой заалтууд оруулах. Тухайлбал, орон нутгаас шилжин ирсэн, орцны жижүүр хийдэг зэрэг бүлгийг онцгойлон анхаарах.		+	
2. Зориулалтын бус сууцанд амьдардаг иргэдийн статистик, мэдээллийг сайжруулах			
2.1 Зориулалтын бус сууцанд амьдарч байгаа иргэдийн тоо мэдээллийг албан статистикаар, дотор нь төрлөөр нь ангилж гаргадаг тогтолцоо бүрдүүлэх	+		

2.2 Зориулалтын бус сууцанд амьдарч байгаа иргэдийг хамруулсан үндэсний хэмжээнд төлөөлөхүйц түүвэртэй судалгааны ажлыг явуулж, бодлого боловсруулалт, шийдвэр гаргалтад ашиглах.	+		
3. Зориулалтын бус сууцанд амьдарч буй иргэдийн нөхцөл байдал дордохоос урьдчилан сэргийлэх:			
3.1 Орц, хонгилд амьдарч буй иргэдийн ихэнх нь орон нутгаас шилжин ирэгчид байгаа тул нэгэн шилжин ирсэн иргэдэд зориулсан үндсэн хэрэгцээгээ хангах, дасан зохицоход нь туслах чиглэлээр хэрэгжүүлдэг төсөл хөтөлбөрүүдийн талаар иргэдэд мэдлэг, мэдээлэл олгох, төслүүдийн үйл ажиллагааг өргөжүүлэх	+		
3.2 Орон нутгаас шилжин ирж буй бүртгэлгүй, ажилгүй, өрх тойлгойлсон, гэх мэт эмзэг бүлгийн иргэдийг олон нийт, хороодын нийгмийн ажилтнуудаар дамжуулан илрүүлэх, нэгэнт шилжин ирсэн суурьшигчдад зориулсан тусгай хөтөлбөр/арга хэмжээнд хамруулах	+		
3.3 ГОЗБСАИ-ийн, ялангуяа орцны жижүүр иргэдийн цалингийн хэмжээг нэмэгдүүлж, нийгмийн даатгал, эрүүл мэндийн даатгалдхамрагдалтын байдлыг төрийн татаасаар зохицуулж, сайжруулах	+		
4. Зориулалтын бус сууцанд амьдардаг иргэдийн нийгмийн хамгаалал, баталгааг дээшлүүлэх:			
4.1 Зориулалтын бус сууцанд амьдардаг тул хаяг шилжүүлэлт, шилжих хөдөлгөөний бүртгэл хийлгэх боломжгүй байгааг анхаарах.	+		
4.2 Хаяггүйгээс болж урьдчилан сэргийлэх үзлэг, нарийн мэргэжлийн эмнэлгийн тусламж үйлчилгээг үнэ төлбөргүй авах боломжгүй, нийгмийн даатгал, халамжийн үйлчилгээнд хамрагдаж чадахгүй байгааг анхаарч, хаягжуулах арга хэмжээ авах	+		
4.3 Дийлэнх нь тогтсон ажил, орлоготой тул зориулалтын бус сууцанд амьдардаг иргэдэд зориулсан бага хүүтэй, эсвэл хүүгүй бага талбайтай орон сууцны зээл, хашаа/газар, түрээсийн сууцанд хамруулах боломжуудыг судалж хэрэгжүүлэх, ингэхдээ сарын хүү болон зээлийн төлбөр, эсвэл, түрээсийн төлбөр нь тухайн өрхийн сарын орлогын 30%-аас хэтрэхгүй байхаар зохицуулах	+		
4.4 Бага төлбөртэй, түрээсийн, ваучераар олгох орон байр, хашаа/газар нь сургууль, цэцэрлэг, төрийн үйлчилгээ гэх мэт нийгмийн дэд бүтэцтэйгээ ойрхон, хүнд ээлтэй орчинд баригдах	+		

7. АШИГЛАСАН МАТЕРИАЛ

Монгол хэлээр:

- АХБ. (2019). Иргэний Улсын бүртгэлийн мэдээллийн санд бүртгэлгүй, оршин суугаа газрын тодорхой хаяггүй, иргэний бичиг баримтгүй иргэдийг бүртгэлжүүлэх арга зам
- Мягмар, О. (2016). Хүний хөгжлийн сэтгэл зүйн лекцүүд (дөрөв дэх удаагийн хэвлэл). Улаанбаатар, Монгол Улс: Ган принт.
- НДЕГ. (2022). Аж ахуйн нэгж, байгууллагын ажиллагчдын сарын дундаж цалин. https://1212.mn/tables.aspx?tbl_id=DT_NS0_0400_021V1&SOUM
- НХТТ. (2021). НХТТ-ийн үйл ажиллагааны тайлан 2021.
- ХНХСИ. (2017). Нийгмийн халамжийн зарим үйлчилгээний нөлөөллийн шинжилгээ, Улаанбаатар хот.
- ХНХЯ. (2010). Шилжих хөдөлгөөн ба хот, суурины аюултай бүс, оронд амьдарч буй гэр бүл. (НХХЯ-ны хэвлэгдээгүй судалгааны тайлан)
- ҮСХ. (2018). “Хөдөлмөрийн статистик”-ийн мэдээллийн эх үүсвэр, ойлголт, тодорхойлолт. https://1212.mn/BookLibraryDownload.aspx?url=Хүн_амын_ажил_эрхлэлтийн_статистикийн_мэдээний_тухай_тооцох_арга_зүй.pdf&ln=Mn
- ҮСХ, ХНХЯ (2019). Хөдөлмөр эрхлэлтийн статистикийн үзүүлэлтийг тооцох аргачлал. Улаанбаатар хот.
- ҮСХ. (2020). Хүн ам, орон сууцны 2020 оны улсын ээлжит тооллогын нэгдсэн дүн. Улаанбаатар: “Би Си Ай” ХХК.
- ҮСХ. (2021). Ажилгүйдлийн түвшин (хувиар), хүйс, насны бүлэг, хөгжлийн бэрхшээлтэй иргэдээр. https://www.1212.mn/tables.aspx?tbl_id=dt_ns0_0400_049v1&indicator

Англи хэлээр:

- Aleksandra Tkaczyk, Z. B. (2010). Cultural dimensions analysis.
- Asian Development Bank (2019). Ways to register unregistered population in the national registration system.
- Bassuk, Ellen L, Carmela J DeCandia, Alexander Tsertsvadze, and Molly K Richard. (2014). The Effectiveness of Housing Interventions and Housing and Service Interventions on Ending Family Homelessness: a Systematic Review. *The American Journal of Orthopsychiatry* 84 (5): 457-474.
- Fry C, L. K. (2016). A systematic review of cognitive functioning among young people who have experienced homelessness, foster care and of poverty. *Child Neuropsychol.* .
- Harman, G. (2008). *On the Horror of Phenomenology: Lovecraft and Husserl.*
- Hazel R. Markus, S. K. (2008). Culture and the Self.

- Institute of Global Homelessness. (2017). An Overview of Global Homelessness and Strategies for Systemic Change.
- Keane CA, M. C. (2016; 61:43–54.). Is there a complex trauma experience typology for Australians experiencing extreme social disadvantage and low housing stability? *Child Abuse Negl.*
- McAll, Christopher, Pierre-Luc Lupien, Marcio Gutiérrez, Aimée Fleury, Amélie Robert, and Antoine Rode. (2013). “Existing” in the eyes of others: the impact of the Montreal At-Home project after 18 months, from the participants’ point of view. *CREMIS/Centre affilié universitaire CSSS Jeanne-Mance*. 11 10.
- Medicine Hat Community Housing Society. (2014). At Home In Medicine Hat: Our Plan to End Homelessness. Homelessness & Housing Development.
- Mzwandile A. Mabhala, B. E. (2016). Understanding the determinants of homelessness through examining the life stories of homeless people and those who work with them: A qualitative research protocol,.
- NSO. (2020). Population and Housing Census of Ulaanbaatar.
- Social Insurance General Office. (2022). MONTHLY AVERAGE WAGES AND SALARIES, by region, aimag and the Capital, by gender, quarter, year. https://1212.mn/tables.aspx?tbl_id=DT_NSO_0400_021V1&SOUM
- Spector, P. E. (2004). Industrial and organizational Psychology. New York.
- Suzanne Speak (2019). “The state of homelessness in developing countries” presentation at the expert group meeting on affordable housing and social protection systems for all to address homelessness, Nairobi.
- Tsemberis S, et al (2015). One-year outcomes of a randomized controlled trial of housing first with ACT in five Canadian cities. *Psychiatr Serv*.
- UN HABITAT. (2005). Хотын орон сууцны санхүүжилт: Хүн амын суурьшлын талаарх глобал илтгэл – 2005. Найроби
- UN-Habitat (1996-2006). Global Urban Indicators Database
- World Bank (2012). Proposed services for the homeless in Mongolia. <https://ighomelessness.org/igh-announces-the-first-global-framework-on-homelessness/>
- 58th UN Commission for Social Development (2020). Affordable housing and social protection systems for all to address homelessness. //documents-dds-ny.un.org/doc/UNDOC/LTD/N20/037/48/PDF/N2003748.pdf?OpenElement

8. ХАВСРАЛТ

А. Судалгааны зөвлөлдөх семинарт оролцогчид (2022/02/16)

№	Төрөл	Байгууллагын нэр	Оролцогчийн нэр	Албан тушаал
1	Төрийн байгууллага	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам	н. Балжирцог	Нийгмийн халамжийн асуудал хариуцсан мэргэжилтэн
2		Үндэсний статистикийн хороо	Т. Алтансүх	Хүн ам, орон сууцны тооллогын товчооны дарга
3			Ш. Ариунболд	Тооллого, өгөгдөл шинжилгээний газрын дарга
4			Баянгол дүүргийн ЗДТГ	н. Батцэцэг
5		Хан-Уул дүүргийн ЗДТГ	н. Баярбат	Мэргэжилтэн
6		Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газар	н. Азжаргал	Хараа хяналтгүй хүүхдийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн
7			н. Бадамцэцэг	Мэргэжилтэн
8			н. Саранхүү	Мэргэжилтэн
9		Цагдаагийн зрөнхий газар	н. Жаргалсайхан	Цагдаа
10			н. Нарантуяа	Цагдаа
11		Нийслэлийн нийгмийн халамжийн газар	Л. Дуламсүрэн	Дарга
12			н. Мягмарсайхан	Мэргэжилтэн
13		Энэрэл эмнэлэг	Г. Одончимэг	Эмчилгээ эрхэлсэн дарга
14			н. Энхтуяа	Хүний нөөцийн мэргэжилтэн
15		Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар	А. Чимэгсүрэн	Халамжийн үйлчилгээний хэлтсийн дарга
16		Сонгинохайрхан дүүргийн нийгмийн халамжийн хэлтэс	Г. Баянбаатар	ОНОТХҮ-ий мэргэжилтэн
17		Баянгол дүүргийн нийгмийн халамжийн хэлтэс	Б. Шүрэнцэцэг	ОНОТХҮ-ий мэргэжилтэн
18		Сүхбаатар дүүргийн нийгмийн халамжийн хэлтэс	Ц. Батбаяр	ОНОТХҮ-ий мэргэжилтэн
19		Баянзүрх дүүргийн нийгмийн халамжийн хэлтэс	Б. Ган-Очир	ОНОТХҮ-ий мэргэжилтэн
20		Чингэлтэй дүүргийн нийгмийн халамжийн хэлтэс	Х. Цэрмаа	ОНОТХҮ-ий мэргэжилтэн
21		Хан-Уул дүүргийн нийгмийн халамжийн хэлтэс	Б. Хүрэлцэцэг	ОНОТХҮ-ий мэргэжилтэн
22	Олон улсын байгууллага	Азийн хөгжлийн банк	Л. Итгэл	Нийгмийн салбарын Ахлах мэргэжилтэн
23	Олон улсын шилжилт хөдөлгөөний байгууллага	Ю. Оюунхишиг	Төслийн үндэсний мэргэжилтэн	
24	Улсын түр хоноглох байр	НЗД-ын дэргэдэх Нийгмийн хамгааллын тусгай төв	Ш. Мөнхцэцэг	Захирал
25			н. Пүрэвсүрэн	Мэргэжилтэн
26			н. Буянсүрэн	Сэтгэл зүйч
27			н. Болдцэцэг	Сэтгэл зүйч
28			н. Нэргүй	Ахлах арга зүйч
29			н. Нандинцэцэг	Ахлах нийгмийн ажилтан

30	ТББ-ын түр хоноглох байр	Өлзийт асар ТББ	н. Баянмөнх	Захирал
31		Ганц зам итгэл ТББ	н. Алтантуул	Захирал
32		Найдварын өргөө ТББ	н. Уртнасан	Захирал
33		Сэргэлт өөд ТББ	н. Алтантуяа	Менежер
34		Заюу тайж ТББ	н. Тамара	Захирал
35			н. Пүрэвдорж	Менежер
36		Тэр гэрэл төв ТББ	н. Бадамсүрэн	Захирал
37			н. Муяа	Нийгмийн ажилтан
38		“Help International Mongol” ТББ	А. Амартүвшин	Менежер
39		Бат гэрэлт ирээдүй ТББ	Г. Роза	Захирал
40		Титэм констракшн ТББ	н. Буяннэмэх	Захирал

Б. Тоон судалгааны асуулгын хуудас

Азийн Хөгжлийн Банк

Судалгаа, үнэлгээний Когнос Интернэйшнл ХХК

**УЛААНБААТАР ХОТЫН ОРОН ГЭРГҮЙ ИРГЭДИЙН НӨХЦӨЛ БАЙДЛЫГ ҮНЭЛЭХ
ТҮРГЭВЧИЛСЭН ТООН СУДАЛГААНЫ АСУУЛГА**

Судалгаа нөхөх заавар:

1. Асуулгыг судалгааны мэдээлэл цуглуулах сургалтад хамрагдсан судлаач судалгаанд сонгогдсон иргэнтэй ярилцах замаар нөхнө (иргэдээр өөрсдөөр нь судалгааг нөхүүлэхгүй).
2. Тоогоор кодлосон хариулттай асуултад “зөвхөн нэг” хариулт сонгож харгалзах кодыг дугуйлна; үсгээр кодлосон хариулттай асуултад нэг болон түүнээс олон хариулт сонгож болно; дөрвөлжин нүдэнд тоон хариулт болон код нөхнө.
3. Сонгосон хариултын ард сум байвал, зарим асуултыг алгасч заасан дугаар бүхий асуулт руу шилжин асууна.

№	Асуулт	Хариултын код	Алхам
ТАНИХ ХЭСЭГ			
1	Дүүргийн нэр, код:	нэр: <input type="text"/>	
2	Хорооны нэр, код:	нэр: <input type="text"/>	
3	Хариулагчийн байрлаж буй газар/байгууллагын нэр, хаяг:	а) Нэр: б) Хаяг:	
4	Судлаачийн нэр, код:	нэр: <input type="text"/>	
5	Ярилцлага авсан сар, өдөр:	а) сар: <input type="text"/> б) өдөр: <input type="text"/>	
6	Хариулагчийн дугаар:	дугаар: <input type="text"/>	

Сайн байна уу? Намайг.....гэдэг. Би "Когнос Интернэйшнл" ХХК-д судлаачаар ажилладаг. Бид Улаанбаатар хот дахь орон гэргүй иргэдийн нөхцөл байдлыг судалж байна. Судалгааны үр дүнг орон гэргүй хүмүүсийн асуудлаар Монгол Улсын Засгийн газраас явуулах шаардлагатай үйл ажиллагааны чиглэлийг тодорхойлоход ашиглах юм. Таныг манай судалгаанд оролцож тусална уу хэмээн урьж байна.

7	Та 18 нас хүрсэн үү?	тийм <input type="checkbox"/> үгүй <input type="checkbox"/>	1 2 → дуусгах
8	Та сүүлийн үед янз бүрийн газруудад хэч хоноглоон амьдарсан уу? Тийм бол хэдий хугацаагаар амьдарсан бэ?	тийм 1 хүргэлх сар <input type="checkbox"/> 1-3 сар <input type="checkbox"/> 3-аас дээш сар <input type="checkbox"/> үгүй <input type="checkbox"/>	1 2 3 4 } 11
9	Та сүүлийн үед түр хоноглох/ байрлуулах төвүүдэд байрлан амьдарсан уу? Тийм бол хэдий хугацаагаар амьдарсан бэ?	тийм 1 хүргэлх сар <input type="checkbox"/> 1-3 сар <input type="checkbox"/> 3-аас дээш сар <input type="checkbox"/> үгүй <input type="checkbox"/>	1 2 3 4 } 11
10	Та сүүлийн үед орчны хонгил, подваль, вагончик, албан байгууллагын өрөө, траншейн, зах зэрэг газарт тогтмол байрлан амьдарсан уу? Тийм бол хэдий хугацаагаар амьдарсан бэ?	тийм 1 хүргэлх сар <input type="checkbox"/> 1-3 сар <input type="checkbox"/> 3-аас дээш сар <input type="checkbox"/> үгүй <input type="checkbox"/>	1 2 3 4 → дуусгах
11	<i>Та судалгаанд сайн дурын үндсэн дээр хамрагдах эрхтэй ба нэрээ хэлэхгүй, зарим хариулахыг хүсэхгүй асуултдаа хариулахгүй байж болно. Мөн Та орон байртай холбоотой үйлчилгээ авч байгаа бол Таны судалгаанд хамрагдах, үгүй нь уг үйлчилгээнд нөлөөлөхгүй. Таны өссөн хувийн мэдээллийн нууцыг бид хариуцлагатай хамгаалах ба тайландаа хувийн чанартай мэдээлүүдийг бусад хүмүүсийнхтэй нийлүүлэн ерөнхий байдлаар тайлагнах болно. Ярилцлага ойролцоогоор минут үргэлжилнэ. Та судалгаанд оролцохыг зөвшөөрч байна уу?</i>	тийм <input type="checkbox"/> үгүй <input type="checkbox"/>	1 2 → дуусгах

1. ХАРИУЛАГЧИЙН ХҮН АМ ЗҮЙН ШИНЖ БАЙДАЛ

101	Хариулагчийн хүйс	эрэгтэй <input type="checkbox"/> эмэгтэй <input type="checkbox"/>	1 2
102	Та хэдэн оны хэдэн сард төрсөн бэ?	төрсөн он <input type="text"/>	

Азийн Хөгжлийн Банк		Судалгаа, үнэлгээний Когнос Интернэйшнл ХХК	
		төрсөн сар	<input type="text"/>
		мэдэхгүй/ санахгүй байна	98
		татгалзсан/ хариулаагүй	99
103	Та Улаанбаатар хотод төрснөөсөө хойш амьдарч байна уу, шилжиж ирсэн үү?	төрснөөсөө хойш	1 → 105
		өөр газар байнга амьдарч байгаад буцаж ирсэн	2
		өөр газраас шилжиж ирсэн	3
104	Та хамгийн сүүлд хэдэн онд Улаанбаатар хотод шилжин ирсэн бэ?	шилжин ирсэн он	<input type="text"/>
		мэдэхгүй/ санахгүй байна	98
		татгалзсан/ хариулаагүй	99
105	Та Улаанбаатар хотын аль нэг дүүрэг, хороонд хаягийн бүртгэлтэй юу?	тийм	1
		үгүй	2
		мэдэхгүй/ санахгүй байна	98
		татгалзсан/ хариулаагүй	99
106	Хэрэв тийм бол аль дүүрэг, хороонд бүртгэлтэй вэ?	дүүрэг	<input type="text"/>
		хороо	<input type="text"/>
107	Та эзэмшсэн боловсролынхоо дээд түвшинг хэлнэ үү?	боловсролгүй	1
		бага	2
		суурь	3
		бүрэн дунд	4
		техникийн болон мэргэжлийн	5
		тусгай мэргэжлийн дунд	6
		дипломын дээд	7
		бакалаврын дээд	8
		магистр	9
		доктор	10
108	Та энгийн өгүүлбэр уншиж, бичиж чадах уу?	тийм	1
		үгүй	2
109	Та энгийн нэмэх, хасах үйлдлийг хийж, тоо бодож чадах уу?	тийм	1
		үгүй	2
110	Та гэрлэлтийн байдлаа хэлнэ үү?	огт гэрлээгүй	1
		гэрлэсэн: батлуулсан	2
		гэрлэсэн: батлуулаагүй	3
		тусгаарласан	4
		цуцалсан	5
		бэлтгэсэн	6
111	Та хүүхэдтэй юу?	тийм	1
		үгүй	2 → 201
112	Тийм бол хэдэн хүүхэдтэй вэ? Үүнээс хэд нь 16 ба түүнээс доош насны хүүхэд вэ?	a) Нийт хүүхдийн тоо	<input type="text"/>
		b) 16 ба түүнээс доош насны хүүхдийн тоо	<input type="text"/>
113	Таны хүүхэд тантай хамт байдаг уу?	тийм	1
		үгүй	2
2. ОРОН ГЭР, АХУЙН НӨХЦӨЛ			
201	Та хэзээнээс хэсүүчлэн/ зориулалтын бус сууцанд амьдарч байна вэ?	он	<input type="text"/>
		мэдэхгүй/ санахгүй байна	98
		татгалзсан/ хариулаагүй	99
202	Та хэсүүчлэн/зориулалтын бус сууцанд амьдрахаас өмнө хэнийд/хаана амьдарч байсан бэ?	анхнаасаа орон гэргүй байсан	1
		өөрийн хашаа, гэрт	2
		өөрийн хашаа, байшинд	3
		өөрийн орон сууцанд	4
		түрээсийн орон сууц, хашаа байшин/гэрт	5
		хамаатан, таниланд түрээсгүй	6
		асрамжийн газарт	7
		засан хүмүүжүүлэх газарт	8
		бусад	9
		(бичих)	
203	Таны орон гэргүй/зориулалтын бус сууцанд амьдрах болсон шалтгаан юунаас болж үүсэвч бэ?	гэр бүл салсан	A
		гэр бүл дэх хүчирхийллээс болж гэрээс дайжсан	B

Азийн Хөгжлийн Банк		Судалгаа, үнэлгээний Когнос Интернэйшнл ХХК	
		гэр бүл дэх хэрүүл маргаан, таарамжгүй байдал	C
		архивд донтож гэрээсээ хөөгдсөн/явсан	D
		гэртээ гадуурхагдаж хөөгдсөн	E
		орон нутгаас шилжин ирээд газар/байр олдоогүй	F
		хангалттай орлого, мөнгөгүй	G
		хүмүүст хууртаж, залилуулсан	H
		өр зээлийн дарамт	I
		байгалийн гамшигт өртсөн	J
		ял шийтгэл эдэлж байсан тул гадуурхагдсан	K
		туслах танил тал байхгүй	L
		бусад	M
		(бичих)	
204	Сүүлийн 1 жилд дулааны ба хүйтний үед ихэвчлэн хаана (ямар байр, саванд) амьдарсан бэ?	а. дулааны үед (4-10 сар)	б. хүйтний үед (11-3 сар)
	Улсын түр хоноглох/байрлуулах төвийн байр/гэр	A	A
	ТББ-ын түр хоноглох/байрлуулах байр/гэр	B	B
	Ах, эгч, дүү, найз нөхөд, танилындаа	C	C
	Сүмийн байр/гэр/хашаа	D	D
	Нийтийн байранд	E	E
	Орон сууцны орчны хонгил, подвальд байрлан амьдардаг	F	F
	Орон сууцны орц, подваль хэсэж хоноглодог	G	G
	Гудамж, задгай газарт гадаа хонох	H	H
	Зуслангийн задгай/ээгүй байранд	I	I
	Траншейн	J	J
	Хогийн цэг	K	K
	Вагончик, манаачийн шовгор	L	L
	Голын эрэг, ууланд	M	M
	Нүхэн гарц	N	N
	Шөнө онгорхой байдаг үйлчилгээний газар	O	O
	Бусад	P	P
		(бичих)	
205	Хоол, ундандаа хэрэгтэдэг усаа дулааны ба хүйтний үед хаанаас авдаг вэ?	а. дулааны үед (4-10 сар)	б. хүйтний үед (11-3 сар)
	Төвлөрсөн ус хангамжийн шугам сүлжээ	A	A
	Хамгаалагдсан гүний худаг	B	B
	Төвлөрсөн шугам сүлжээнд холбогдсон нийтийн ус түгээх байр	C	C
	Төвлөрсөн шугам сүлжээнд холбогдоогүй нийтийн ус түгээх байр	D	D
	Хамгаалагдсан гар худаг	E	E
	Хамгаалагдсан булаг, шанд	F	F
	Хамгаалагдаагүй гүний худаг	G	G
	Хамгаалагдаагүй гар худаг	H	H
	Хамгаалагдаагүй булаг, шанд	I	I
	Зөөврийн усны үйлчилгээ	J	J
	Савласан ус	K	K
	Хурын ус	L	L
	Усны ил эх үүсвэр (гол, горхи, булаг шандны задгай ус)	M	M
	Орон сууц, подвалийн төвлөрсөн шугамаас	N	N
	Айл, өрх, албан байгууллагын төвлөрсөн шугамаас	O	O
	Бусад	P	P
		(бичих)	
206	Та одоогоор түр хоноглох/байрлуулах төв (улсын юмуу ТББ-ын)-өөр үйлчлүүлж байна уу?	тийм (Шалгах: Асуулт 9=1:3 бол Тийм) үгүй	1 2 → 209
207	Та энэ төвдөө тасралтгүй хэдэн сар амьдарч байна вэ?	сар	<input type="text"/> <input type="text"/> <input type="text"/>
		мэдэхгүй/ санахгүй байна	98
		татгалзан/ хариулаагүй	99

Азийн Хөгжлийн Банк		Судалгаа, үнэлгээний Когнос Интернэйшл ХХК					
208	Одоо үйлчлүүлж буй “гүр хоноглох/байрлуулах төв”-ийн дараах үйлчилгээнд Та хэр сэтгэл хангалуун байна вэ? (3=сайн; 2=дунд; 1=муу)	сайн	дунд	муу	мэдэхгүй	тухайн үйлчилгээ үзүүлэхгүй	301
	1 Хоол цайны тоо, хэмжээ	3	2	1	9	0	
	2 Хоол, цайны чанар	3	2	1	9	0	
	3 Орон байрны тохь тух	3	2	1	9	0	
	4 Ариун цэврийн үйлчилгээ	3	2	1	9	0	
	5 Эрүүл мэндийн үйлчилгээ	3	2	1	9	0	
	6 Соёлын, мэдээллийн үйлчилгээ	3	2	1	9	0	
	7 Сэтгэл зүйн эмчилгээний үйлчилгээ	3	2	1	9	0	
	8 Ажилд зуучлах	3	2	1	9	0	
	9 Ажил, мэргэжлийн дадал олгох	3	2	1	9	0	
	10 Ажилтнуудын зан, харилцаа	3	2	1	9	0	
	11 Ажилтнуудын мэргэжлийн ур чадвар	3	2	1	9	0	
209	Та сүүлийн 7 хоногийн хэдэн өдөр нь халуун хоол идсэн бэ?	тоо: <input type="text"/>					
210	Та сүүлийн 7 хоногийн хэдэн өдөрт нь зориулалтын бие засах газарт орсон бэ?	тоо: <input type="text"/>					
211	Та сүүлийн 7 хоногийн хэдэн шөнө нь бүтэн нойртой, тухтай унтаж амарсан бэ?	тоо: <input type="text"/>					
212	Та сүүлийн 7 хоногийн хэдэн өдөрт нь гараа савандаж угаасан бэ?	тоо: <input type="text"/>					
213	Та сүүлийн 1 сард хэдэн удаа халуун усанд орсон бэ?	тоо: <input type="text"/>					
3. ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙДАЛ							
301	Танд одоогоор дараах өвчин/ зовиур байна уу? <i>(Мөр баалтыг цохож асууна уу)</i>	толгой өвдөх A хүзүү хөших, нүд бүрэлзэх, даралт ихсэх, багасах B шүд, буйл өвдөх C байнга ханиах (цэртэй, цэргүй), цээжээр өвдөх D элэг, цөс, ходоод өвдөх E шээс дусагнах, дүлж шээх, шээх үед шээс тасалдах, шээхэд хүндрэлтэй өвдөх, цустай шээх F арьс загатнах, хавдах, улаах, гүвдрүү, тууралт, идээ бээр гарах G бэлэг эрхтнээс хурц үнэр гарах, загатнах, шингэн, үү, ургацаг гарах H үе мөчөөр өвдөх, улайх, бадайрах, хавагнах I осол, гэмтэл авсан эсэх (одоогоор зониуртай) J бусад зодуулж, гэмтэх K бусад L одоогоор өвчин, зовиур байхгүй M <i>(бичих)</i>					
302	Танд юм харахад хүндрэлтэй байдаг уу?	хүндрэлгүй 1 бага зэргийн хүндрэлтэй 2 их хүндрэлтэй 3 огт чаддаггүй 4					
303	Танд юм сонсоход хүндрэлтэй байдаг уу?	хүндрэлгүй 1 бага зэргийн хүндрэлтэй 2 их хүндрэлтэй 3 огт чаддаггүй 4					
304	Танд алхах болон шатаар өгсөх/ дээшээ авирахад хүндрэлтэй байдаг үү?	хүндрэлгүй 1 бага зэргийн хүндрэлтэй 2 их хүндрэлтэй 3 огт чаддаггүй 4					
305	Танд аливаа зүйлийг санах, анхаарлаа төвлөрүүлэхэд хүндрэлтэй байдаг уу?	хүндрэлгүй 1 бага зэргийн хүндрэлтэй 2 их хүндрэлтэй 3 огт чаддаггүй 4					

Азийн Хөгжлийн Банк		Судалгаа, үнэлгээний Когнос Интернэйшнл ХХК	
306	Танд бие даан усанд орох, хувцсаа өмсөх зэргээр өөрийгөө арчлахад хүндрэлтэй байдаг үү?	хүндрэлгүй	1
		бага зэргийн хүндрэлтэй	2
		их хүндрэлтэй	3
		огт чаддаггүй	4
307	Танд бусадтай ярилцахад ямар нэгэн хүндрэл гардаг үү?	хүндрэлгүй	1
		бага зэргийн хүндрэлтэй	2
		их хүндрэлтэй	3
		огт чаддаггүй	4
308	Та өвдсөн үедээ ихэвчлэн ямар эмнэлэгт ханддаг вэ?	эмнэлэгт очдоггүй	1
		өвдөөгүй	2
		өрхийн эмнэлэг/улсын эмнэлэг	3
		хувийн эмнэлэг	4
		Энэрэл эмнэлэг	5
		бусад	6
309	Эмнэлэгт ханддаггүй шалтгаанаа хэлнэ үү?	өөрийгөө эмчилдэг	A
		бичиг баримтгүй	B
		эрүүл мэндийн даатгалгүй	C
		хялгийн бүртгэлгүй	D
		мөнгөгүй	E
		хүлээн авдаггүй/гадуурхагддаг	F
		сүмийн эмч, ажилтан тусалдаг	G
		түр хоноглох, байрлуулах төвийнхөн тусалдаг	H
		лам, бөө, бариач тусалдаг	I
		бусад хүн тусалдаг	J
		бусад	K
		310	Та хамгийн сүүлд хэзээ эмч/эмнэлгийн байгууллагаар үйлчлүүлсэн бэ? (хэдэн сарын өмнө орсныг тодруулан сараар нөхөж бичнэ)
мэдэхгүй/ санахгүй байна	98		
татгалзсан/ харгуулаагүй	99		
311	COVID-ын вакциндаа хамрагдсан уу? I, II, III тун хийлгэсэн үү?	I тун	A
		II тун	B
		III тун	C
312	Та COVID-оор өвдсөн үү?	тийм	1
		үгүй	2
4. АЖИЛ ЭРХЛЭЛТ, ОРЛОГО, ҮНДСЭН ХЭРЭГЦЭЭ			
401	Орон гэргүй болохоос өмнө Та орлого олох үүднээс хувиараа юмуу албан байгууллагад ажил, хөдөлмөр эрхэлж байсан уу?	тийм	1
		үгүй	2
